

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-97
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	98-230
1.“Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	100-101
2.“Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	101-118
3.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	118-124
4.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	124-145
5.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	145-151
6.Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	152
7.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	152-160
8.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	160-165
9.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	165-168
Хуралдаан санал хураалтаар үргэлжлэв.	168-198
10.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/	198-230

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
06 дугаар сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Заяабал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Ч.Анар, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Г.Лувсанжамц, А.Ундраа, С.Эрдэнэбат;
Чөлөөтэй: Б.Мөнхсоёл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;
Тасалсан: О.Цогтгэрэл.*

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Уянгахишиг, П.Батчимэг нар хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт орсон “Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Уянгахишиг, П.Батчимэг нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	7
Бүгд:	20

65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. “Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Заяабал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Заяабал: “Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	10
Бүгд:	20

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Заяабал: “Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх заалтыг зөрчсөн тул дээрх санал хураалтыг хүчингүй болгов.

Б.Заяабал: “Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Заяабал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Г.Уянгахишиг, Р.Сэддорж, Б.Жаргалан, М.Мандхай, Г.Очирбат нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Заяабал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Л.Гантөмөр нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал “Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Улсын Их Хурлын гишүүдийн саналыг тусгаж, тогтоолын төслийг дахин хэлэлцэх нь зүйтэй тул хойшлуулав./16:09/

Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбаагийн Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Очирбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нар үг хэлэв.

Хуралдаан 16 цаг 33 минутаас 17 цаг 27 минутад завсарлав.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу нэгтгэж явуулахаар хойшлуулав./17:29/

Дөрөв.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн дэд сайд Б.Хулан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга С.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, мөн газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, С.Нацагдорж, П.Чанцалдулам, Д.Энхдалай, В.Эрдэнэцогт, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер Б.Саруул, ахлах аудитор У.Оюунхүү, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Амартүвшин, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Б.Баяр-Эрдэнэ, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мягмарнаран, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Цагаанхүү, Харилцаа холбоо, кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Гүнсэнхорол, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Батбаяр, Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сумъяа, шинжээч С.Лхам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга П.Баянбаатар, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Билгүүн, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Ц.Борхүү, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн дарга Э.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Г.Очирбат, Б.Жавхлан, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Б.Жавхлан нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын ахлах референт Б.Төрбат, Монгол Улсын Ерөнхий сайдын Засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх С.Тэнгис, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын хуулийн менежер Б.Ариунзаяа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш С.Батбаяр, Г.Давааням, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, мөн компанийн ерөнхий аудитор О.Баярмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, М.Мандхай нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш С.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу нэгтгэж явуулахаар хойшлуулав./19:04/

Зургаа.Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын ахлах референт Б.Төрбат, Монгол Улсын Ерөнхий сайдын Засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх С.Тэнгис, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын хуулийн менежер Б.Ариунзаяа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш С.Батбаяр, Г.Давааням, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, мөн компанийн ерөнхий аудитор О.Баярмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу нэгтгэж явуулахаар хойшлуулав./19:05/

Долоо.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны Дэд

ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал Б.Мөнхзул, Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцны бодлогын зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Хуулийн хэлтсийн дарга Э.Батболд, Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал Б.Мөнхзул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Р.Сэддорж нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу нэгтгэж явуулахаар хойшлуулав./19:33/

Найм.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал Б.Мөнхзул, Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцны бодлогын зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Хуулийн хэлтсийн дарга Э.Батболд, Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Г.Очирбат нарын тавьсан асуултад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал Б.Мөнхзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу нэгтгэж явуулахаар хойшлуулав./19:54/

Ес.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга П.Баянбаатар, мөн газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Кадастрын хэлтсийн дарга М.Энхтуяа, Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу нэгтгэж явуулахаар хойшлуулав./20:03/

Хуралдаан 20 цаг 03 минутаас 20 цаг 57 минутад завсарлав.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Б.Заяабал: 1.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал:

Б.Заяабал: 1.Төслийн нэрийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй” гэснийг “засаглалыг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Дээрх 1, 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан энэ хууль болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тухай бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах “Тайлбар” хэсэг нэмэх:

“Тайлбар: -Энэ хуульд заасан “үр ашигтай байх” гэж арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд оруулсан капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс өндөр түвшинд байхаар үйл ажиллагаа явуулж, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхийг ойлгоно. Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд нийтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, боломжит бага зардлаар үзүүлэхийг ойлгоно.

Тайлбар: -Энэ хуульд заасан “зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх” гэж хуульд зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй, төрийн болон орон нутгийн өмчийг зах зээлийн үнэ, нөхцөлөөс доогуур ашиглахгүй, зөвшөөрөл, эрх олгох болон төрийн худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэхгүй, дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн нийтлэг журмаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдөхгүй байхыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “, хэлбэр” гэснийг хасаж, 6.1.2, 6.2.2 дахь хэсгийн “34-өөс” гэснийг “гуравны нэгээс” гэж тус тус өөрчилж, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны, эсхүл нийтийн үйлчилгээний гэж ангилах бөгөөд энэ талаар тухайн компанийн дүрэмд тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулж болно:

8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, санхүүгийн үр ашиггүй нөхцөлд нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялгийг ашиглах;

8.1.3.зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, харилцаа холбоо, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжих, холбогдох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.5.хуульд тусгайлан заасан бол” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	8
Бүгд:	23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Ногдол ашгийн бодлого

16.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашгийн бодлоготой байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

16.2.Ногдол ашгийн бодлогод тухайн компанийн үйл ажиллагааны зорилго, хөрөнгө оруулалтын бүтэц, мөнгөн урсгалын онцлогоос хамааруулан дараах хэлбэрийн аль нэг, эсхүл хосолсон хэлбэрийг тусгана:

16.2.1.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.2.2.жил бүр хөрөнгө оруулагчид тогтвортой хуваарилахаар урьдчилан тогтоосон ногдол ашгийн зорилтот хэмжээ болон түүнд тооцох өсөлтийн хувиар;

16.2.3.аудитлагдсан санхүүгийн тайланд туссан хувь нийлүүлсэн хөрөнгө, чөлөөт мөнгөн урсгал, хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг, эсхүл хүү, татварын өмнөх ашиг зэрэг санхүүгийн үзүүлэлтээр урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр;

16.2.4.бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалж урьдчилан тооцоолоогүй орлого бий болсон тохиолдолд түүний урьдчилан тогтоосон тодорхой хувиар.

16.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн ногдол ашгийн бодлогод дараах зарчим, шаардлагыг тусгана:

16.3.1.ногдол ашгийг аудитлагдсан санхүүгийн тайланг үндэслэн тогтоох;

16.3.2.компанийн батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.3.3.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалт, зориулалтын хөрөнгийг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.3.4.компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагааг дордуулахгүй байх;

16.3.5.бусад хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.

16.4.Арилжааны зорилготой төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь ногдол ашгийн бодлогод заасны дагуу ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан компанийн тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээ, ногдол ашиг тооцох хэлбэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилготой компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, эсхүл энэ хуулийн 16.8-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.7.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.6-д заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.8.Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.5, 16.6-д заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно:

16.8.1.компанийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд цэвэр ашгаас дахин хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага үүссэн;

16.8.2.компанийн ногдол ашгийн бодлогод тусгасны дагуу хуримтлагдсан алдагдлыг нөхөх шаардлага үүссэн;

16.8.3.эрх бүхий байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг хангуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлага үүссэн.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах баримт бичгийг хавсаргана:

16.9.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;

16.9.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;

16.9.3.зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоолол.

16.10.Энэ хуулийн 16.9-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.4.Төлөөлөн удирдах зөвлөлгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд түүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “авлигын,” гэсний дараа “нийтийн албаны ашиг сонирхлын,” гэж нэмж, 24.1.2 дахь заалтын “тухайн салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд” гэснийг “төрийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд таваас доошгүй, орон нутгийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд хоёроос доошгүй жил” гэж, “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, 24.1.6.а. заалтын “өөрөө” гэснийг “дангаараа” гэж өөрчилж, “дангаараа болон” гэснийг хасах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.4, 24.5, 24.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“24.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь сондгой тооны таваас ес хүртэлх гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн болон орон нутгийн төлөөллийн нэг гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал болгож, томилогдсон этгээд байна.

24.6.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй бол хоёроос, 7 гишүүнтэй бол гурваас, 9 гишүүнтэй бол дөрвөөс доошгүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүнийг Компанийн тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “нийтийн зориулалттай дэд бүтэц,” гэснийг хасаж, “таваас илүүгүй сондгой тооны” гэснийг “таван” гэж, “хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны албан хаагч, хоёроос доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байж болно” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.8.Энэ хуулийн 24.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн төлөөллийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох бөгөөд төрийн захиргааны албан хаагч нэрээ дэвшүүлж, сонгон шалгаруулалтад оролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийн бодлогыг батлах, хэрэгжүүлэх;

29.6.2.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 8

Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Дээрх 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.7, 29.8, 29.9 дэх хэсэг нэмэх:

“29.7.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компанийн ашиг сонирхол, хуульд заасан үүрэг, хариуцлагыг тэргүүн ээлжид баримтлах бөгөөд энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн баримтлах эсэхийг бие даан шийдвэрлэнэ.

29.8.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг баримталсан, эсхүл баримтлаагүй нь түүнийг Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөх, үндэслэл болохгүй.

29.9.Энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч бүртгэж хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 8

Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 36.1.2 дахь заалтын “3” гэснийг “хоёр” гэж, 36.1.3 дахь заалтын “өргөдөл” гэснийг “хүсэлт” гэж, 36.1.13 дахь заалтын “3 жил дараалан хангалтгүй” гэснийг “хоёр жил дараалан өөрчлөлттэй” гэж тус тус өөрчилж, 36.1.4 дэх заалтын “ноцтой” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, 36.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Энэ хуулийн 36.1.1-д заасан тохиолдол төрийн болон орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний компани, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төслийн санхүүжилттэй компанид хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 7

Бүгд: 23

69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа баталгаажуулах, хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэнэ.

37.5.Төрийн аудитын байгууллага тайлант жилийн улсын хөгжлийн бодлого, тухайн жилийн санхүүгийн төлөв байдал, урьдчилсан судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж, өмнөх оны гүйцэтгэсэн аудитын дүн, хүний нөөц, төсөв, санхүү бусад хүчин зүйлд үндэслэн санхүүгийн тайлангийн аудит хийх төрийн болон орон нутгийн өмчийн компанийг сонгон гүйцэтгэнэ.

37.6.Төрийн аудитын байгууллагаас энэ хуулийн 37.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдэд тавигдах тусгай шаардлагыг Засгийн газарт хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Дээрх 16 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.7, 37.8 дэх хэсэг нэмэх:

“37.7.Энэ хуулийн 37.6-д заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.8.Энэ хуулийн 7.1-д заасан өмчлөлийн бодлогод нийцүүлэн тухайн жилд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх төрийн өмчит компанийн жагсаалт болон аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийг хасаж, 41.4 дэх хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “04 дүгээр сарын 15-ны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

19. Төслийн 44 дүгээр зүйлийн дугаарыг 43 болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43 дугаар зүйл.Энгийн хувьцаа нэмж гаргах, арилжих

43.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани энэ хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн энгийн хувьцаа нэмж гаргаж, дараах хэлбэрээр үнэт цаасны зах зээлд санал болгож хөрөнгө оруулалт татаж болно:

43.1.1.хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгох;

43.1.2.хуульд заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгүүлэн санал болгох;

43.1.3.хуульд заасан бусад хэлбэрээр дотоодын болон гадаадын үнэт цаасны зах зээлд санал болгох.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

43.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг дээшлүүлэх;

43.3.2.компанийн засаглал, ил тод байдал, хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах;

43.3.3.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, Тэтгэврийн сан болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх;

43.3.4.газрын хэвлийн баялгийн өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд хүртээмжтэй, ил тод, зах зээлийн зарчмаар хүргэх;

43.3.5.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.

43.5.Энэ хуулийн 43.3.1-43.3.5-д заасан зорилго болон 43.6.2-т заасан зарчмыг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгохдоо хөрөнгө оруулагчийн төрлийг дараах байдлаар дангаар болон хослуулан тогтоож болно:

43.5.1.Монгол Улсын иргэн;

43.5.2.мэргэжлийн хөрөнгө оруулагч;

43.5.3.стратегийн хөрөнгө оруулагч;

43.5.4.бусад хөрөнгө оруулагч.

43.6.Энэ хуулийн 43.4-т заасны дагуу хөрөнгө оруулагчдын төрөл, захиалгын доод болон дээд хэмжээ, хуваарилалтын аргачлал, төвлөрлөөс сэргийлэх арга хэмжээ болон шаардлагатай тохиолдолд нэг этгээдийн эзэмших дээд хэмжээг төрийн өмчит компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.7.Төрийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгоход дараах зарчмыг баримтална:

43.7.1.шударга, ил тод оролцох боломж олгох;

43.7.2.дангаар болон холбогдох этгээдэд хувьцаа эзэмшлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх;

43.7.3.хувьцааны үнэ, үнэлгээ, эрсдэл, ногдол ашиг, саналын эрх, хязгаарлалт, захиалгын нөхцөлийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх;

43.7.4.захиалга давсан тохиолдолд хувьцааг урьдчилан зарласан журмын дагуу хуваарилах;

43.7.5.Монгол Улсын иргэний хувьцааг богино хугацаанд төвлөрүүлэн худалдан авах, дамжуулан худалдах, зах зээлийг урвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэх зохицуулалт тогтоох;

43.7.6.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан бусад энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хуульд өөрөөр заагаагүй бол хангах.

43.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг дараах хэлбэрээр арилжиж, худалдаж болно:

43.8.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн энгийн хувьцааг хоёрдогч зах зээл дээр арилжих;

43.8.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт, хэлэлцээрийн аргаар стратегийн хөрөнгө оруулагчид худалдах;

43.8.3.өөр төрлийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр солих;

43.8.4.хуульд заасан бусад.

43.9.Энэ хуулийн 43.8-д заасны дагуу төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн хувиар гаргана.

43.10.Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, арилжих шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

43.11.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ур чадвартай ажилтныг тогтвортой ажиллуулах, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн ажилтнуудад опцион эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж болно.

43.12.Энэ хуулийн 43.10-д заасан хөтөлбөрийн нөхцөл, эзэмшлийн дээд хэмжээ, шилжүүлэх хязгаарлалт, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн саналын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3, 51.4, 51.5 дахь хэсэг нэмэх:

“51.3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг энэ хуулийн 8.3-т заасан үндэслэлд нийцүүлэх арга хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

51.4.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг 2028 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

51.5.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 8.3-т заасан зөвшөөрөл хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:

Б.Заяабал: 1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагааны зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.4.Компанийн гүйцэтгэх удирдлагыг хуульд заасан шаардлагыг хангасан хараат бус, мэргэжлийн багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг өөрчлөн найруулах санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед дэмжигдсэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 5

Бүгд: 23

78.3 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 7

Бүгд: 23

69.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Б.Заяабал: 1.Орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 9

Бүгд: 23

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Б.Заяабал: 1.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Наранбаатар, Ц.Туваан, А.Ундраа, Б.Уянга, Б.Мөнхсоёл, Д.Үүрийнтуяа, Р.Эрдэнэбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.40 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.40.“гэрээ байгуулах боломжтой талбай” гэж энэ хуулийн 4.1.39-д заасан гэрээг байгуулах боломжтой тусгай зөвшөөрөл олгогдоогүй, ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаагүй, сонгон шалгаруулалтын талбайд хамрагдаагүй, эсхүл сонгон шалгаруулалтыг хоёр удаа зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй, геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэхээр тогтоосон талбайг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.39 дэх заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн, 15^{1.7.5} дахь заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Үндэсний геологийн албанд” гэж, 15^{1.3} дахь хэсэг, 15^{1.4} дэх хэсэг, 15^{1.8} дахь хэсэг, 15^{1.9} дэх хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “Үндэсний геологийн албатай” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.2.4} дэх заалтын “чадавхыг тусгасан” гэсний дараа “геологийн суурь судалгаа, эрлийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.7.6} дахь заалт, 15^{1.7.7} дахь заалт, 20.5.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.9} дэх хэсгийн “15^{1.1}-д” гэснийг “4.1.40-д” гэж, “мэдээлнэ” гэснийг “мэдээлж байна” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19^{1.2.1} дэх заалтын “гэрээний хэрэгжилтийн тайлан” гэснийг “гэрээ дүгнэсэн акт” гэж, 19^{1.2.3} дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл авах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19^{1.8} дахь хэсгийн “зөвшөөрөл олгосон” гэсний дараах “даруйд энэ” гэснийг хасаж, “нийтэд ил тод” гэсний дараах “мэдээлнэ” гэснийг “, нээлттэй мэдээлж байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 27.1.15 дахь заалтын “ирүүлэх” гэснийг “хүргүүлэх” гэж өөрчилж, 27.1.16 дахь заалтын “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 28¹, 29¹ дүгээр зүйлийн гарчгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 28^{3.4} дэх хэсгийн “28^{3.4}” гэснийг “28^{3.3}” гэж, 29^{1.1} дэх хэсгийн “хаягдал чулуулгийн” гэснийг “хаягдлын” гэж тус тус өөрчилж, 28^{1.1} дэх хэсгийн “зөвшөөрөлтэй” гэсний дараа “хуулийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, уг саналаар санал хураалт явуулаагүй болно.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 42^{1.1} дэх хэсгийн “олон нийтэд” гэснийг “олон нийт, орон нутгийн иргэдэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23

69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.20.Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах эрдэс, элементээс бусад эрдэс, элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахгүй бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах эрдэс, элементийн төрөл, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64^{1.1} дэх хэсгийн “саад учруулахыг” гэсний өмнө “хууль бусаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.2 дахь хэсгийн “19^{1.5}-д заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн” гэснийг “19^{1.4}-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан талбайн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийн 2 дахь баганын “Ашигт малтмалын нэр төрөл” гэснийг “Бүтээгдэхүүний нэр төрөл” гэж, 5 дахь баганын “ам.доллар” гэснийг “ам.доллороор” гэж, 6 дахь баганын “Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь” гэснийг “Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “байгаль орчны менежментийн” гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.32.“чухал ашигт малтмал” гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Б.Уянга нар үг хэлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.32.“чухал ашигт малтмал” гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.43 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч” гэж, мөн хэсгийн “гаргаж болно” гэснийг “гаргана” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.9.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нь 25-3000 гектар бол 20000 нэгж, 3000 гектараас дээш бол 20000 нэгж дээр нэг гектар тутамд 7 нэгж нэмж тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29¹ дүгээр зүйл, 29² дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.1 дэх хэсгийн “35 нэгж” гэсний дараа “, 6-9 дэх жилд 50 нэгж” гэж нэмэх, 5 дахь заалтын 33.1.5 дахь заалтын “6 дахь жилд” гэснийг “7-9 дэх жилд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Наранбаатар, Р.Батболд нарын гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Р.Батболд, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нар үг хэлэв.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлээс “4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний,” гэснийг “засагт

нөлөөлөхүйц,” гэж” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

4.1.12.“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.29” гэснийг “11.1.28” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “1 удаа” гэснийг “2 удаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлээс “15 дугаар зүйл,” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “16 дугаар” гэсний өмнө “15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “мэдэгдэж бүртгүүлнэ” гэснийг “мэдэгдэнэ” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг хууль зүйн техникт нийцүүлж, өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, 1.1/Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19^{1.4} дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “нь” гэж нэмэх.

1.2/Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.3.2} дахь заалтын “талаар” гэснийг “тухай” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “ажил” гэснийг “ажлыг” гэж, 10 дахь заалтын 29^{2.1.2} дахь заалтын “талаар санал дүгнэлт” гэснийг “тухай санал, дүгнэлт” гэж, 12 дахь заалтын 35.13 дахь хэсгийн “байгууллагуудын” гэснийг “байгууллагын” гэж, 13 дахь заалтын 42^{1.2.2} дахь заалтын “байгууллагуудтай” гэснийг “байгууллагатай” гэж, 2, 4 дүгээр зүйлийн “16 дугаар зүйл” гэснийг “16 дугаар зүйлийн гарчгийн” гэж тус тус өөрчлөх.

1.3/Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 48.15 дахь хэсгээс “тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 32.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нар үг хэлж, Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 14
Бүгд: 23
39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.21 дэх хэсгийн “бүртгэж, хяналт тавина” гэснийг “бүртгэнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн үг хэлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 15
Бүгд: 23
34.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.35, 4.1.36 дахь заалтын, 10 дахь заалтын 28¹.3 дахь хэсгийн, 28³ дугаар зүйлийн, 16 дахь заалтын 64¹.2 дахь заалтын, төслийн 2 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн, төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7.1 дэх хэсгийн, 2 дахь заалтын 11.1.19 дэх заалтын, 6 дахь заалтын 35.4 дэх хэсгийн, төслийн 4 дүгээр зүйлийн 53.1 дэх хэсгийн “баяжуулалтын” гэснийг “боловсруулалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн үг хэлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 14
Бүгд: 23
39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 19
Бүгд: 23
17.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйлийг хасах:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө олгосон хайгуулын тусгай зөвшөөрөлд Ашигт малтмалын тухай хуулийн 21.1.5 дахь заалт, 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйл хамаарахгүй болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд нь биржээр дамжуулан баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж экспортлох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт олон улсын худалдааны нөхцөлөөр арилжиж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д заасны дагуу дээрх заалтаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан саналыг хуралдаан даргалагч танилцуулж, ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул бусад санал дэмжигдээгүйд тооцож, уг саналаар санал хураалт явуулаагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.32 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэсний дараах “зөвшөөрөл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 59.1.2 дахь заалтын “15” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “30 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэснийг “40 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийн” гэснийг “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 22 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Х.Сүрэнхорол, С.Тэнгис, Монгол Улсын Шадар сайдын зөвлөх Г.Жавхлантөгс, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн газрын зөвлөх Ж.Мягмарсүрэн, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, Б.Нарангэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Батбаатар, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, Э.Одбаяр, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа, С.Цэнгүүн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ болон ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН нэгтгэсэн төслийн нэрийг “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

“1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан өмчлөгчийн эрхийг хамгаалах, бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрх, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга өрсөлдөөн, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим

3.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангахад дараах зарчмыг баримтална:

3.1.1.хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.бизнесийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх;

3.1.3.төрийн зохицуулалт нь тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байх;

3.1.4.шударгаар олж авсан өмчлөх эрхийг хамгаалах;

3.1.5.бизнесийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх;

3.1.6.хөдөлмөр, оюуны бүтээл, хөрөнгө оруулалтын үр шим, хууль ёсны дагуу олсон орлогоо чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг баталгаажуулах;

3.1.7.хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг бие даан тодорхойлох эрхийг хангах;

3.1.8.хөдөлмөрлөх эрхийг бүрэн хангах, зохистой хөдөлмөрийг дэмжих;

3.1.9.ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, зохицуулалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулах;

3.1.10.шударга өрсөлдөөнийг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх,

3.1.11.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр шударгаар өрсөлдөх боломжийг хангах;

3.1.12.хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийг байгуулахгүй байх;

3.1.13.төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй байх, бизнес эрхлэгчээс нэг мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.14.нийтийн мэдээллийг хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгож ашиглах боломжийг нэмэгдүүлэх;

3.1.15.бизнесийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээнд суурилсан, давхардалгүй, ил тод, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахад чиглэсэн хяналт шалгалтыг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх;

3.1.16.хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоох үйл ажиллагаанд төр аливаа хэлбэрээр оролцохгүй байх.

3.2.Эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсруулан батлахдаа энэ хуулийн 3.1-д заасан эдийн засгийн эрх чөлөөний зарчмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Х.Сүрэнхорол нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	8
Бүгд:	23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, зохицуулалт

4.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

4.2.Өмчлөх эрхийг хязгаарлах шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хууль, хуулиар эрх олгосон байх шаардлагыг хангасан байна.

4.3.Төрөөс үнэ тогтоох, нийлүүлэлтийг хязгаарлах шийдвэр гаргахдаа энэ хуулийн 3.1.2-т заасныг баримтлах бөгөөд аливаа хязгаарлалтыг зөвхөн хугацаатай тогтооно.

4.4.Тухайн жилийн төсвийн тухай хууль болон түүнийг дагаж боловсруулсан хууль тогтоомжоос бусад хууль тогтоомж нь бизнес эрхлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, зардлыг нэмэгдүүлэх бол хууль тогтоомжийн дагаж мөрдөж эхлэх хугацаа нь батлагдсанаас хойш 6-аас доошгүй сарын хугацаатай байна.

4.5.Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн үр дагаварт жил тутам шинжилгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг багасгана.

4.6.Бизнес эрхлэгчийн ашиг, орлого, хөрөнгөд ногдуулах татварыг хуулиар тогтооно.

4.7.Төр нь бизнесийн үйл ажиллагаанаас үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлал, арбитрын болон бусад шүүхийн бус журмаар шуурхай, шударга, хараат бусаар шийдвэрлэх боломжийг дэмжинэ.

4.8.Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломжийг хангасан байна.

4.9.Мэргэжил эзэмших, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн зохицуулна.

4.10.Төсвийн сахилга батыг сахиж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажиллана.

4.11.Төр бизнес эрхлэгчийн зөвшөөрөлтэй эрхэлж байгаа үйл ажиллагааг хэвийн, саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 8

Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 7 дугаар зүйлийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл

8.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

8.1.1.үндэсний аюулгүй байдал, хүний үндсэн эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, норм, стандартын баримт бичиг батлан гаргах;

8.1.2.бизнес эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндэд халдах, үндэслэлгүй, хуурамч мэдээлэл түгээх;

8.1.3.бизнес эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулах;

8.1.4.хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхүй гаргах;

8.1.5.энэ хуульд заасан зарчмыг зөрчиж эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлах, эс үйлдэхүй гаргах;

8.1.6.бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, оролцох, үндэслэлгүй хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлах;

8.1.7.бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актад зааснаас бусад баримт бичиг, түүний бүрдлийг шаардах;

8.1.8.бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тогтоосон хугацааг хэтрүүлэх.

8.2.Хувийн өмчийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хураах, дайчлан авах төрийн шийдвэр нь зөвхөн зах зээлийн бодит үнэлгээнд үндэслэсэн нөхөх олговор бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэгжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 8

Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар бүлгийн нэрийг **“ХОЁРДУГААР БҮЛЭГ” “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”** гэж өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 9

Бүгд: 23

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 8 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 9

Бүгд: 23

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар бүлгийн нэрийг **“ГУРАВДУГААР БҮЛЭГ” “ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ”** гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 8

Бүгд: 23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 9 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 10 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 11 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 12 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 13 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 14 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 15 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 16 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн **“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ”**
“ХАРИУЦЛАГА, ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 17 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хариуцлага

5.1.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйгээс бизнес эрхлэгчид учирсан хохирлыг төрөөс хуульд заасны дагуу нөхөн төлнө.

5.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 18 дугаар зүйлийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Гомдол гаргах эрх

7.1.Аж ахуй эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, эрхийг сэргээх, нөхөн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.энэ хуулийн 3.1.12-т заасны дагуу үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”** **“БУСАД”** гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Р.Сэддорж нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 21 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн **“ЗУРГАДУГААР БҮЛЭГ”** **“БУСАД ЗҮЙЛ”** гэснийг **“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 22 дугаар зүйлийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэг, 15.9.6 дахь заалтын “Олон улс,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 13
Бүгд: 23
43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23

60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэг, 15.9.6 дахь заалтын “Олон улс,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “хассугай” гэсний өмнө “, мөн зүйлийн 15.9.7 дахь заалтын “, татварын өргүй байх” гэснийг тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “18 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын дугаарыг “7.1.11” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийн “эрх бүхий” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9

Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд” гэснийг “2024-2034 онд 90 хувиар, 2035-2040 онд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “дагаж мөрдөнө.” гэсний дараа “Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтын өөрчлөлтийг 2041 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 32 дугаар зүйлийн “дэвшилтэт технологи” гэсний өмнө “газар тариалан,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.18 дахь хэсгийн “зөвшөөрлийн гэрчилгээг” гэснийг “зөвшөөрлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “25.6 дахь” гэсний өмнө “25 дугаар зүйлийн” гэж нэмж, мөн зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “амьтныг сэргээн нутагшуулах” гэсний дараа “, өсгөн үржүүлэх” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Арбитрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 26.9.4 дэх заалтын “архивын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “26.3.4 дэх заалтын “аюулын” гэснийг “аюулгүй байдлын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсгийн” гэсний дараа “22 дугаар зүйлийн 22.2, 22.7 дахь хэсгийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Аудитын тухай хуулийн” гэсний дараа “3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.11.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх хууль тогтоомжийн болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, захиргааны шийдвэрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, 62.1-д заасан журмын дагуу урьдчилан мэдээлж, санал авах, сонсох ажиллагаа явуулах, хэлэлцүүлэх, албан ёсоор нийтлэх замаар ил тод байдлыг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 6.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.14.Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төрийн хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлэх бөгөөд хуульд заасан хугацааг хэтрүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “5 дугаар зүйлийн” гэсний өмнө “аж ахуй нэгжийг” гэснийг “хуулийн этгээдийг” гэж,” гэж , “Долоодугаар бүлэг” гэсний өмнө ““22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж”, гэж нэмж, мөн зүйлийн ““7 дугаар зүйлийн 7.2.9 дэх

заалтын дугаарыг 7.2.10” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “16.3 дахь хэсгийн” гэснийг “16.3.1 дэх заалтын” гэж, төслийн 6 дугаар зүйлийн “9.3-5 дахь хэсэг” гэснийг “9.3, 9.4, 9.5 дахь хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян хоёр.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян гурав.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян дөрөв.Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян тав.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян зургаа.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд” гэснийг “2024-2034 онд 90 хувиар, 2035-2040 онд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “дагаж мөрдөнө.” гэсний өмнө “2041 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Заяабал: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “дагаж мөрдөнө.” гэсний өмнө “2041 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9

Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян долоо.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “16 дугаар зүйлийн” гэсний өмнө “12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “аж ахуйн нэгжийг” гэснийг “хуулийн этгээдийг гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян найм.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11

Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Наян ес.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ер.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн нэг.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн хоёр.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн гурав.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн дөрөв.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн тав.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.20, 25.21 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	9
Бүгд:	23

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	8
Бүгд:	23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн зургаа.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	8
Бүгд:	23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ерэн долоо.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Заяабал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.17 дахь заалтын “тэсэрч дэлбэрэхээс бусад” гэснийг, мөн заалтын “100-“ гэснийг, 6 дахь хэсгийн 6.15 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлээс “1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.7 дахь заалтыг” гэснийг хасаж, 1 дүгээр зүйлд шилжүүлэх, мөн зүйлийн 13 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.11 дэх заалтын “өвчний” гэсний дараа “судалгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй холбогдох бусад” гэснийг, мөн зүйлийн “8.1” гэсний дараа “, 8.3” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9

Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “3.1 дүгээр” гэснийг “3.2 дугаар” гэж, мөн зүйлийн 5.5 дугаар зүйлийн “14 дэх” гэснийг “15 дахь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 8.1 дэх зүйлийн 7 дахь хэсгийн “7.8”, мөн зүйлийн “1.12” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найруулгын санал:

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан, Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 2026.06.25-ны өдрийн 00 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 8 цаг 08 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 2026.06.25-ны өдрийн 00 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 39 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Заяабал: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Цэндийн Баатархүү, Пүрэвийн Батчимэг, Хүрэлбаатарын Булгантуяа, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Мэндбаярын Мандхай, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Болдын Уянга, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Мөнхчулууны Энхцэцэг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд өнөөдрийн Байнгын хорооны хуралд хүрэлцэн ирсэн байна. Ингээд хуралдааны ирц 56.3 хувьд хүрсэн тул хуралдааныг нээе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56.3 хувьтай хүрсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн асуудлаар, 2.Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай Улсын Их Хурал /УИХ/-ын тогтоолын төслийг хэлэлцэх, 3.Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх, 4.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах, 5.Монгол Улсын 25 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн Газар /ЗГ/-ын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна. 6.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна, 7.Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг явуулна, 8.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна, 9.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна, 10.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна, 11.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулна, 12.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 13.Ашигт малтмалын

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахаар тов дараалалд тусгагдсан байна.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Хоёр, гурван гишүүн байна. Соронзонболд гишүүний микрофон олгоё.

Л.Соронзонболд: Энэ Эрчим хүчний салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг нөгөө заалтууд нэлээн нарийн техникийн асуудлууд байгаа учраас Эрчим хүчний сайдыг байлцуулж, хэлэлцэж байгаад тогтоолын төслөө яривал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Тийм учраас энэ тогтоолын төслийг хэлэлцэх асуудал хойшлуулж өгнө үү гэсэн нэг ийм хүсэлт гаргаж байна. Тийм, хойшлуулах, өнөөдөр Эрчим хүчний сайд байхгүй байгаад байна. Эрчим хүчний энэ дээр нэлээн нарийн даалгаврууд өгч байгаа. Тэгэхээр томилолтой байгаа юм чинь.

Б.Заяабал: Уянгахишиг гишүүн адилхан горимын санал гэсэн учраас Уянгахишиг гишүүний горимын саналыг сонсчихё.

Г.Уянгахишиг: Яг энэ тогтоолын хувьд болохоороо нэлээн олон нөгөө нэг суурь мэдээллүүдийг авах гээд хүсэлт гаргачихсан байгаа. Тэгэхээр тэр хүсэлтийн дагуу суурь мэдээллүүд ирж байж хэлэлцүүлгээ бид хангалттай явуулах шаардлагатай гэж харж байгаа. Мөн түүнчлэн энэ ЗГ-т үүрэг өгч байгаа учраас яг сайдыг нь байж байгаад хэлэлцэхгүй болохгүй гэдэг саналтай байгаа юм. Тэгэхээр энэ асуудлаас хойшлуулж өгөөч гэдэг горимын санал байна.

Б.Заяабал: Байнгын хорооны хуралдаанд ирцэд орсон гишүүд хуралдааны танхимд хүрэлцэн ирнэ үү. Горимын санал Батчимэг гишүүн, дараа нь Жаргалан гишүүн байгаа. Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Эрчим хүчний салбарын энэ тогтвортой, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай гээд УИХ-ын тогтоолын төсөл орж ирж байгаа. Тэгэхээр энийг манай Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд энэ тогтоолын төслийг маш сайн харах хэрэгтэй. Би ойрын өдрүүдэд энийг хараад байгаа. Энэ ЗГ-ын бүрэн эрхийн асуудалд УИХ тогтоол гаргах замаар оролцох нь зөв үү, үгүй юү гэдэг зөв эсэхэд бид үнэлэлт, дүгнэлт өгч байж энэ тогтоолын төслийг цааш хэлэлцэж явах нь зүйтэй гэсэн санал гаргаж байгаа юм. Яагаад гэвэл энэ Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан энэ хуулийн заалтыг зөрчөөд ороод ирж байгаа юм л даа. Тэгэхээр эхлээд үнэлэлт, эхлээд энэ зөв үү, энийг хэлэлцэх нь зөв үү, үгүй юү гэдгийг гишүүд ярилцах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Б.Заяабал: УИХ-ын манай Эдийн засгийн байнгын хорооны гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү? Тэгээд гишүүдийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Бүгдээрээ гишүүдийн гаргасан горимын саналаар санал хураая. Гишүүн болгоноор хураах уу? Горимын саналтай холбоотой санал гаргасан 3 гишүүний санал маань агуулгын хувьд нэг байгаа учраас 3 дахь асуудал буюу Эрчим хүчний салбарын тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэхийг өнөөдрийн

хэлэлцүүлгээс хойшлуулъя гэдэг горимын санал гаргасан. Энэ горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү.

Саналын томъёоллоо уншаад танилцуулсан. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Ингээд 3 дахь асуудал өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлогдож байна, хасагдаж байна гэсэн үг. Өөр бусад горимын саналтай гишүүд байгаа билүү, байхгүй байна. Ингээд дарааллын дагуу хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг. “Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Нэр дэвшигчийн сонсголын товыг хойшлуулах талаар Байнгын хороонд ирүүлсэн хүсэлт болон тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тус тогтоолыг уншиж танилцуулъя.

Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3, 121.4 дэх хэсэг, УИХ-ын гишүүн Жавхлан нарын 16 гишүүний хүсэлтийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 26 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 4 дүгээр тогтоолд заасан Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын товыг хойшлуулж, 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсголын товыг нийтэд дахин зарлах, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү? Гишүүд асуулт асууж, санал хэлэх гишүүд байхгүй байна. Уг тогтоолыг дэмжье гэдэг дээр санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Ирцэд 20 гишүүн орсон, танхимд 13 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ингээд Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Санал хураалт бэлдчихсэн үү, бэлдчихсэн. Санал хураалт явуулъя. 50 хувьтай, 50 хувийн санал. Булгантуяа гишүүн горимын санал гаргая гэсэн, Булгантуяа гишүүний микрофон өгье.

Х.Булгантуяа: Байнгын хорооны даргаа санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хураалт зохион байгуулж өгөөч.

Б.Заяабал: Сая Булгантуяа гишүүн горимын санал гаргасан. Ингээд Булгантуяа гишүүний гаргасан горимын саналаар энэ санал хураалтыг хүчингүй болсонд тооцъё гэдгээр санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Бэлдчихсэн үү? Булгантуяа гишүүний гаргасан горимын саналыг

дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 54.5 хувийн саналаар уг горимын санал дэмжигдлээ.

Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг томьёоллоороо санал хураалтаа дахин явуулъя. Дахиж бэлдэх үү? Санал хураалтаа явуулъя, бэлдье гэдэг томьёоллоор, юу дэмжье гэдэг томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 54.5 хувийн саналаар уг Байнгын хорооны тогтоолын төсөл дэмжигдлээ, тогтоол батлагдлаа.

2 дахь асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудлын 2, Эдийн засгийн нөхцөл байдал болон үнийн өсөлтөөс сэргийлэх чиглэлээр. УИХ-ын тухай хуулийн чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дээр санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно гэсэн ийм заалт байгаа юм байна. Тэгээд сая Байнгын хорооны гишүүний гаргасан саналаар байхгүй байгаа гишүүний кноп гарч байна гэсэн ийм асуудал гарсан учраас уг санал хураалтыг хүчингүй болгохтой холбоотой санал хураалтыг дахин явуулъя. Шууд хүчингүй болгох уу, зөв. Дэгийн тухай хуулийн 19-ийн дагуу уг санал хураалтыг шууд хүчингүй болсонд тооцох юм байна. Саяын санал хураалтыг Дэгийн тухай хуулийн 19-ийн дагуу хүчингүй болсонд тооцлоо.

Тогтоолын төслийн Нэр дэвшигчийн сонсголын тов хойшлуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Ирцэд, орчихсон уу? Ингээд саналын томьёоллоор дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй. 47.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

Хоёр. “Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэх асуудлын хоёрдоо оръё. Эдийн засгийн нөхцөл байдал болон үнийн өсөлтөөс сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаарх Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан боловсруулсан Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Төслийг уншиж танилцуулъя.

Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Макро эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, гадаад орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нийлүүлэлтийн гаралтай инфляц /inflation/-ыг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын ЗГ-т даалгасугай:

1/уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх замаар экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;

2/газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэх, шатахууны нөөцийг бүрдүүлэх хүрээнд хувийн хэвшлийн агуулах, нөөцийн савны багтаамжийг нэмэгдүүлэх, шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн агуулахын үлдэгдлийг бодит цагийн горимоор хянах системийг ашиглалтад оруулах;

3/шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах хүрээнд шатахуун экспортлогч орнуудын төр, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хэлэлцээ хийх, шаардлагатай хэлэлцээрийг байгуулах;

4/ ЗГ-ын боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн угаах гэрээтэй холбоотой үүссэн татварын маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5/Евразийн худалдааны түр хэлэлцээр 2026 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хэрэгжиж буйтай холбогдуулан тус хэлэлцээрээр тарифын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан малын гаралтай түүхий эд, ноолуур, арьс, шир, бэлэн бүтээгдэхүүний экспортын нэмүү өртгийн сүлжээг дэмжих, уул уурхайн бүс, экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх;

6/Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн, Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян, Цагаан алт хөдөлгөөний хүрээнд улсын төсвийн татаас, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдэд макро эдийн засгийн болон салбарын үйлдвэрлэлд үзүүлсэн бодит нөлөөлөл, эдийн засгийн үр ашгийн судалгаа хийж, цаашид тус хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх эсэх тухай саналыг боловсруулж, 2026 оны 3 дугаар улиралд багтаан УИХ-д танилцуулах;

2.Хүнсний нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бууруулах, үйлдвэрлэлийн өртгийг бууруулах, нийлүүлэлтийг тогтворжуулах чиглэлээр:

1/махны хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүүгийн дэмжлэгтэй санхүүжилтэд тулгуурлан мах боловсруулах үйлдвэрүүд болон малчдын хоршоодын түншлэлээр махны захиалгат тогтолцоог нэвтрүүлэн, нэг цонхны бодлогоор зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2/нөөцийн мах бэлтгэлийн санхүүжилтийг 2026 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэж, малчдаас шууд худалдан авах урьдчилсан гэрээний тогтолцоог нэвтрүүлэх;

3/махны хадгалалт, ложистик /logistics/-ийн дэд бүтцийг өргөжүүлэх, хаврын улиралд нийлүүлэлтийн хуваарилалтыг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн уян хатан, шуурхай зохион байгуулах, цахим системийг нэвтрүүлэх;

4/нөөцийн мах бэлтгэлд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шалгуурыг тодорхой болгож, өрсөлдөөнийг дэмжих замаар нийлүүлэлтийн хомсдол үүсэх эрсдэлийг хаах;

5/газар тариалангийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай дизель түлш, эрдэс бодис, эрдэс бордоо, ургамал хамгааллын бодисыг дотоодын үйлдвэрлэгч болон импортлогчдод хөнгөлөлттэй зээлээр хангах, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын зохицуулалтаар дэмжих;

6/тариалангийн бүс нутгуудад ашиглагдаж буй цахилгааны эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтийг усжуулалтын систем, зоорины аж ахуйд уртасгасан хугацаагаар мөрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг хийх;

7/тариалангийн үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор таримлын үр, шатахуун, химийн гаралтай эрдэс бордоог тариалан эрхлэгчдэд нийлүүлэх ажлыг Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит ХХК-аар дамжуулан шуурхай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг шууд худалдан авалтын нөхцөлөөр шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

8/төмс, хүнсний ногооны хадгалалтын алдагдлыг бууруулах зорилгоор орчин үеийн стандартын шаардлага хангасан дулаан зоорийг бүс нутгийн байршлаар нь нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх;

9/хүн амын хүнсний хэрэгцээний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд хүргэх худалдааны нөхцөлийг бүрдүүлэх, цаашид зуучлагчид түшиглэсэн худалдааны тогтолцоог үе шаттайгаар бууруулах зорилгоор аймаг, нийслэлийн төвд хадгалалт, түгээлтийн нэгдсэн төвүүдийг ашиглалтад оруулах;

10/стратегийн хүнсний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, зах зээлд дамжуулан худалдаалах зохиомол хомсдол, үнийн хөөргөдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, нийлүүлэлт, худалдан борлуулалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах;

3/тогтоолын 1, 2 дугаар заалтад заасан арга хэмжээний биелэлтийн үр дүнг тооцох, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, энэ дагуу заалт бүрээр биелэлтийг гарган Монгол УИХ-ын 2027 оны хаврын ээлжит чуулганд багтаан танилцуулахыг Монгол Улсын ЗГ-т даалгасугай;

4/тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгасугай гэсэн ийм УИХ-ын тогтоолын төсөл байна. Тус тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу, Пунсалмаа гишүүн нэмэлтээр оруулчихъя, Цэнгүүн гишүүн. Цэнгүүн гишүүний микрофон өгье.

С.Цэнгүүн: Энэ тогтоолын төсөл орж ирж байгаатай холбоотойгоор ерөнхийдөө зарчмыг нь ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Манай Монгол Улсын Ерөнхий сайд маань чөлөөлье аяныг явуулаад ер нь төр эдийн засаг дахь оролцоогоо больё, тэгээд бизнесүүдээ дэмждэг байя гээд яриад байдаг. Гэтэл энэ тогтоолын төсөл нь болохоор эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээ гээд, тэгээд энэ нь өөрөө төрийн оролцоогоо нэмчихсэн тогтоолын төсөл өөрөө орж ирээд байгаа юм. Тэгэхээр ЗГ-ын явж байгаа тэр чөлөөлье гээд байгаа бодлогын эсрэг зүйл байгаа

учраас энэ нь өөрөө яг ямар агуулгаар бэлтгэсэн юм гэдэг нь их сонирхолтой байна л даа.

Тэгээд ерөнхийдөө энэ хүнсний үнэ тогтворжуулах, тэгээд л эрчим хүч, түлш шатахуун гээд бид маш олон үнэ тогтворжуулах бодлогуудыг хэрэгжүүлсэн байдаг. Гэтэл тэр нь өөрөө бодитоороо ерөөсөө хэзээ ч хэрэгжиж байгаагүй. Тэгээд эцсийн дүндээ яг тэр тухайлсан бараа бүтээгдэхүүнүүдийн үнийг нь хянана гэдэг юм нь өөрөө хомсдолтой болоод, дутагдалтай болоод, тэгээд бүр ингээд тэр нь төр оролцсоноосоо хийсэн юм болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ нэг ийм төрийн оролцоогоо улам ахиад нарийвчилж зааж өгөөд, тэгээд тэрийг нь УИХ-ын тогтоолоороо батлаад өгнө гэдэг нь өөрөө буруу бодлого байна гэж хараад байна л даа. Тийм учраас энэ тогтоолыг ер нь яг анх хаанаас боловсруулсан, эх хувь нь хаанаас боловсруулж өгсөн юм бэ? Тэрэн дээр тайлбар авмаар байна. Тэгээд үндсэндээ энэ тогтоолын төслийг бид батлах шаардлагагүй гэж харж байна.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. УИХ-ын дэгийн тухай хуулийн дагуу бид өнгөрсөн 7 хоног билүү, хоёр 7 хоногийн өмнө Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр сайдаас энэ эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой бид мэдээлэл сонссон. Энэ мэдээлэл дээр үндэслээд Байнгын хороо уг тогтоолын төслийг боловсруулж, өнөөдрийн хурлаар оруулж ирж байгаа. Энэ Их Хурлын тогтоол, Байнгын хорооны биш, Их Хурлын түвшний Их Хурлын тогтоол байх нь зүйтэй гэж Байнгын хорооноос үзсэний дагуу боловсруулж оруулж ирж байгаа.

Дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.3-т энэ Байнгын хороо энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, УИХ-аас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно гэсэн ийм заалт байгаа. Энэний дагуу уг тогтоол боловсрогдож, өнөөдөр та бүхэнд танилцуулагдсан. Тэгээд УИХ-ын Байнгын хорооныхоо гишүүдтэй хэлэлцэх асуудал дээр уг томъёоллыг боловсруулж, Байнгын хорооныхоо групп дээр бид тавьсан байгаа. Энэнтэй холбоотойгоор зарим манай Байнгын хорооны гишүүдээс санал ирсэн. Эдгээр саналыг боловсруулж нэгтгээд, өнөөдрийн энэ УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, өнөөдрийн хэлэлцэх асуудлаар орж ирж байгаа гэдгийг хариулж хэлье.

Мөн түүнчлэн энэ тогтоолд 3 яамны саналыг авч тусгасан. Энэ манай эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөлд дэмжлэг болгох үүднээс ЗГ-ын холбогдох яамдын төлөөлөл энэ ажлын хэсэг болж орж ирсэн байгааг энд танилцуулъя гэж бодож байна.

Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Цэдэнгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга гэсэн ийм 3 яамны төлөөлөл өнөөдөр хүрэлцэн ирсэн байна гэдгийг танилцуулъя. Цэнгүүн гишүүн тодруулъя.

С.Цэнгүүн: Энэ заалтууд дундаас сонирхол татаж байгаа зүйл байна. Хүн амын хүнсний хэрэгцээний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд хүргэх, худалдааны нөхцөлийг бүрдүүлэх, цаашид зуучлагчид түшиглэсэн худалдааны тогтолцоог үе шаттайгаар бууруулах зорилгоор аймаг, нийслэлийн төвд хадгалалт, түгээлтийн нэгдсэн төвүүдийг ашиглалтад оруулах гээд ярьж байгаа. Тэгэхээр ажлын хэсгээс асуумаар байгаад байгаа юм. Энэ нь өөрөө жишээ нь ийм төвүүдийг төр өөрөө барьж ашиглалтад оруулах гээд байгаа юм уу, хэрэгжүүлэгч нь хэн байх агуулгаар энийг оруулаад байгаа юм бол? Уг нь манай төр чинь нийтээр ингээд нийтийн дундын зам ч байдаг юм уу, эрчим хүч байдаг юм уу, тэрийгээ л төр хариуцдаг байя, бусад бүх зүйлүүд төр оролцохгүй байя гээд яриад байгаа. Гэтэл одоо бид чинь ингээд ийм хадгалалт, түгээлтийн нэгдсэн сүлжээг нь өөрөө төр нь үүсгэнэ гэж байгаа юм шиг ийм агуулгатайгаар тогтоолын төсөл дээр ороод ирчихсэн байна л даа. Тэгэхээр энийг хэн жишээ нь ашиглалтад оруулаад, хэн хариуцаж явах юм бэ? Энэний үнэ өртөг, зардлын тооцоо байгаа юм уу?

Б.Заяабал: Дэмжих чиг үүрэгтэй ажлын хэсгээр нэмэлт тодруулга, мэдээлэл өгье. Энэнээс өмнө гишүүддээ хэлэхэд энэ нэгэнт манай Байнгын хорооноос гарч байгаа, Их Хурал руу оруулж байгаа тогтоолын төсөл учраас манай гишүүд энэ дээр томъёоллоо одоо бэлтгээд, бүгдээрээ санал хураагаад, оруулаад, шийдээд явах боломж нь нээлттэй байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Дэмжих чиг үүрэгтэй оролцож байгаа яамдын төлөөллөөс Цэнгүүн гишүүний асуулттай холбоотой нэмэлт хариулт хэн өгөх вэ? 8 дугаар микрофон өгье.

Ц.Болорчулуун: Цэнгүүн гишүүний асуултад хариулт өгье. ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. ХАА-н гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ хэд хэдэн дамжлага дамжиж, эцсийн хэрэглэгчид нэлээд үнэтэй орж ирж байгаа. Тухайлбал, махан дээр аваад үзвэл малчны хотноос гарсан мах 4 ч дамжлага дамжиж, эцсийн хэрэглэгчид хүрч, энэ хоорондоо үнэ тодорхой хэмжээнд нэмэгдэх, нэлээдгүй хэмжээгээр нэмэгдэх ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Тэгэхээр энийг шууд орон нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт дээр түшиглэсэн зохион байгуулалттайгаар, ийм шууд хэрэглэгчээс бэлтгэн нийлүүлэгчээс хэрэглэгчид хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор л энэ тогтоолын төсөлд энэ саналыг тусгаж өгч байгаа. Тэгээд энэ дээр төр учиргүй хөрөнгө гаргаад, хөрөнгө оруулалт хийгээд, энэ төвүүдийг бариад байхгүй, тухайн сум орон нутгаар аваад үзвэл сум болгонд ингээд.../минут дуусав/

Б.Заяабал: 8 дугаар микрофон нэмж өгье, нэмэлт тодруулга.

Ц.Болорчулуун: Шинэ хоршооны хөдөлгөөнд сум болгонд ингээд хамгийн багадаа 5-аас 10 хоршоо байгуулагдсан. Энэ хоршоод маань дундын хоршоо хэлбэр лүү шилжээд явж байгаа. Тэгэхээр энэ дундын хоршоонууд дээр байгаа агуулахуудыг түшиглэж, энэ тогтолцоог бий болгох чиглэлээр энэ тогтоолын заалтыг оруулсан байгаа.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүн тодруулга 1 минут өгье. Гантөмөр гишүүний микрофоныг нээгээд өгөөрэй, бүртгэлд аваадхаарай.

С.Цэнгүүн: Тэгэхээр миний ойлгож байгаагаар таны саяын хариултаас төр маань энийг, энэ нэгдсэн төвүүдийг ашиглалтад оруулахгүй юм байна, тийм үү? Тийм болохоор яг энэ дээр тэгээд биччихсэн байна л даа. Хадгалалт, түгээлтийн

нэгдсэн төвүүдийг ашиглалтад оруулах гээд. Тэгэхээр үндсэн ойлгогдох юм нь ЗГ энэ юмнуудыг ашиглалтад оруулах гээд байгаа юм шигээр ойлгогдоод байна. Тэгэхээр хувийн хэвшлийнхэн өөрсдөө ашиглалтад оруулаад явчих юм нь өнөөдрийн хууль тогтоомжоор ямар ч хаалт, боолт байхгүй байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ заалт өөрөө ямар ч нөгөө нэг чиг үүрэг, ямар нэгэн зорилгыг агуулаагүй байгаа учраас тэртээ тэргүй нэг ийм бүдэг бадаг заалт оруулж байхаар энийг жишээ нь хасчихмаар юм шиг харагдаад байна л даа. Ер нь чөлөөт эдийн засгийн зах зээлийг бид бүхэн дэмжсэн. Тэр утгаараа ер нь энэ түгээлттэй холбоотой ч байдаг юм уу, эдийн засаг дахь оролцоон дээр төр оролцоод байх нь маш зохимжгүй, буруу үр дагавар гаргадаг гэдэг нь харагдаад байгаа учраас иймэрхүү заалтуудыг бүгдээрээ хасчихвал дээр юм байна гэж харж байна.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүн санал хэлчихлээ. Уянгахишиг гишүүний микрофон өгье.

Г.Уянгахишиг: Яах вэ тогтоолыг ингээд уншихаар яалт ч байхгүй нэг хэрэгтэй асуудлууд шийдээд байгаа юм шиг уншигдаж байгаа юм. Махны нөөц, нөгөө зуучлагч дундын ченжүүдийг дамжуулахгүй байх энэ тэр гээд, тэгэнгүүт энэ дээр яг ингээд нөгөө тухайлан сая яг Цэнгүүн гишүүний хэлсэнчлэн яг яаж хэрэгжүүлэх гээд байгаа буюу яг ямар үр дүнг ямар замаар гаргах гээд байгаа юм гэдэг дээр нөгөө эзэн бие нь нэг ийм ойлгогдохгүй юмнууд гарч ирээд байгаа байхгүй юу. Хамгийн түрүүнд байна шүү дээ, энэ дээр нэг ийм хяналттай холбоотой хэд хэдэн заалтууд ороод ирчихсэн байгаа юм. Тэр дээр би бүр тухайлан юу гэж асуумаар байна гэхээр яг энэ эрхүүд нь хуулиараа яг энэ тухайн төрийн байгууллагууддаа, яамддаа олгогдсон байна уу гэж нэгдүгээрт? Энэ 1.2 дээр байгаа Газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэх гээд. Тэгэнгүүт шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн агуулахын үлдэгдлийг бодит цагийн горимоор хянах системийг ашиглалтад оруулах гэж байгаа юм. Энэ дээр нэмэлт тодруулга, тайлбар авмаар байна. Яг яаж хянах системийг ашиглалтад оруулах гээд байгаа юм, тэр тухайн хувийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа руу яаж оролцох гээд байгаа юм гэдгийг мэдээлэл авмаар байна.

Дөрөвдүгээрт болохоороо Газрын тос боловсруулах үйлдвэрийг, 4 дээр нь байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татварын маргааныг эцэслэн шийдвэрлэх гээд энэ яг ямар маргаан байгаа вэ? Энэ талаар арай дэлгэрүүлж мэдээлэл өгөөч.

Дараа нь энэ 2 дугаар зүйл дээр буюу хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор 10 дээр нь байгаа юм. Стратегийн хүнсний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах, зах зээл дамжуулан худалдаалах зохиомол хомсдол, үнийн хөөргөдөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх, нийлүүлэлт, худалдан борлуулалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах. Яг энэ хүрээнд ямар үйл ажиллагааг төсөөлөөд энийг оруулаад байгаа вэ? Өөрөөр хэлбэл энэ чинь ингээд нэг ийм нийлүүлэлтийн сүлжээ яваад байдаг. Тэгэнгүүт энэ нийлүүлэлтийн сүлжээнд чинь хувийн хэвшил, хувийн компаниуд болон мах нийлүүлэгч болон юу гэдэг юм оролцогчид байж байгаа. Тэгэнгүүт энэ дээр яаж хяналт тавьж ажиллах гээд байгаа вэ? Үйл ажиллагаанд нь төр ямар байдлаар оролцох гээд байгаа вэ? Энэ нь өөрөө хуульчлагдсан хууль, эрх зүйн үндэслэл нь байгаа юм уу гэдэг энэ 3 дахь асуулт байна.

Тэгээд ер нь яг энэ хийх гээд байгаа ажлууд дээрээ жишээлбэл сая тэр үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд хүргэх худалдааны нөхцөлийг бүрдүүлэх гэчихсэн байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр яг хийсэн тооцоо судалгаа юмнууд дээр ямар, яагаад малчид өөрсдөө хотод авчирч борлуулж чадахгүй байгаад байна вэ, эсвэл тэнчээ байгаа махны үйлдвэрүүд яагаад ашигтай ажиллаж чадахгүй, махны үйлдвэрүүд дээр яагаад юу гэдэг юм малчдаас мах нийлүүлж чадахгүй байгаад байна вэ? Энэ дээр нэг тодруулга хэлж өгөөч. Өөрөөр хэлбэл ченжээр дамжих буюу зуучлагч байгууллагаар дамжаад байгаагийн шалтгаан нь юу вэ? Өөрөөр хэлбэл одоо яг ингээд хот руу оруулахад нэлээн их бичиг баримтын бүрдүүлэлт юм орж ирдэг шүү дээ. Тэгэхээр тэр тэрийг махны үйлдвэрүүд хийгээд, өөрсдөө цуглуулахад хүндрэл нь юу байгаад байна вэ?

Б.Заяабал: Ажлын хэсгийн дэмжих чиг үүрэгтэй ажиллаж байгаа ажлын хэсгийн 7 дугаар микрофоныг өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Уянгахишиг гишүүний асуусан энэ тогтоолын 1.2 дээр байгаа энэ газрын тосны бүтээгдэхүүний аж ахуйн нэгжүүдийн үлдэгдлийг хянах системийн талаар. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль 2025 оны 12 сард батлагдсан. Уг хуулийн 7 дугаар зүйл дээр энэ газрын тосны бүтээгдэхүүний агуулахын бүтээгдэхүүний хангамж, хяналтын системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна гээд ЗГ-ын эрх, үүрэг дээр орсон байгаа. Үүнтэй холбоотой бид нийт улсын хэмжээн дээр импорт хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн газрын тосны бүтээгдэхүүний агуулах, ШТС дээр байгаа бүтээгдэхүүний үлдэгдлийг бодит цагийн горимоор хянах системийн платформыг бид зөвлөх үйлчилгээ аваад хийлгэх гээд ажиллаж байна.

Аж ахуйн нэгжүүд дээр, томоохон аж ахуйн нэгжүүд дээр өөрсдөд нь энэ систем бүрдчихсэн байдаг. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн гэдэг утгаар нь бид улсын нөөцийг тогтмол хянах, зохих түвшинд байлгах үүднээс энэ системүүдийг нэгтгэж, платформд холбох ажлыг зохион байгуулна. Нэгдсэн платформыг хийж эхлүүлээд байна. Дараа хүнстэй холбоотой, хүнстэй холбоотой.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон дээр, 8 дугаар микрофон тодруулга өгье. Дараа нь дахиад нэмээд 7 дугаар дээр өгье. 8 дугаар микрофон.

Ц.Болорчулуун: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр Хүнсний тухай хуулийн 3.1.6-д зааснаар стратегийн хүнс гэж малын мах, сүү, ундны ус, тарианы үр, гурилыг хэлж байгаа. Ингээд 6 төрлийн хүнсийг хэлж байгаа. Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээний бид энэ бэлтгэн нийлүүлэлт, худалдан борлуулалтын үйл ажиллагаанд нь хяналт тавьж, энэ дээр зохицуулалтын арга хэмжээг авч ажиллах нь Хүнсний тухай хуулиараа зохицуулагдсан байдаг. Тухайлбал, аюулгүйн нөөц бүрдүүлэх ажил үүрэг нь тухайн нийслэл, аймгийн Засаг даргад үүрэг өгөгдсөн. Тэгэхдээ бид стратегийн хүнс дээр тодорхой хэмжээний энэ дээр нь хяналт тавьж ажиллах ийм зайлшгүй шаардлага байж байж, энүүгээр тасалдуулахгүй байх үүрэг нь ХХААХҮЯ дээр тодорхой.../минут дуусав/

Б.Заяабал: 8 дугаар микрофон, нэмэлт тодруулгын минут өгье.

Ц.Болорчулуун: Үүрэг чиглэл байдаг учраас энэ дээр энэ заалтыг оруулж өгсөн, энийгээ хянаж явах нь зохистой гэж үзэж байгаа. Зоорь, агуулахын хувьд аваад үзвэл ер нь энэ ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг ХАА-н биржээр дамжуулж борлуулах ийм нэгдсэн тогтолцооны сүлжээг бий болгохоор бид зориод ажиллаж байгаа юм. Тэгээд нийтдээ 330 сумдад энэ ХАА-н биржийн итгэмжлэгдсэн агуулахуудыг бий болгохоор, мэдээж тэгээд итгэмжлэгдсэн агуулах гэхээр энэ төрийн хөрөнгө оруулалт биш хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан агуулахуудыг итгэмжлээд тэнд малын гаралтай, ХАА-н гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны тордолтыг хийгээд, тэндээсээ түгээлтийг хийх ийм механизмыг хийх зорилгоор үндсэндээ өнөөдрийн байдлаар 100 гаруй сумдад энэ итгэмжлэгдсэн агуулахуудыг итгэмжлээд явж байгаа. Энийгээ цаашаа улам сум болгонд нэг байхаар тооцоолж, энэ агуулахуудаар дамжуулж түүхий эдээ борлуулбал энэ ченжийн тогтолцоо буюу дундын зуучлагчийн тогтолцоог тодорхой хэмжээнд бууруулах ийм нөхцөл үүснэ гэж харж байгаа.

Б.Заяабал: Хэдэн номер юм, 7 дугаар микрофон, нэмэлт тодруулгыг нь 1 минут өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. 1991 онд анх Газрын тосны тухай хууль батлагдсан. Энэ хуулийн хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад, хайгуулын үе шатаас 2011, 2012 онд ашиглалтад шилжсэн 3 талбай байдаг. Уг талбайтай холбоотой тухайн үеийн хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу гэрээ байгуулсан боловч 12 он болон 14 онд Газрын тосны тухай хууль болон Татварын багц хуулиудад өөрчлөлт орсон. Үүнтэй холбоотой тухайн Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр Монгол Улсын ЗГ-т ногдох хувь хэсэгт энэ Монгол Улсын татваруудын хувь хэмжээ багтсан байдаг, багтсан байна гэдэг заалт байдаг. Уг заалттай холбоотой шинээр гарсан хууль тогтоомжтой зөрчилтэй байдал үүссэн. Уг асуудлаар 2018 онд Татварын нэгдсэн шалгалтаар тавигдсан актууд байгаа. Мөн Аудитын ерөнхий газраас хийсэн шалгалтуудын дүнд.../минут дуусав/

Б.Заяабал: Уянгахишиг гишүүний нэмэлт минут микрофон өгье.

Г.Уянгахишиг: Ингээд нөгөө тайлбарыг сонсохоор яг энэ тогтоолын өөрийнх нь шаардлага ерөөсөө тодорч гарч ирэхгүй байгаад байна л даа. Өөрөөр хэлбэл одоо яг ингээд үйл ажиллагаа явж байгаа болж байгаа, эрх, үүрэг нь байгаа, энэ ажлаа үргэлжлүүлээд хийчихнэ гэдэг юм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор хэрвээ Их Хурлын тогтоол жишээлбэл тодорхой хэмжээнд гарч байгаа бол яг энэ дээр чинь ямар асуудлыг шийдэх шаардлагатай байгаад байгаа юм бэ? Дээрээс нь ЗГ өөрөө мэдээд байгаа бол, харилцах хариуцсан яам нь мэдээд байгаа бол заавал Их Хурлын тогтоол гаргаж чиглэл, чиг үүрэг авч байж энэ ажлыг хийх ёстой юм уу гэдэг асуулт байгаад байна?

Тэгээд дээрээс нь тэр түрүүн Хүнсний хуультай холбоотой хэллээ шүү дээ. Тэгэхээр стратегийн хүнсээ мэдэж байгаа. Тэгэхээр тэрний хүрээнд нөөц бүрдүүлэх үүрэгтэй гэдгийг чинь мэдэж байгаа. Харин яг энэ худалдан борлуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих гэдгийг хяналт тавих нь зохистой гэж үзэх гэдэг чинь надад хангалттай хариулт биш байгаад байна л даа. Өөрөөр хэлбэл яг тэр хувийн

хэвшлийн үйл ажиллагаанд явуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих хууль зүйн үндэслэл чинь юу юм бэ?

Б.Заяабал: 8 номер, ажлын хэсгийн 8 номер.

Ц.Болорчулуун: Уянгахишиг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр ер нь энэ бэлтгэн нийлүүлдэг, худалдан борлуулах үйлчилгээнд хяналт тавина гэдэг бол жишээлбэл энэ хаврын тухайд энэ махны асуудалтай холбоотой нөөц бүрдүүлэлт, тэгээд хаврын яг дутагдаж байгаа цаг үед гарахтай холбоотой энэ асуудал гарсантай холбоотойгоор ийм асуудлууд энэ Их Хурлаас энэ тогтоолоор орж ирж байгаа гэж ойлгож байгаа.

Б.Заяабал: Уянгахишиг гишүүний микрофон.

Г.Уянгахишиг: Харин тэгэхээр яг наадах чинь байхгүй юу. Өөрөөр хэлбэл төрийн өмнө үүрэг хүлээгээд, жилийн 3 хувийн хүүтэй зээл аваад, тэгээд нөөц бэлдэнэ гэхихсэн тэр хуулийн этгээдүүдийнхээ үйл ажиллагаанд хяналт тавь л даа, гэрээнийхээ дагуу. Тэгэхгүй энэ дээр чинь ерөнхий орчхож байгаа байхгүй юу. Шууд урьдчилан нийлүүлэлт, худалдан борлуулалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих. Хэрвээ төрийн өмнө ямарваа нэг үүрэг хүлээгээгүй хуулийн этгээд байхад тэр хувийн хэвшлийн үйл ажиллагаа руу төр хуульд заасан үндэслэлгүйгээр хяналт тавьж байна гээд ороод байж болохгүй биз дээ? Тэгэхээр энэ юугаа тогтоол дээрээ байгаа юмнууд чинь ерөнхийлж яваад байна. Тэгээд үнэхээр тэр гэрээгээ биелүүлээгүй, нөөцийн мах бэлтгэл дээр тэр хэмжээний хөнгөлөлттэй зээл авчхаад, намар нь 13 мянган төгрөгөөр авсныгаа хавар нь 35 мянгаар зараад байгаа бол тэр компаниудынхаа асуудлыг шийд л дээ. Тэгэхээр энэ юмнуудаа оруулж ирэх, шийдэх асуудал байх ёстой болохоос биш үүгээрээ дамжуулаад бүх сүлжээн дээр хяналт тавих гэдэг юм гарч ирж болохгүй шүү дээ.

Б.Заяабал: Уянгахишиг гишүүн санал хэллээ. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Би нэг өмнө нь гарсан тогтоолын хэрэгжилтийг нэхмээр байна. 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр чиглэл өгөх тухай, энэ тогтоол нэлээн хэдэн заалттай ийм тогтоол байгаа. Энэ биелэлт ямархуу байгаа вэ? Ялангуяа тэр 2 дахь заалт дээр байгаа уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааг биржийн арилжаанаас салгаж, бие даасан байдлаар зохицуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах гэсэн ийм чиглэл ЗГ-т өгсөн байгаа. Энэ хаана яваа вэ?

Тэгээд энэ өнөөдөр бид дахиад шинэ чиглэл өгөх гэж байгаа, чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ шинэ чиглэл өгч байгаа чиглэл дээрээ энэ асуудлыг дахин оруулах зайлшгүй шаардлагатай байна. Яагаад энэ ЗГ энэ УИХ-аас гаргасан энэ чиглэлийг хэрэгжүүлэхгүй байгаа юм, УИХ-ын энэ бодлого тогтоолыг хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ? Энэ дээр хэн хариулах вэ? Эндээс холбогдох яамны хүмүүс байна уу, ЗГ-аас байна уу? Өнөөдөр бид энэ 20 мянга гаруй уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэгчдийн биржийн хуулиас болоод энэ хүмүүс маш хүнд байдалд орсон байгаа. Өнөөдөр өдөрт нэг айл бараг дампуурч байгаа, доод тал нь 350 сая төгрөгийн зээлтэй ББСБ-аас. Тэгээд энэ айлууд энэ тээвэр, огт энэ Биржийн тухай хуулиар огт явж чадахааргүй. Яагаад гэхээр Биржийн тухай хуульд тээврийг

Төрийн худалдан авах ажиллагааны газар олж өгнө, тэр хуулиараа хамгийн бага үнэ өгсөн тээвэрлэлт, тээврийн компани нь энд сонгогдоно. Хамгийн бага үнийг гадаадын аж ахуйн нэгжүүд буюу маш олон машинтай, маш мөнгөтэй ийм гаднын компаниуд, тээврийн компаниуд өгч байгаа юм. Тэд нар л зөвхөн тээвэр хийж байгаа, сүүлийн энэ Биржийн хууль гарснаас хойш.

Тэгэхээр энэ дээр энэ 1.1 дээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх замаар экспортыг нэмэгдүүлэх, нүүрс тээвэрлэлтэд үндэсний жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжиж, дотоодын тээвэрлэгчдэд чөлөөт зах зээлийн тэгш оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах гэж оруулмаар байна. Энийг оруулж өгөөч. Тэгээд түрүүний асуултад хариулж өгөөч?

Б.Заяабал: Сэддорж гишүүний асуултад тодруулга өгөх манай ЗГ-ын нэмэлт дэмжих ажлын хэсгийн гишүүд байна уу? 7 дугаар номер.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Биржтэй холбоотой асуулт дээр би холбогдох газрын дарга нар болон хүмүүсээс нь тодруулга аваад танд бичгээр хариу өгье. Яг одоо надад мэдээлэл алга байна.

Б.Заяабал: Өмнөх энэ 124 дүгээр тогтоол гэсэн үү, тийм ээ? Тийм. Өмнөх тогтоолын хэрэгжилттэй холбоотой манай холбогдох яамдын төлөөлөл албан ёсоор Сэддорж гишүүнд бичгээр хариулт өгөхийг хүсье. Албан ёсоор өгөөрэй. Энэ тогтоолын төсөл мэдээж Байнгын хорооноос гарч байгаа учраас Дэгийн тухай хуулийнхаа дагуу манай Байнгын хорооны гишүүд холбогдох зүйл, заалт дээр саналаа гаргаад тусгуулах эрх нь нээлттэй байгаа юм байна. Тийм учраас Сэддорж гишүүн та оруулах саналынхаа томъёоллыг бичээд өгнө үү гэдэг ийм хариулт өгье. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Дахин энэ Байнгын хорооноос тогтоолын төсөл дээр дахин оруулъя, санал оруулъя. 1.1 дээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх замаар экспортыг нэмэгдүүлэх, нүүрс тээвэрлэлтэд үндэсний жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжиж, дотоодын тээвэрлэгчдэд чөлөөт зах зээлийн тэгш оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах гэдэг заалтыг оруулмаар байна, энийг яг энэ үг үсгээр нь улам баяжуулж өгөөч. Тэгээд энэ өнөөдөр бид энэ нэг өдөрт дор хаяж нэг айл дампуурч байгаа шүү, тэр банкны зээлийн хүүд. Тэгээд энэнээс үүдээд маш олон хүн ингээд тээврийн бизнес эрхлэх гээд зээл авчихсан. Энэ хүмүүс бүгд дампуурч байгаа, бүгд энэ төрийн худалдан авахаас гарч байгаа үнээр явах ямар ч боломж байхгүй. Тийм учраас энийг шийдэж өгөөч.

Б.Заяабал: Сэддорж гишүүн санал хэллээ. Дараа нь Жаргалан гишүүн. Жаргалан гишүүний микрофон өгье.

Б.Жаргалан: УИХ нь УИХ шиг байгаад ЗГ нь ЗГ шиг баймаар байна гэж удаа дараалан хэлж байгаа. Тэгээд энэ УИХ нэг ийм ЗГ-ын хуулийн хэлтэс шиг эсвэл нэг туслан гүйцэтгэх шиг ерөөсөө ажилламааргүй байна. Энэ тогтоолын төслийг харвал тэртээ тэрэнгүй түүгээрээ ЗГ дээр мөрийн хөтөлбөрт нь ороод, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь ороод хийгдээд явж байх ёстой зарим нэг ажлуудыг зүгээр ингээд тусгаад өгчихсөн байж байгаа. Тэгэхээр ийм ажил хаана хаанаа удаж, энэ ЗГ-ын

захиргааны байгууллагуудын, яамдын энэ газрын дарга нар, албан хаагчдыг ингэж нааш цааш нь гүйлгэж, ингэж дор бүрнээ ингэж ажил удаж, ажил хийж байгаа дүр эсгэмээргүй байна. Энд байгаа дийлэнх ажил угаасаа ЗГ дээр түүгээрээ явж байгаа ажлууд байгаад байна.

Зарим нэг ажлууд нь болохоор ер нь хаана хаанахын, аль алиныхаа бодлоготой огт нийцэхээргүй ажлууд байна. Жишээлбэл, нэг баахан татаас, нэг баахан хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал олгоно энэ тэр гэсэн ийм заалтууд. Уул нь Их Хурал дээр чинь гишүүд энийг чинь шүүмжлээд л байдаг биз дээ? Энэ нэг зах зээлийнхээ горимоор асуудлуудаа шийдье, янз бүрийн энэ татаас, хөнгөлөлт, чөлөөлөлтүүдээ таная л гэж бид уул нь яриад байгаа биз дээ? Тэгээд хаанаасаа ийм тогтоолын төсөл боловсруулагдаад ороод ирдэг юм бэ? Эдийн засгийн байнгын хороо санаачилж байгаа бол яагаад Эдийн засгийн байнгын хорооны гишүүд дотроосоо ажлын хэсэг гаргаад ч юм уу явуулаагүй, түүгээрээ энэ нөгөө яамдынхаа хэдэн дарга нарыг дуудаад, энэ яамдынхаа хүмүүсийг суулгаад, ингээд нэг өөх ч биш, булчирхай ч биш, Засгийн ажил ч юм уу, Их Хурлын ажил ч юм уу ойлгомжгүй ийм асуудал хийхээ боливол яасан юм бэ?

Тэгээд энэ Эдийн засгийн байнгын хороон дээр яг энэ тогтоолын төслийг хэн боловсруулсан юм бэ, Заяабал дарга өөрөө боловсруулсан юм уу? Энэ чинь аягүй ойлгомжгүй байгаад байна шүү дээ. Тэгээд энэ чинь бидний бид бүхний нэрээр явна гэсэн үг шүү дээ. Тэгээд ийм хэнд ч хэрэггүй баахан цаас үйлдвэрлэхидэг, дараа нь тэгээд УИХ яг бодит хуулийнхаа хэрэгжилтийн араас, энэ хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийн араас явах гэхээр маш бага хэрэгжилттэй болоод байдаг. Тэгээд хаана хаанаа бид ахиад л хэл ам хийгээд сууна. Тэгэхээр ийм хоёрын хооронд ойлгомжгүй, зорилго нь тодорхой бус зүйлүүд ер нь хийж хаана хаанаа цагаа үрмээргүй байна гэсэн ийм саналтай байна. Тэгэхээр би энэ тогтоолын төслийг ер нь дэмжиж болохгүй гэж байна.

Хэрэв ийм үнэхээр Эдийн засгийн байнгын хорооноос тогтоолын төсөл гаргаад, үнэхээр энэ ЗГ-ын зарим ажлууд нь болохгүй байна гэж үзвэл Байнгын хорооноосоо Байнгын хорооныхоо гишүүдээр ажлын хэсэг байгуулаад, тэгээд тэндээ энэ тогтоолын төслийнхөө тэр бүх шүүсийг нь шахаад, тэгээд батлаад явъя. Эс бөгөөс энэ хаана боловсруулагдсан нь мэдэгдэхгүй ийм зүйл хийчихвэл дараа нь хэдүүлээ хэрэгжилт дээрээ л унана. Намар болохоор энэ нөгөө тогтоолын чинь хэрэгжилт хааччихсан бэ энэ тэр гээд л ахиад яригдаад унана. Тэгэхээр хаа хаанаа ингэж ерөөсөө бие биеийнхээ цагийг үрэхээ больё. Тэгээд ЗГ өөрөө ажлаа түүгээрээ хий. Саяын наад ярьж байсан ажлуудынхаа асуудлуудыг тэгээд өөрсдөө хөөцөлдөөд яв. Их Хурал зүгээр хуулийнхаа хэрэгжилтийг шахаад ажиллая л гэсэн ийм саналтай байна.

Б.Заяабал: Жаргалан гишүүн санал хэллээ. Ер нь өмнөх эдийн засагтай холбоотой энэ асуудлуудыг Эдийн засгийн сайдыг оролцуулаад бид мэдээлэл сонссон. Энэтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдал, энэ геополитикийн нөхцөл байдалтай холбоотой, ирэх намар үүсэж байгаа, үүсэх энэ үнийн өсөлтийн асуудал, одоо байгаа энэ инфляц өндөртэй холбоотой асуудлуудыг ер нь нэг УИХ-ын тогтоол гарч энэ асуудлыг анхааралдаа авах нь зүйтэй гэдэг ийм агуулга яригдсан. Энэний хүрээнд холбогдох ЗГ-ын яамнууд руу албан ёсоор энэтэй холбоотой энэ бодлогууд, ирэх намрыг чиглэсэн энэ богино хугацаатай холбоотой энэ бодлогууд дээр ямар бодлого барьж байгаа вэ, энэтэй холбоотой УИХ-ын

тогтоолын санал дээр санал өгөөч гэсэн ийм саналыг албан ёсоор хүргүүлсэн. Ингээд ирсэн саналууд дээр бид ажиллаад өнөөдөр ингээд Байнгын хорооны тогтоол гарч ирж байгаа юм, боловсруулагдаж байгаа юм.

Энэ санал нь өнгөрсөн тав дахь өдөр манай Байнгын хорооны гишүүдийн групп дээр албан ёсоор тавигдсан. Ингээд тэрнээс хойш зарим нэг гишүүд саналаа өгсөн. Энэ саналаа өгсөн гишүүдийн санал бол одоо тусгагдаж орж ирсэн байгаа. Тэгсэн хэдий ч өнөөдөр энэ Байнгын хорооны тогтоолын төсөл учраас өнөөдрийн энэ хуралдаанаар Байнгын хорооны гишүүд саналаа гаргаж, нэмж хасах эрх нь чөлөөтэй байгаа. Хэрвээ энийг нухацтай авч үзье энийг шаардлагатай гэвэл гишүүд энэ дээрээ бүгдээрээ санал гаргаад, шийдвэрлэх эрх нь манай Байнгын хорооны асуудал байгаа гэдгийг гишүүддээ мэдээлэл болгож хэлье. Дараагийн хүн Жавхлан гишүүн, Жавхлан гишүүн байхгүй байна. Мандхай гишүүн мөн байхгүй байна. Пунсалмаа гишүүний микрофоныг өгье. Пунсалмаа гишүүний микрофоныг шинээр өгье, ахиад эхнээс нь өгье.

Б.Пунсалмаа: Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах, үнийн өсөлтийг бууруулах чиглэл бүхий энэ тогтоолын төслийг хэлэлцэж байгаа юм байна. Ерөнхийдөө энэ заалтуудыг дэмжиж байгаа, тэгээд энэ дотроос нэг асуулт байна. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бууруулах энэ зорилтын хүрээнд энэ жил нөөцийн мах бэлтгэх юм уу гэж ингэж асуух гээд байгаа юм. Ер нь нөөцийн мах бэлтгэх гэдэг өөрөө төсвөөс хүү, зардал, татаас гаргадаг зардалтай. Гэхдээ үнэ буурдаггүй л байхгүй юу. Энэ жил бүр ч энэ нөөцийн махны үнэ бүр өсчихсөн байгаа. Зах зээлийн жамаараа шийдэгдэж байгаа зүйлийг болиулаад, энэ ченжүүд гээд энэ хүмүүс байдаг, тэр нь хөдөө мал дээр байгаа малчид, хотод байгаа иргэдийг энэ мах, сүүгээр холбож байгаа хүмүүс шүү дээ. Энэ холбоосыг нь байхгүй болгох гэж үзээд энэ жил махны үнэ ханш бүр өссөн, зах зээлийн бус ийм хэлбэрээр өссөн. Тэгээд энэ өсөлт ерөөсөө ийм бодит үнийн өсөлт биш байхгүй юу. Энэ буруу бодлогын хямралын үнийн өсөлт болсон шүү.

Хэрвээ үнэхээр бодитоор ийм өсөлт махны үнэ өсдөг юм бол хотын иргэд хөдөө рүү маш олноороо нүүж очоод, мал, мах бэлтгээд ингээд ажиллана. Ингээд эргээд махны үнэ бууна. Тэгэхээр миний гол санаа бид ингэж нөөцийн мах бэлтгэж, ингэж юмыг хиймлээр ийм зохицуулалт хийх гэж ингэж бужигнуулж байхаар энийг зах зээлийнх нь жамаар үлдээх хэрэгтэй. Малчин Монгол ард түмэн мал, махаа бэлтгээд хүргээд, ингээд аваад өгөөд сурчихсан ард түмэн. Тэгэхээр энийг бид заавал ингээд бужигнуулах шаардлагагүй. Хэрвээ ингэж үнийг зохицуулаагүй байсан бол үнэ өслөө, өслөө гэхэд энэ түвшинд өсөхгүй. Энийг зах зээлийн жамаар нь орхиход махны үнэ хэзээ ч энэ түвшинд хүрэхгүй юм шүү. Тэгэхээр энэ жил энэ махны дахиад нөөц бэлтгэдэг ийм бодлогыг дэмжихгүй байгаа.

Б.Заяабал: Пунсалмаа гишүүн санал хэллээ. Гантөмөр гишүүн, Гантөмөр гишүүний микрофон өгье.

Л.Гантөмөр: Үнэхээр ниргэсэн хойно нь хашхирав гэдэг зүйл болж байна. Байнгын хорооны удирдлагууд мэргэжлийн өндөр түвшинд энэ зүйлийг хармаар байгаа. Яг үнэн хэрэгтээ хоршоо нэрийн доор 1.1 их наяд төгрөг гарсан, 1.1 их наяд төгрөг юунд зарцуулсан бэ гэдэг тайланг бид аваагүй байгаа. Эдийн засгийн байнгын хороо энэ тайланг заавал авах хэрэгтэй. Заяабал дарга, ингэж байж эндээс юм харагдана. Бид малчдыг их олон ажил зэрэг хийлгэх гэж шахаж байгаа.

Тариаланч бол, тээвэрчин бол, худалдаачин бол, зоорь агуулах барь, малаа малла. Яг үнэн хэрэгтээ энэ бодлогын ард мал ахуй ойлгодог нэг ч хүн энэ бодлогод оролцоогүй. Мал ахуй ойлгодог хүн малчны хөдөлмөр ямар их вэ гэдгийг ядаж мэднэ. Тэгэхээр бараг энэ Монголын төрд малчин айлын хүүхэд үлдээгүй юм шиг ийм дүр зураг байгаа юм. Зүгээр байгаа хүмүүсээр юм хийлгэх гээд байдаг. Ялангуяа махыг бид орон нутагт, сум болгонд бэлдэнэ гэвэл бүр худлаа, хаана хадгалах юм бэ?

Мах гэдэг чинь хадгалах горимтой бүтээгдэхүүн, сүү гэдэг чинь хадгалах горимтой бүтээгдэхүүн, малаа хаана нядлах юм. Ариун цэврийн горимтой. Ер нь би зүгээр үг аваад Заяабал даргад нэг зүйлийг хүсэх гэж байгаа нь энэ бодлогоо эргэж хараач, 3 жил явлаа, үр дүнд нь махны үнэ 35 мянган төгрөг болсон, 1 их наяд төгрөг зарцуулаад хот хүрээ газрын хүмүүсийн нуруун дээр яг 1 их наядын ачаа үүрүүлсэн нэмээд. Дундын зөрүү мөнгө нь хаачсан бэ? Яг үнэн хэрэгтээ мах бэлтгэл хийгээгүйг Нямбаатарт үүрүүлээд, Нямбаатарыг огцруулсан. Бодитойгоор яагаад мах бэлтгээгүй вэ гэдэг зүйлийн хариуг бид аваагүй, хэн ч мэдэхгүй өнгөрч байгаа. 30 мянган тонн мах хэрэгтэй, Улаанбаатарчууд өвөл, хаврын улиралд хэрэглэдэг хүнс. Монгол Улс нүүдлийн малын аж ахуйтай учраас өвөл, хаврынхаа идшийг намар нь бэлддэг юм. Бусад улсаас ялгаатай юм, энэ цөөхөн суурин аж ахуй энийг нөхөж барахгүй. Тийм учраас яг жинхэнээсээ юу болоод мах тасрав гэдгийн эзнийг олооч гэж би Байнгын хорооны удирдлагаасаа хүсмээр байна. Тэгээд эцэст нь хэлэхэд, ер нь энэ үнийн өсөлтийн ар дээр ирэх давлагаа чинь юу ирэх юм бэ гэдэг дээр тооцоолол хийгээч. Намар юу болох юм бэ, харж байгаа хүн байна уу? Ялангуяа шатахууныг их хэмжээгээр нөөцөлнө гэж байгаа юм. Нөөцөлж болдог эд мөн үү, биш үү?

Б.Заяабал: Гантөмөр гишүүний нэмэлт минут өгье.

Л.Гантөмөр: Манай энэ газрын тосны дарга энийг бодооч. Бензин, түлш 2 чинь нөөцөлж болдог бараа мөн үү? Энэ улс орнууд газрын тос нөөцлөөд байна, бензин тос, шатахуун 2-ыг чинь нөөцлөхөөр энэ үнийн зөрүү нь дийлдэхээ болино, мөнгөний хүүгийн зөрөө дийлдэхгүй. Алга болсон түлш дээр чинь бөөн амьтан шоронд орно. Ганц асуудал байна шүү дээ. Хятадаас бид газрын энэ бензин, дизель хоёроо худалдаж авч чадах юм уу, чадахгүй юм уу нэмэлтээр? Орос дайны байдалд орчихлоо бензин, тосны хувьд. Дэлхий дээр 100 доллар байсан нефть чинь 70 руу орчихлоо. Хятад улсаас бид худалдаж авч чадах уу, үгүй юү гэдгээс бидний намрын амьдрал шалтгаална. Тийм учраас та нар энэ нэг баахан сав, суулга худалдаж авна, баахан татаас өгнө гэсэн энэ худлаа мөрөөдлөө болиод, бодитой дүгнэлт, шинжилгээ хийгээд, яг эдийн засгийн ирж байгаа энэ үнийн дарамт чинь эдийн засгийн дарамт болохгүй.../минут дуусав/

Б.Заяабал: Гантөмөр гишүүн санал хэллээ. Мандхай гишүүний микрофон өгье.

М.Мандхай: Яг энэ тогтоолыг хэлэлцэх эсэх дээр эргэлзэж байна. 2025 оны төсвийн гүйцэтгэл өөрөө маш хангалтгүй, хэрэгжээгүй маш олон хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг бид хэлэлцээд сууж байгаа яг энэ цаг үед дахиад ийм санхүүжилт гаргахтай холбоотой, хөрөнгө оруулалттай холбоотой бараг шахуу ийм тогтоол орж ирж байгаа учраас ер нь дэмжихэд тун хэцүү л байна, яг үнэнээ хэлэхэд. Тэгээд энэ Евразийн түр хэлэлцээрийн хүрээнд малын гаралтай

түүхий эд, энд чинь нөгөө мах, махан бүтээгдэхүүн, хонь, ямаа, үхэр гээд л бид чинь махаа гаргах гээд байгаа. Гэтэл яг энэ хэлэлцээрээр зөрүүлээд бид сүү, тахиа, гурилан бүтээгдэхүүний хүнсний импорт огцом өсөх ийм эрсдэл байгаад байгаа. Яг үнэнээ хэлэхэд 2025 оны төсвийн гүйцэтгэлээр харахад Хүнсний хувьсгал хөтөлбөр өөрөө 40 хувьтай харагдаж байгаа шүү. Тэгсэн мөртөө яг үр дүн нь өөрөө тодорхой бус. Тэгэхээр энэ импортын нөлөө нь өөрөө дотоодын хүнсний үйлдвэрлэлийг ер нь шахах ийм эрсдэлтэй хэлэлцээр харагдаж байгаа.

Тэгэхээр энэ хэлэлцээрээр, энэ хэрэгжиж эхэлснээр хүнсний импорт хэдэн хувиар ер нь өсөх эрсдэл, тооцоо байгаа юу? Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотооддоо өөрийгөө хангах зорилттой зөрчилгүй байх ер нь баталгаа байгаа юу? Энэ дээр нэг бүр протоколтой хариу авъя гэж бодож байгаа юм. Нэмүү өртгийн сүлжээ байгуулах боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг өнгөрсөн жилүүдэд ер нь хангалттай хэрэгжүүлээгүй байна лээ шүү дээ, 2025 оны төсвийн гүйцэтгэл дээр ч гэсэн. Тэгэхээр энэ удаа яг ямар шинэ механизмыг дэмжиж байгаа юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Дээрээс нь энэ ургамал хамгааллын бодис, эрдэс бордоо, шатахууны хөнгөлөлт эдгээр энэ санхүүжилтийг өгснөөр тариалангийн бүтээгдэхүүний өртөг хэдэн төгрөгөөр буурна гэж харж байгаа вэ? Хөдөлмөр эрхлэлт, ургацын өсөлт яг ямар түвшинд нэмэгдэх тооцоо гарсан уу? Тэгээд энэ эцсийн үр дүнд би дахиад л хэлээд байгаа юм. Шалгуур үзүүлэлтээр энэ удаагийн биелэлтийн шалгуур нь өөрөө энэ төсөв зарцуулалтаас гадна инфляц буурах, буурсан байдал, иргэдийн хүнсний сагсны зардал хэдэн төгрөгөөр хэмнэгдсэн, мах, гурил, хүнсний ногооны үнэ хэдэн хувиар тогтвортой болсон зэрэг би яг энэ бодит үр дүн, үзүүлэлтүүдийг асуумаар байна.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 8 дугаар номер уу? Гишүүний асуултад нэмэлт тодруулга 8 дугаар номероос эхэлье.

Ц.Болорчулуун: Мандхай гишүүний асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр энэ тогтоолоор нэг тийм татаас өгөөд, хөнгөлөлт, чөлөөлөлт өгөөд ингээд яваад байх асуудал байхгүй. Тэгэхээр энэ дээр хуучин 2008 оноос эхлээд энэ ХАА-н гаралтай техник, трактор, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоог гааль, НӨАТ-ын татвараас үе шаттай чөлөөлж ирсэн энэ асуудал орсон байгаа. Тэгээд одоо энэ хуулийн үйлчлэх хугацаа дуусаад хүчин төгөлдөр ингээд хууль хэрэгжээд татвар аваад явж байгаа. Зүгээр энэ татварын зохицуулалтаар дэмжих боломж байна уу гэсэн энэ асуудлыг л оруулсан.

Яагаад гэвэл дэлхийн зах зээл дээр энэ бордооны үнэ, ургамал хамгааллын бодисын үнэ огцом үнийн өсөлттэй байгаа. Тэгээд энэ шатахууны үнэ ч гэсэн тогтвортой биш байгаа учраас энэ татварын зохицуулалт байвал цаашдаа одоо байгаа хэмжээндээ үнэ тогтвортой байх болов уу гэдэг үүднээс энэ заалт л орсон. Өөр энэ дээр тийм нэмж олгоод байх зээл, татаасны асуудал энд тусгагдаагүй байгаа гэдгийг хэлье. Тэгээд Хүнсний хувьсгал дээр энэ хөтөлбөрүүд хэрэгжээд явж байгаа. Тэгээд Хүнсний хувьсгал хөтөлбөр ингээд жил жилээр тайлангууд гараад, хөтөлбөрийн ерөнхий үр дүн ингээд 6 сар, энэ 6 сараар дуусаж байгаа учраас ерөнхийдөө гарна. Энэ дээр тэгээд тухайн бүтээгдэхүүн болгоноороо ямар үр дүн

гарсан, ямар дэвшил гарсан, зарим нэгэн дээр нь ямар нэгэн ахиц дэвшил гараагүй бол гэдгээрээ энэ тайлангаар тодорхой гарна.

Евразийн хэлэлцээрийн хүрээнд мэдээж энэ 367 бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой, 367 бүтээгдэхүүнийг харилцан импортолж, экспортлохтой холбоотойгоор мэдээж том зах зээлээс, 5 улсаас орж ирэхэд энэ хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүн дээр савлагаа, үнийн дотоодын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөх ийм нөхцөл байдал болзошгүй гэдгийг үгүйсгэх аргагүй юм гэж хэлье.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга хэд вэ, 6 дугаар номер уу? 6 дугаар номер нэмэлт тодруулга өгөөрэй.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яам Мөнх-Эрдэнэ. Энэ тогтоолын төслийн 5 дугаар заалтын хүрээнд түүхий эд, ноолуур, арьс, шир гээд энэ бүтээгдэхүүнүүдийн экспортыг дэмжих Евразийн худалдааны түр хэлэлцээртэй ийм заалт томъёологдсон байна. Миний хувьд болохоороо Евразийн хэлэлцээрийг хариуцсан Худалдааны газрын дарга биш учраас таны асуусан импортоор орж ирэх бараануудын прогноз, тооцооллыг яаман дээр очоод албан бичгээр бэлдээд хүргүүлэх ийм хүсэлтэй байна.

Б.Заяабал: Мандхай гишүүний нэмэлт минут өгье.

М.Мандхай: Үгүй ээ, ийм байгаа юм. Бид нэг ийм нэг жил, жилд нэг шинэ хүмүүс орж ирж сууж байгаа юм шиг байдлыг ийм хариулт ерөөсөө, яагаад тэгвэл энэ хариуцлага хүлээгээд сууж байдаг энэ тогтоолыг оруулж ирж байгаа дарга, сайд нар нь өөрсдөө орж ирж хариулахгүй байгаад байгаа юм бэ? Ямар ч хариуцлага хүлээхгүй ийм нөхдүүд орж ирчхээд хариулж ч чадахгүй, ингээд бид нараар цаг үрээд ингээд хэлэлцүүлээд байгаа байхгүй юу. Тогтоолын хэрэгжилтийг тоон, чанараар нь шалгуураар гаргаж, 2027 онд тайлагнана гэж заасан байгаа шүү дээ та хэд. Тэгээд энэ өмнөх жилүүдийн тайлангууд чинь угаасаа 2025 онд төсвийн гүйцэтгэл дээр дэд бүтэц нь зогсчихсон, төсөв зарцуулалт нь 30-аас 50 хувьд хүрчихсэн, тэгээд 100 хувь гээд өөрсдөө үнэлчихсэн байгаа. Үгүй ээ, тэгээд үнээ тогтворжуулахгүй юугаа хийж байсан юм бэ энэ олон хэдэн их наядаар нь төсөв, санхүүжилт гаргачхаад. Дахиад ингээд ийм гоомой юм оруулж ирээд бид нараар хэлэлцүүлэх гээд суугаад байх юм. Энэ дараагийн удаа энэ сайд нарыг нь оруулж ирж, өөрсдөө хариуцлагатай хариулт авмаар байна.

Б.Заяабал: Мандхай гишүүн санал хэллээ. Тэгэхдээ энэ манай ЗГ-аас орж ирж байгаа Их Хурлын тогтоол биш, манай Байнгын хорооноос орж ирж байгаа тогтоол. Тийм учраас Байнгын хорооны гишүүд энэ дээр саналаа өгөөд өөрчлөх эрх нь бүрэн нээлттэй байгаа. Тийм учраас би энэ тогтоолын төсөл дээр Байнгын хорооны гишүүд бүрэн санал нь тусгагдаагүй байгаа учраас энэ асуудлыг хойшлуулах нь зүйтэй юм байна даа гэсэн ийм саналтай байгаа. Ямар ч байсан гишүүд саналаа хэлээд, дараа нь бүгдээрээ шийдье. Очирбат гишүүний микрофон олгоё.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Би ч Эдийн засгийн байнгын хорооны дарга Заяабал даргыгаа нэлээн төрийн хүн болсон, асуудлыг олон талаас нь хардаг, шийдвэр гаргахдаа бодитой гаргадаг гэж харж явдаг хүний нэг. Сүүлийн үеийн шийдвэрүүд ингэж гарахгүй байна, дандаа улс төржиж байна. Дарга ах

нарынхаа захиалгаар Байнгын хороог удирдах гэж оролдож байна шүү. Тэгэхээр Заяабал Байнгын хорооны дарга энэ дээрээ анхаараарай нэг.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад энэ төслийг Эдийн засгийн байнгын хорооноос Их Хурлын гишүүд ороогүй, асуулт асууя гэхээр Байнгын хорооны тогтоолын төсөл гэгчихдэг, тэгээд гишүүд нь, сайд нар нь байх ёстой гэхээр наадах чинь Байнгын хорооных шүү дээ гэгчихдэг. Ингээд нэг ам хаасан маягаар яваад байхаар юу асуух вэ, хүндрэлтэй байдалд орж байна шүү. Тэгэхээр Их Хурал нь Их Хурлынхаа ажлыг, гүйцэтгэх засаглал нь гүйцэтгэх засаглалынхаа ажлыг хиймээр байгаад байгаа юм.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад 3 асуулт асууя. Тогтоолын төслийн нэг дээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх замаар экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах гэгчхэж байгаа юм. Тэгэхээр энэ яг биржээр манай энэ дотоодын компаниуд өрсөлдөж орж чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юу өнөөдрийн нөхцөл байдал? Миний авч байгаа мэдээллээр энэ нүүрсийг угаадаг юм уу, хуурайгаар баяжуулдаг юм уу, тэр компаниуд юмаа авч чадахгүй байна гээд байгаа. Дархантай холбоотой энэ төмрийн баяжмалаа бид нар хуурайгаараа, тийм үү, нойтноор баяжуулъя гэхээр тэр түүхий эдээ авч чадахгүй байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ цаашдаа ер нь яах юм бэ? Энэ Эрдэс баялгийн яамнаас ирчихсэн байна. Цаашдаа дотоодынхоо энэ баялаг бүтээгчдийг яаж дэмжих юм бэ?

Дараагийнх нь Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн авах Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татварын маргааныг эцэслэн шийдвэрлэх гэж байгаа юм. Энэ дээр чинь хэдэн төгрөгийн асуудал яг яригдаад байгаа юм бэ? Эцэслэн шийдвэрлэнэ гэхээр энэ Их Хурлын тогтоол гаргаж авч байгаад тэглүүлэх гээд байгаа юм уу татварыг нь, энэ дээр нэг хариулт авчихъя.

3 дахь нь нөөцийн мах бэлтгэнэ гэж байгаа юм. Нөөцийн махтай холбоотойгоор энэ жил махны асуудал үүссэн, хэдэн компани авсан юм бэ? Яг миний авч байгаа мэдээллээр энэ Европ, ази руу ч юм уу, энэ гадагшаа экспортолж байгаатай холбогдуулаад нөөцөлсөн махнуудаа түрүүлээд гаргаад үнэтэй зарчихсан, тэгээд нийгэмд хомсдол үүссэн гээд байгаа юм. Энэ үнэн үү, худлаа юу? Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас байгаа дээр нь асуугаад авъя.

Дараагийнх нь 5 дээр нь газар тариалангийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай дизель түлш, эрдэс бордоо, ургамал хамгааллын бодисыг дотоодын үйлдвэрлэгч болон импортлогчдод хөнгөлөлттэй зээлээр хангах, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын зохицуулалтаар дэмжих гэж байгаа юм. Ингэхээр дахиад л тэгш бус байдал үүсээд байгаа байхгүй юу. Хэн нэгэн компанид давуу эрх олгох ийм тогтоолын төсөл орж ирээд байгаа юм. Тэгэхээр өрсөлдөөнт зах зээлд чинь болохгүй. Тэгээд ийм асуултад хариулт авъя.

Б.Заяабал: Манай гишүүд, энэ манай Байнгын хорооноос гаргаж байгаа тогтоол. Байнгын хорооны гаргаж байгаа тогтоол дээр ЗГ-аас дэмжлэг үзүүлэх ийм ажлын хэсгийг ажиллуулсан. Тийм учраас энэ ЗГ-ын холбогдох яамдын газрын дарга нарыг өнөөдрийн энэ Байнгын хорооноос боловсруулж байгаа тогтоол дээр дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байгаа ажлын хэсгийг оруулж ирсэн байгаа

гэдгийг нэмэлт мэдээлэл болгож хэлье. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд энэ Байнгын хорооноосоо гаргаж байгаа тогтоолын төсөл дээр бүрэн санал өгөх эрх нь нээлттэй, өөрчлөх эрх нь бүрэн нээлттэй байгаа шүү гэдгийг хэлье. Ингээд саяын гишүүний асуусан асуултад нэмэлт тодруулга өгье. 8 дугаар номероос эхлэх үү? 8 дугаар номер.

Ц.Болорчулуун: Очирбат гишүүний асуултад хариулт өгье. ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр Хүнсний тухай хуулиараа нөөцийн мах, аюулгүй нөөц бүрдүүлэх нь аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгчихсөн байдаг. 2023 оноос хойш энэ хаврын нөөцийн махны асуудлыг нийслэл дангаараа хариуцаж явж байгаа. Энэ жилийн тухайд нийслэл хариуцаж явж байгаад хавар нөөцийн мах байна, байхгүй гэдэг асуудал гараад, ЗГ-ын хуралдаан дээрээс байгаа үлдэгдэл махыг зах зээлд гаргаж нийлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийг ХХААХҮ-ийн сайдад даалгаснаар бид энэ асуудал руу, энэ борлуулалттай нь холбоотой, үлдэгдэл махны асуудалтай холбоотой асуудал дээр яам тодорхой хэмжээнд ажилласан. Авсан мэдээллээр нийтдээ 7 аж ахуйн нэгж 5071 тонн нөөцийн махыг бэлдсэн. Энэ хэмжээндээ тодорхой хэмжээнд энэ дутуу гэдэг нь хяналт шалгалтын байгууллагынхаар тогтоогдсон. Энэнээс цаашаа мэдээлэл байхгүй байгаа. Түрүүлж зарсан эсэхийг нь бид нар мэдэхгүй, тэрэн дээр угаасаа хяналтын байгууллагууд шалгалт орсон байх.

Хоёрдугаарт, энэ 5 дугаар заалттай холбоотой түрүүнд хэлсэн гаалийн болон НӨАТ-ын нэмэгдсэн өртгийн албан татвар ингээд тухайн нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгож байгаа биш. Ер нь газар тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай трактор, комбайн, техник, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоо гээд үндсэндээ тариалангийн үйлдвэрлэлд ордог 5 том орц нь өөрөө 100 хувь импортын хамааралтай байгаад байгаа юм. Тийм учраас энэ дээр Монгол Улсын ЗГ-аас, УИХ-аас удаа дараа шийдвэр гаргаж, энэ гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас үе шаттай чөлөөлж ирж байсан. Сүүлийн 5 жилийн хугацаанд энэ татварын чөлөөлөлтийн асуудал зогссон учраас, одоо дэлхийн зах зээл дээр үнэ өсөж байгаатай холбоотойгоор энэ татварын зохицуулалт хийгээд, сэргээгээд явбал гадаад зах зээл дээр огцом өсөж байгаа энэ тариалангийн гол орцуудыг тодорхой хэмжээнд бууруулах, үнийг бууруулах ийм боломж байна уу гэж л энэ заалт орж байгаа гэж ойлгож болно.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга 6 дугаар номер.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засгийн хөгжлийн яам Мөнх-Эрдэнэ. Энэ тогтоол үнийн өсөлтийг хамгаалахад чиглэсэн заалтууд байгаа. Тэгээд бид нар дэмжих ажлын хэсгийн хүрээнд мэдээлэл өгөхөд одоо инфляц 11.2 хувьтай байна. Үүнээсээ 8.3 нэгж хувь нь дотоодын гаралтай барааных, харин 2.8 нэгж хувь нь буюу энэ нь импортын гаралтай барааных байна. Өөрөөр хэлбэл бид нар экспортыгоо дэмжсэнээрээ валютын ханшаа тогтворжуулаад, валютын нөөцөө нэмэгдүүлж байгаа учраас энэ импортын инфляцыг хязгаарлах сайн нөлөөтэй гэж үзээд, тогтоолын төсөл дээр уул уурхайн биржийн арилжаагаар экспортыг нэмэгдүүлэх гэсэн ийм заалт орж ирж байгаа. Тэгээд уул уурхайн биржийг ажиллуулснаараа биржийн бус үетэй харьцуулахад үнэ дунджаар 20-оос 30 хувиар нэмэгдэж байгаа ийм тооцоонууд байдаг. Тэр зорилго нь ийм байгаа юм.

Б.Заяабал: 7 дугаар номерын микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Очирбат гишүүний асуулттай холбоотой нарийвчилсан хариултыг би холбогдох газрын даргаас аваад бичгээр танд хүргүүлье. Яг одоо надад мэдээлэл нь алга, биржтэй холбоотой. Би газрын тосны асуудал.

Б.Заяабал: Тэгье, гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. УИХ-ын тухай хуулийн Байнгын хорооны даргын чиг үүрэг дээр байгаа. Байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулах гэсэн чиг үүргийн дагуу, 26.1.1-ийн дагуу УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос бэлтгэн боловсруулж байгаа УИХ-ын тогтоолын төсөлтэй холбоотойгоор Байнгын хорооны гишүүд үг хэлсэн гишүүд, нийт 7 гишүүн үг хэлсэн, санал хэлсэн. Бүгдээрээ саналууд хэлсэн учраас энэ саналуудыг бүгдийг нь тусгаж, уг тогтоолыг дахин найруулж, хэлэлцэх нь зүйтэй гэж ингэж үзэж байна. Тийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас уг УИХ-ын тогтоолыг хойшлуулъя. Гишүүд энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор саналаа ирэх 7 хоногийн нэг дэх өдрөөс өмнө та бүхэн саналаа ажлын албанд ирүүлэхийг хүсье. Ажлын алба хүлээж авч, найруулгыг бэлтгэж, Байнгын хорооны гишүүддээ эргэн танилцуулъя.

16.09 цаг

Гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудлын 4 дэх асуудал байгаа. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд танилцуулна. Энхбаяр сайдыг микрофонд урья. 5 дугаар номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахаар тусгасан. Монгол Улс газрын тос боловсруулах үйлдвэрийг 2028 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж, түүхий тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажил дуусах шатдаа орж байна. Иймд газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинэ орд газар илрүүлэх, баталгаат нөөцийг өсгөх зэрэг эрх зүйн болон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт, олборлолт тасралтгүй буурч байгаа бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой хууль тогтоомжийн зөрчил, эрх зүйн тогтворгүй байдал үүнд нөлөөлж байна. Иймд 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр

батлагдсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд үүсээд буй олон жилийн маргааны асуудлыг шийдвэрлэх, өмнө байгуулсан гэрээний тогтвортой байдлыг хангах, газрын тосны хөрөнгө оруулалт, олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор ЗГ-аас Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан хуулийн төслийг нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Монгол УИХ-д өргөн мэдүүлж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар 1991 оны Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний тогтвортой байдлыг хангаж, гэрээнд заасан татвар, шимтгэл, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг гэрээний дагуу хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэх болно. Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийг танилцуулъя. Энхбаяр Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, зэрэгцээд Төсвийн байнгын хорооны хурал явж байгаа. Төсвийн байнгын хорооноос дуудаарай. Маргад Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга, Цогтнаран Татварын ерөнхий газрын дарга, Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүд байна.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн ирцийн дарааллаар. Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Энэ юуны газрын тосны 19 дүгээр талбай газрын тосны нөөц ашигласны төлбөрт хамрагдахгүй байхаар байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Энэ дээрээ нэг дахиад нэг сайн тайлбар өгөөч. Яагаад хамрагдахгүй байгаа билээ? Газрын тосны нөөц ашигласны төлбөр чинь ерөнхийдөө 5-аас 15 хувьтай байгаад байдаг. Гэтэл 19 дүгээр талбай хамрагдахгүй гээд байгаа. Энэ дээр нэг тайлбар өгөөч?

Б.Заяабал: Хэдэн номер вэ? Ажлын хэсгийн 6 дугаар номерын микрофоныг нээе.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. 1991 оны Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ажиллаж байгаа тохиолдолд газрын тос олборлосны төлбөрийг Бүтээгдэхүүн хуваах тооцоонд оруулж болно гэж заасан байдаг. Тосон-Уул 19 дүгээр талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8.1-д төлбөр рояалти /royalty/ нь ашигт тосны Монголын ногдох хэсэгт багтана гэж заасан байдаг. Тэгэхээр нөөц ашигласны төлбөр бол Монголын талд оногдож буй хэсэгт орсон гэж шууд ойлгож болно. 2014 онд Газрын тосны тухай хууль өөрчлөгдөөд, шинэчилсэн найруулгаар 5-аас 15 хувь байна гэж заасан. Үүнтэй холбоотой ямар нэгэн байдлаар тодорхой тэдэн хувь нь нөөц ашигласны төлбөр гэж гэрээн дээр тусгаж өгөөгүй учраас автоматаар хамгийн

доод хэмжээ буюу 5 хувиар тооцоод Үндэсний аудитын газраас тодорхой хэмжээний төлбөр тооцоонууд акт тавьсан байдаг. Бодит байдал дээр гэрээн дээрээ Монгол Улсын ЗГ-т ногдох хувь хэмжээнд орсон байгаа гэдэг, хуулийн төсөл дээр 5 хувь гэж тодорхой болгож зааж өгөхөөр оруулсан байгаа.

Б.Заяабал: Соронзонболд гишүүний нэмэлт минут өгье.

Л.Соронзонболд: Тэгэхээр 19 дүгээр талбай маань 5 хувиар цаашдаа тооцогдож бодогдож авах юм байна гэж ойлголоо. Зөв үү? За.

Б.Заяабал: Очирбат гишүүн.

Г.Очирбат: Хуулийн төсөлтэй холбоотой ер нь энэ хуваалт болон татвар, шимтгэлийг тухайн гэрээнд заасан хувь хэмжээгээр зохицуулна гэж өөрчилсүгэй л гэхгэж байгаа юм. Энэ яг хэнд хамаарч үйлчлэх гэж байна, ямар аж ахуйн нэгжид хамаарч үйлчлэх гэж байна, хэдий хэмжээний энэ татвар, шимтгэлийн асуудал яригдах гэж байна вэ? Ер нь цаашдаа энэ хэчнээн үр дүн үзүүлэх вэ, энэ хуулийг ингэж өөрчилснөөрөө? Тэгээд яг тодорхой компанийн нэртэй, хувьтай, мөнгөн дүнтэй мэдээлэл авчхаад, тодруулъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн хэдэн номер вэ? 6 дугаар номерын микрофон нээе.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. 1991 оны Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулагдаж, ашиглалтад шилжсэн 3 талбай хамрах Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг энд дурдаж байгаа. Нэгдүгээрт, Тосон-Уул 19 дүгээр талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээ, Тамсаг-21 дүгээр талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ 97 дугаар талбайн гэрээнүүд тус тус энд багтана. Уг 3 талбай, 19, 21 дүгээр талбай дээр бүтээгдэхүүн хуваах гэрээний эрхийг хэрэгжүүлж буй Петрочайна компанийн хувьд 2013-аас 2024 оны хооронд хамрагдсан татварын шалгалтаар ААНОАТ, нэмэгдсэн өртгийн албан татвар, хүн амын орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар гэх нийт 703 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа. Доншен компанийн хувьд дээрх татваруудтай адил 23.8 тэрбум төгрөгийн татвар, өөрөөр хэлбэл 11 жилийн хугацаанд үүссэн татварын асуудлыг тодорхой болгохоор хуулийн төслийг боловсруулсан.

Б.Заяабал: Энхбаяр сайдын микрофон 5 номер.

Ж.Энхбаяр: Монгол Улс 1991 онд Газрын тосны хуулийг батлаад, газрын тосны салбарт гаднын хөрөнгө оруулалтыг урьсан байдаг. Ингээд анх Америкийн хөрөнгө оруулалттай SOCO компани манай зүүн бүсийн талбарт геологи, хайгуулын ажил хийгээд газрын тосыг илрүүлсэн. Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Очирбат очиж, дээлээ газрын тосоор мялааж байсныг бид ингээд бодоход тэрнээс хойш 35 жил өнгөрсөн байна. Ингээд Соко интернэйшнл /SOCO International/ компани эзэмшиж байсан лиценз, талбайгаа Хятадын Петрочайна /PetroChina/ компанид шилжүүлээд, Монгол Улсаас хөрөнгө оруулалтаа татсан. Петрочайна компани 2 талбай дээр, Тамсаг-21 дүгээр, нөгөөдөх нь Тосон-Уул 19 дүгээр гэсэн 2 талбай дээр 4 тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалтыг хийж, газрын тосны эрэл, хайгуулыг идэвхжүүлсэн. Ингээд хамгийн оргил үедээ.../минут дуусав/

Б.Заяабал: 5 номерын микрофоныг дахин нээе.

Ж.Энхбаяр: Сая 500 орчим, би жоохон алдаж магадгүй шүү, гэхдээ сая 300-аас сая 500-гийн хооронд тонн газрын тос олборлож, экспортолдог хэмжээнд хүрсэн. Улмаар энэ компанитай 93, 95, 97 онуудад Бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улс байгуулж ажилласан байна лээ, яг олон улсынхаа жишгийн дагуу. Ингээд 2012 оноос хууль, эрх зүйн орчныг шинэчилсэн, татварын багц хууль шинэчлэгдсэн, Газрын тосны тухай хуулийг шинэчилсэн. Ингээд 2013 оноос бид анх байгуулсан гэрээнээсээ давсан шаардлага буюу шинэ хуулийн хүрээнд татвар нэхэж эхэлсэн. Энэ асуудлыг хөрөнгө оруулагч тал хүлээн зөвшөөрөөгүй. Анх хөрөнгө оруулахдаа амласан, байгуулсан гэрээ, бүтээгдэхүүн авах гэрээгээ мөрдөх ёстой гэдэг ийм байр суурьтай ингээд шийдэгдэхгүй акт, торгууль нь нэмэгдээд байдаг, асуудал шийдэгдэхгүй.../минут дуусав/

Б.Заяабал: 5 номерын микрофоныг дахиад нээе.

Ж.Энхбаяр: Хуримтлагдсаар байгаад өнөөдрийг хүрсэн. Ингээд Монгол Улсын хамгийн эмзэг байдал бол нефть бүтээгдэхүүн байгаа, 100 хувь импортоос хамааралтай. Гадаад аюулгүй байдлын орчинд гарч байгаа өөрчлөлт энийг улам бүр тодруулж байна. Иймд дотооддоо газрын тос боловсруулах нь үндэсний аюулгүй байдал, үндэсний эдийн засаг, эрх ашигт чухал ийм стратегийн гол чиглэл. Энэтхэг улсын ЗГ-аас нэн хөнгөлөлттэй зээл аваад 1.5 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулж байна, 2028 онд дуусах төлөвлөгөөтэй. Ингээд газрын тосны орд газраас түүхий нефтиэ татах дамжуулах хоолойг үндсэндээ бариад дуусаж байна. Гэтэл энэ хууль, эрх зүйн орчин, үүссэн маргаантай холбоотойгоор газрын тосны олборлолт тасралтгүй буурсаар байгаад өнөөдөр 200, 300 мянган тонны түвшинд хүрсэн. Энэ асуудал нь ингээд шийдэгдэхгүй хоёр улсын ЗГ-ын хоорондын, хоёр улсын харилцааны асуудал болж хувирсан. Ингээд энийг нэг шийдэхээр хувилбарыг боловсруулаад ЗГ-аас энэ асуудлыг.../минут дуусав/

Б.Заяабал: Очирбат гишүүн.

Г.Очирбат: Яах вэ, энэ нөгөө газрын тосны үйлдвэртэй холбоотойгоор асуудлыг ойлгож байгаа, хүнд байгаа гэдгийг чинь ойлгож байгаа. Түүхий эдээ татаж авчирч ирэхэд ч ер нь хүндрэлтэй байгаа шүү дээ, бүгд ойлгож байгаа. Тэгэхдээ энэ хоёр улсын хоорондох асуудал нэгд хөндөгдөж байгаа байх, хоёрт гэвэл Петрочайна гэдэг компанитай олон удаагийн хэлэлцээр хийж манай татварынхан ч тэр, иргэд ч тэр, олон удаагийн мэргэжлийн яамнууд ч гэсэн олон удаагийн уулзалт хийж асуудлууд хүндэрдэг. Тэгээд яг одоо энэ хуулийг ингэж өөрчилснөөрөө түрүүн бараг тэр 703 тэрбум, бараг 800 гаран тэрбум төгрөгийн асуудал яригдах гэж байна шүү дээ. Тэгэхээр энийг Энхбаяр сайдаа нэгэнт нөхцөл байдал ингээд тулчихсан юм чинь ил хэлчих хэрэгтэй. Яг хэчнээн төгрөг бид нар татвар дээрээс нь, татварын маргааныг нь шийдээд хүчингүй болгох гэж байгаа юм, яг энэ үлдэж байгаа юм гээд ойлголтоо их зөв өгөхгүй бол манай Дорнодын зүүн бүсийн иргэд гэж энэ чинь харж байгаа, тийм биз? Мөн дээрээс нь энэ дээр чинь улс төрждөг олон хүмүүс байгаа, харж байгаа.../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсэг нэмэлт хариулт өгөх үү? 5 дугаар номерын микрофон.

Ж.Энхбаяр: Анхны хөрөнгө оруулалт хийгээд, уриад ажил эхэлсэн гэрээ бол бүтээгдэхүүн, хэрвээ хөрөнгө хийгээд газрын тос олбол бүтээгдэхүүнээ хуваана гэдэг гэрээ байгаа. Бидний гаргасан асуудал юу вэ гэвэл шинэ хуулийн орчныг үүсгээд, бүтээгдэхүүн хуваах гэрээгээ мөрдөхгүйгээр шинэ хуулиараа татвар ногдуулна гэж эхэлсэн. Ингээд маргаан үүссэн, шийдвэрлэгдээгүй өнөөг хүрсэн. Энэ дээр Петровича Дачин Тамсагтай холбоотой нийт нийгмийн даатгал, ажлын байрны төлбөр, орон нутгийн төлбөртэй холбоотой 16.3 тэрбум төгрөг, Петровича Дачин Тамсагтай холбоотой татвар, нийгмийн даатгал, гааль, НӨАТ-тай холбоотой нийт 727.2 тэрбум төгрөг, Доншен газрын тос компанитай холбоотой 8.6 тэрбум.../минут дуусав/

Б.Заяабал: 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Ер нь товчлоод ингээд базаад хэлбэл Петровичатай холбоотой 727.2 тэрбум төгрөг яг өнөөдрийн байдлаар, Доншен газрын тос компанитай холбоотой өнөөдрийн байдлаар 34.7 тэрбум төгрөгийн ийм маргаан үүссэн. Ингээд маргаан хоёр талаасаа шийдэхийн тулд агентлагийн түвшинд 4 ажлын хэсэг ажилласан. Яамны түвшинд 4 ажлын хэсэг ажилласан. Ерөнхий сайдын захирамжтайгаар 6 ажлын хэсэг ажиллаад, би зургаа дахь ажлын хэсгийг хариуцаж энэ хэлэлцээрийг хийж байна. Ингээд бодит байдал яг ийм эрх зүйн орчны тодорхойгүй байдалтай холбоотойгоор ийм байдал үүсчихсэн. Энийг нэг мөр шийдье. Яагаад гэвэл өнгөрсөн 35 жилийн хугацаанд газрын тосны салбарт өөр хөрөнгө оруулалт нэмж орсонгүй. Хийсэн хөрөнгө оруулалт маань үр ашиг нь тасралтгүй буурсаар байгаад, сая 500 хүрсэн олборлолт маань одоо 200, 300 мянга руу унаж байна. Энэ асуудлаа шийдэхгүй бол хөрөнгө оруулалтын цаашид эрэл, хайгуул бүрэн зогсох.../минут дуусав/

Б.Заяабал: 5 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Гэдгээ хөрөнгө оруулагч талаас илэрхийлсэн. Ингээд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, нөгөө хууль, эрх зүйн орчин ойлгомжтой, тодорхой болох ажлын хүрээнд бид нар энэ асуудлуудыг оруулж байгаа. Энэ бол тэглэх асуудал биш. Энэ газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан агуулгуудаараа та нар хуулиа хэрэгжүүлээч гэдгийг тавьж байгаад, бид бүтээгдэхүүн хуваах гэрээгээр авч байгаа тэр хураамждаа энийгээ тооцоод, шимэгдүүлээд тооцоогоо л хаана гэсэн үг. Энийг бид нар 3-аас 5 жилийн дотор суутган тооцоод л шийдчих болов уу гэж бодож байна. Нэгэнт ийм татварын акт үүсчхээд байдаг. Гэтэл бидний анх байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гарсан газрын тосны чинь 30 хувь байх, 30 хувийг нь Монгол Улс чинь шууд авчхаж байгаа шүү дээ. Бид түүн дотроосоо суутгаад энийгээ шимэгдүүлнэ гэсэн үг байхгүй юу. Харин энэ тоо нь, саяын хоёр тоо нь тэр. 727.2 Петровича.../минут дуусав/

Б.Заяабал: 5 номер.

Ж.Энхбаяр: Доншен газрын тос компанитай 34.7, ингээд нийтдээ 761.9 тэрбум төгрөгийн татвар, нийгмийн даатгалын, НӨАТ-ын энэ актыг бид Монголын талын ногдож байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр авч байгаа үнэдээ суутгаад,

ингээд тооцъё. Ингээд цаашдаа хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, хайгуул, олборлолтоо нэмэгдүүлье гэсэн ийм зүйл. Байнгын хорооны даргаа, танилцуулгууд, энэ РРТ бэлэн байгаа. Ажлын хэсэг зөвшөөрөл өгвөл энэ дээр маш дэлгэрэнгүй ингээд танилцуулахад бэлэн байна шүү.

Б.Заяабал: Тодруулга уу, Очирбат гишүүний тодруулга өгье.

Г.Очирбат: Ингээд 761.9 тэрбум төгрөгийн асуудлыг бүтээгдэхүүн хуваах гэрээгээрээ зохицуулъя гэж байгаа юм байна. Яах вэ, хэлэлцээрээ та хэд 6 удаагийн ажлын хэсэг гараад, хамгийн сүүлийнхийг нь Энхбаяр сайд хариуцаад явж л байгаа юм байна л даа. Тэгээд хэлэлцээрээ энэнээс сайн үр дүнд хүргэх боломж байхгүй байсан уу? Магадгүй түрүүн илтгэл дээр тавигдаж байна, хоёр улсын хоорондын асуудал гээд мэдээж нюанстай асуудлууд байдаг л байх. Тэгэхдээ Энхбаяр сайд, Эдийн засаг, хөгжлийн яамны сайдын хувьд Монгол Улсдаа илүү хэрэгтэй боломж, бололцоонуудыг эрэлхийлсэн үү? Энэ талаар олон асуултууд хөвөрдөг, тийм биз?

Б.Заяабал: 5 дугаар номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Петрочайна Дачин Тамсаг компанийн хувьд Монгол Улсад 4.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Өнгөрсөн хугацаанд газрын тос хуваах гэрээгээр 1.8 тэрбум төгрөгийн орлого буцаан олсон байна. Одоо 2.5 тэрбум төгрөгийн нөхөж авах дутуу буюу өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд ийм л эдийн засгийн үр өгөөжтэй байна. Энэ юу харагдаж байна гэвэл газрын тос гэдэг эрсдэлтэй салбар юм. Хөрөнгө оруулалтаа ийм урт хугацаанд нөхдөг юм байна, 30 жил орчихсон байхад хөрөнгө оруулалтынхаа 50 хувийг нь ч нөхөж чадаагүй байж байна.

Хоёрдугаарт, өөр Монгол Улсад бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад хөрөнгө оруулсан ямар ч гаднын компани алга байна. Энэ маань манай газрын тосны салбарт үйлчилж байгаа эрх зүйн орчин бид нар алджээ, буруу байна л гэсэн үг. Тэгэхээр энийгээ анхны олон улсын зарчим болсон бүтээгдэхүүн хуваах гэрээндээ тулгуурлаад энийгээ.../минут дуусав/

Б.Заяабал: 5 дугаар номерын микрофон.

Ж.Энхбаяр: Бүтээгдэхүүн хуваах гэрээ маань их шударга. Газрын тос гарвал 30 70-аар нь л хуваана гээд тохирчихсон. Тэр 30 хувьдаа манайх ямар ч эрсдэлгүйгээр гарах юм бол 30-аа авчихна, гарахгүй бол хөрөнгө оруулагчийн эрсдэл гээд яг л ийм суурь гэрээ нь тэр. Гэтэл бид нар нэмж баахан татварын хууль өөрчилж байгаад татвар тавих гэж оролдсон. Энэ 2012 оноос энэ эрх зүйн орчныг өөрчилсөн. Тухайн үед газрын тосны үнэ баррель нь 100-аас дээш гараад эхлэнгүүт бид нар илүү татвар авах гэж оролдсон. Тэгээд газрын тос тэрнээс хойш унасан, тэгээд энэ үр дүн гараагүй. Өнгөрсөн хугацаанд 12 сая тонн газрын тос олборлож, Монгол Улс 3 их наяд төгрөгийн орлого олсон. Монголын эдийн засагт их бодитой, манайд ямар нэгэн хөрөнгө оруулалтын эрсдэл гаргаагүйгээр 3 их наядыг улсын төсөвт олсон байгаа юм, 1998 оноос 2025 оны хугацаанд.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх

гишүүд нэрсээ өгнө. Гишүүдийг нэрсээ өгөхийг хүсье. Сэддорж гишүүнээр тасаллаа. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Энэ 2031 онд дуусах байх, тийм ээ? Хугацаа нь дуусна. 31 он хүртэл 5 жилийн хугацаа байна. Тэгэхээр дэлхий дээр бизнес хийж байгаа харилцан худалдаа наймаа хийж байгаа оронд хэлсэн ярьсандаа байхгүй бол болохгүй л дээ. Тэгээд тэр үеийн хүмүүсийг буруу юм хийчхэж гэж бид нар хэлэлтэй биш. Тийм учраас энэ оруулж ирж байгаа Эдийн засгийн хөгжлийн яамнаас оруулж ирж байгаа энэ саналыг дэмжээд, энэ хоёр улсын эдийн засаг, гадаад харилцаа нь харилцааныхаа асуудлыг бодоод дэмжээд явсан нь дээр. Юм дандаа сайжирч явдаг хорвоо дэлхий үргэлж л цэгцрэх хөдөлгөөн цэгцэрч явдаг. Тийм учраас 31 оноос хойш ямар гэрээ хийх, юу шаардлагатай, бид нар юун дээр алдсан, юун дээр оносон гэдгээ сайн дэнсэлж, 31 ондоо сайн гэрээ хийж цаашаа явж хойч үе маань энийг сайнаар дүгнэж, хүлээж авах болтугай гэж бодож байна. Тэгээд дэмжиж байна.

Б.Заяабал: Гишүүд санал хэлж, үг хэлж дууслаа. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийг танхимдаа урихыг хүсье. Манай Байнгын хорооны санал хураалттай холбоотойгоор гишүүд энэ Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороод зэрэг хурал явагдаад байна, бүх саналууд давхцаад байна. Тийм учраас хойшлуулж өгөөч, жоохон хойшлуулаач, түр хойшлуулаач гэсэн ийм хүсэлтүүд ирээд байгаа юм байна. Тийм учраас завсарлага. Тэгэхээр энэ хоёр Байнгын хороо нь хоёр гол Байнгын хороон дээр санал хураалт яваад байгаа учраас энийг хүлээгээд 15 минут бүгдээрээ завсарлах уу? Тийм, 15 минутын завсарлага өгье.

Хуралдаан 16 цаг 33 минутаас 17 цаг 27 минутад завсарлав.

Байнгын хорооныхоо гишүүдийг танхимдаа ирэхийг урья. ТББХ, Төсвийн байнгын хорооны санал хураалт зэрэг явагдсантай холбоотой гишүүдээс Эдийн засгийн байнгын хорооны санал хураалт давхцаж байгаа тул хойшлуулж өгөөч гэсэн ийм хүсэлт тавьсан. Энэний дагуу завсарласан байгаа. Ингээд гишүүдийгээ эргэж танхимдаа ирэхийг урья.

Байнгын хорооныхоо хурлыг үргэлжлүүлье. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Хэлэлцэх асуудал 4 дээрээ явж байсан. Ингээд Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд үг хэлж, асуулт асууж дууссан байгаа. Санал хураалтыг УИХ-ын дэгийн тухай хуулийн 10.12-т заасны дагуу хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэсэн ийм дэгийн горимоор санал хураалтыг хойшлуулах ийм боломжтой юм байна. Ингээд энэ дагуу санал хураалтыг, одоо хэд болж байна 18, цагийн дараа 18:30 минутад санал хураалтыг явуулахаар хойшлуулъя.

Дөрөв.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэх асуудлын дараагийн асуудал. Хэлэлцэх асуудлын 5, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Төсвийн гүйцэтгэлийн талаар ЗГ-ын илтгэлийг УИХ-ын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн боловсруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хамт ЗГ-аас 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэж байна.

Тайлант онд улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 18 их наяд 988 тэрбум төгрөгт хүрч 95.9 хувийн биелэлттэй, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 20 их наяд 414.3 тэрбум төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 613 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2 их наяд 135.4 тэрбум төгрөгийн буюу 73 хувийн санхүүжилтийг, гадаадын зээл, тусламжийн хүрээнд 116 төсөл, арга хэмжээнд 1 их наяд 874.9 тэрбум төгрөгийн буюу 96 хувийн санхүүжилтийг, нийт 729 төсөл, арга хэмжээнд 4 их наяд 10.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, энэ хүрээнд 1800 орчим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажилласнаар 110 мянган ажлын байрыг хадгалж, улсын хэмжээнд 400 төсөл, барилга байгууламж ашиглалтад орлоо.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж аудит хийлгэн, улсын төсвийн гүйцэтгэлийг, тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Заяабал: Мэндсайхан сайдад баярлалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Цэдэнжав танилцуулна. Ерөнхий аудиторовн орлогчийн микрофоныг нээе, 5 дугаар номерын микрофон.

3.Цэдэнжав: УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийлээ. Тус Байнгын хороонд

харьяалагдах 9 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 35 тайлан нэгтгэснээс 18 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 17 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 11 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 516.9 тэрбум төгрөгийн 127 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн 23 төлбөрийн акт тогтоож, 510.7 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 56 албан шаардлага, хариуцлага тооцуулахаар 0.4 тэрбум төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн. Мөн 5.7 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 43 зөвлөмж өгсөн бөгөөд 0.4 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 24 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлээд дуусгахаар төлөвлөснөөс 4 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 төсөл, арга хэмжээ буюу 20.8 хувь нь тухайн онд хэрэгжиж дууссан. Өмнөх онд аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн нэг албан шаардлага, 5 зөвлөмж, түүврийн байгууллагад хүргүүлсэн нэг албан шаардлага өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт 90.9 хувьтай байна.

2.Монгол Улсын Шадар сайд бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа нэг байгууллагад хязгаарлалттай дүгнэлтийг өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 0.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 2.9 сая төгрөгийн зөрчилд нэг төлбөрийн акт тогтоосон, 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлсэн, 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг өгсөн. Өмнөх актаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн чиг үүрэг, бодлогын хэрэгжилт, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой 2 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

3.Зам, тээврийн сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 11 байгууллагад дүгнэлт гаргасан, 6 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж үзсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, нэг байгууллагад өөрчлөлтгүй, 10 байгууллагад хязгаарлалттай дүгнэлтийг өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 358.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.7 тэрбум төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт тогтоож, 323.6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 88 албан шаардлага хүргүүлж, 29.1 тэрбум төгрөгийн зөрчилд 101 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулахаар 5.5 тэрбум төгрөгийн 3 албан шаардлагыг хүргүүлсэн. Зам, тээврийн сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 869.5 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 79 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 625.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 61 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 77.2 хувь байна. Өмнөх оны

аудитаар өгсөн 2 албан шаардлага, 9 зөвлөмжийг үнэлэхэд 79.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.Эрчим хүчний сайд. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайланд 33 тайланд аудит хийж, 31 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт, харьяа 21 байгууллагад өөрчлөлтгүй, 10 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 968.8 тэрбум төгрөгийн 215 зөрчил илэрснээс 0.8 тэрбум төгрөгийн зөрчилд 34 төлбөрийн акт тогтоосон, 962.4 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоохоор 92 албан шаардлагыг хүргүүлсэн. Хариуцлага тооцуулахаар 2 албан шаардлагыг өгсөн, 5.6 тэрбум төгрөгийг давтан гаргуулахгүй байх 89 зөвлөмж өгч ажиллалаа. Эрчим хүчний сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 241.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 44 төсөл, арга хэмжээг 25 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 128.4 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 33 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 75 хувь гарсан. Өмнөх оны аудитаар тогтоосон 0.2 тэрбум төгрөгийн 44 төлбөрийн акт, 74.5 тэрбум төгрөгийн 87 албан шаардлага, 5.2 тэрбум төгрөгийн зөрчилд 74 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй биелэлт 97.6 хувьтай байна.

5.Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 25 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 9 байгууллагын санхүүгийн тайлан нэгдсэнээс 8 байгууллагад дүгнэлт өгсөн, нэг байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай, харьяа нэг байгууллагад өөрчлөлтгүй, 7 байгууллагад хязгаарлалттай дүгнэлтийг өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 131.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 33 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоосон, 64.4 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 38 албан шаардлага хүргүүлж, 67 тэрбум төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж, 8.7 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулахаар 3 албан шаардлагыг хүргүүллээ. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 0.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээг 25 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжсэн байна. Өмнөх оны аудитаар өгсөн 3 албан шаардлага, 6 зөвлөмж, 2 хариуцлага тооцох албан шаардлагын хэрэгжилт 81.8 хувьтай байна.

6.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд 10 байгууллагын санхүүгийн тайлан нэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд харьяа нэг байгууллагад өөрчлөлтгүй, 3 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар нийт 549.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 65.7 сая төгрөгийг 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47.5 тэрбум төгрөгийн зөрчилд 4 хариуцлага тооцох албан шаардлага, 107.3 тэрбум төгрөгийн зөрчилд 47 албан шаардлага, 402.7 тэрбум төгрөгийн зөрчилд 23 зөвлөмжийг өгч ажиллалаа. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 425.4 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 70 төсөл, арга хэмжээг 25 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 267.3 тэрбум төгрөгийн гэрээний

үнэтэй 40 төсөл, арга хэмжээ буюу гүйцэтгэл 57.1 хувьтай гарсан. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн нэг төлбөрийн акт, нэг албан шаардлага, нэг зөвлөмжийн хэрэгжилт 65.7 хувьтай байна.

7.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 25 оны санхүүгийн нэгдсэн тайланд 13 тайлан нэгтгэснээс 9 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулж үзсэн. Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан тайлант онд гүйцэтгэл гараагүй байсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 2 байгууллагад өөрчлөлтгүй, 7 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5.5 тэрбум төгрөгийн 70 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоосон, 3.9 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 42 албан шаардлага хүргүүлж, 1.4 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмж өглөө. 0.1 тэрбум төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлж, 0.3 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 24.4 тэрбум төгрөгийн гэрээний үнэтэй 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6.9 тэрбум төгрөгийн гэрээний үнэтэй нэг төсөл, арга хэмжээ буюу 6.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Өмнөх оны аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн нэг албан шаардлага, нэг зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан.

8.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Аудитаар нийт 154.2 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 6.2 сая төгрөгийн зөрчилд нэг төлбөрийн акт тогтоосон. Зөрчлийг таслан зогсоох 143 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн. Давтан гаргахгүй байх 4.6 сая төгрөгийн нэг зөвлөмжийг өглөө. СЗХ-ны даргын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 0.2 тэрбум төгрөгийн гэрээний үнэтэй нэг төсөл, арга хэмжээг 25 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлж ажилласан. Өмнөх оны аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 1.2 тэрбум төгрөгийн 2 албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 7.4 тэрбум төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 7.4 тэрбум төгрөгийн 2 зөвлөмжөө хэрэгжүүлж, нэг шийдвэрийн биелэлт 80 хувьтай гарлаа.

Үндэсний статистикийн хорооны дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 байгууллагын.../минут дуусав/

Б.Заяабал: 5 номерын микрофон нээе.

3.Цэдэнжав: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 12 байгууллагын өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 146.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 0.8 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 17.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүлсэн, 128.7 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгсөн. ҮСХ-ны даргын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл, арга хэмжээг 25 онд хэрэгжүүлж дусгахаар төлөвлөсөн нь бүрэн хэрэгжиж ажилласан. Өмнөх оны аудитаар нийт 114 сая төгрөгийн 20 зөрчил илэрсэн, эндээс нэг төлбөрийн акт, 67 сая төгрөгийн 5 албан

шаардлага, 47 сая төгрөгийн 14 зөвлөмж өгснийг 100 хувь бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дээр дурдсан аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд 1 дүгээрт, төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн саналыг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлж тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт, түүнд шаардлагатай төсвийг үнэн зөв, бодитой тооцоолох.

2.Хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлагыг сайжруулах.

3 дугаарт, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн байдлын тайлан болон бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон ашиглалтад орсон хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг үе шат бүрээр бүртгээгүй зэрэг зөрчил илэрч байгаад дүн шинжилгээ хийж, эрх бүхий төрийн байгууллагуудад асуудлыг шийдвэрлэх дараа үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг хангаж ажиллах.

4 дүгээрт, Монгол Улсын ЗГ-аас төсвөөс бүрэн санхүүждэг улсын төсөвт үйлдвэрийн газруудын цалингийн шатлалын нэгдсэн жишиг зохицуулалтыг батлаагүйгээс зарим байгууллагад цалингийн хэмжээ харьцангуй өндөр тогтоогдож, урамшууллын холбогдох журамд зөрчиж олгох, хүний нөөцийг сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулахгүй байх зэргээр мерит зарчим, ил тод байдал алдагдаж байгааг залруулах.

6 дугаарт, зарим байгууллагуудын чиг үүргийн зааг ялгаа тодорхой бус, давхардалтай, ЗГ-ын шийдвэрийн нийцгүй байдлаас засаглал, зохион байгуулалтын уялдаа хангалтгүй байгааг залруулах. Тухайлбал энд Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба хооронд, мөн 20 минутын хот хөгжлийн төв гэх мэт бас.

7 дугаарт, гэрээний удирдлага, гүйцэтгэлийн хяналт сул, зөвлөх үйлчилгээний чанар хангалтгүй, салбарын судалгаа, шинжилгээний чадавх дутмаг байгаа нь бодлогын баримт бичгийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч ажиллан аудитын шийдвэрийн болон хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүн шинжилгээ хийж, цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ. Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Б.Заяабал: Цэдэнжав даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Мэндсайхан Сангийн сайд, Хулан Сангийн дэд сайд, Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Цогтгэрэл Санхүүгийн зохицуулах хорооны ажлын

албаны дарга, Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Анар Сангийн яамны ТНБД, Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД, Ерэн-Өлзий ЭХЯ-ны ТНБД, Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мөнгөсүх Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Цагаанхүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга, Гүнсэнхорол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харилцаа холбоо, кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батбаяр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Дэлгэрмаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн дарга, Борхүү Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга, Баттулга И Монгол академи УТУГ-ын захирал, Амарсанаа Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн дарга, Лхам Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч, Амартүвшин Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга,

Баянбаатар Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Должинсүрэн ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Сумъяа ЗТЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Отгонжаргал Эрчис Ойл ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч, Билгүүн АМГТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Баяр-Эрдэнэ Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Сайхантөгс Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн,

Үндэсний аудитын газраас Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Цэвэлмаа Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Баттуяа Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Баярсайхан Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Цэвэгдорж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Чанцалдулам Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Энхдалай Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Долгорсүрэн Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Эрдэнэцогт Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Нацагдорж Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Саруул Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер, Оюунхүү Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4.2-т зааснаар Байнгын хороод нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед гишүүд төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулан зөвхөн Сангийн сайд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух дэгтэй байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Жаргалан гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Мандхай гишүүн. Мандхай гишүүний микрофоныг өгье.

М.Мандхай: Байнгын хороодоор угаасаа яг энэ төсвийн гүйцэтгэл явж байгаа. Тэгээд үндсэндээ улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харах юм бол хөрөнгө оруулалтын зардлын 2 их наяд гаруй төгрөгийг, энэ дотор нь барилга байгууламж, аймаг, нийслэлийн дэд бүтцийн төслүүд, ЖДҮ-ийн дэмжлэг, тэр хүнсний хувьсгал гэх мэт цагаан хаалт гээд олон зардлууд орсон байгаа. Тэгээд энэ зарцуулалгүй үлдээж байгаа олон хөтөлбөрүүд батлагдсан төсвийнхөө дөнгөж 30-аас 50 хувийг хэрэгжүүлсэн байгаа. Энэ дээр ер нь яагаад ийм гүйцэтгэлтэй гарч байгаа талаар гишүүдэд Сангийн яам хариулаад өгчхөөрэй. Тэгсэн мөртөө энэ үр дүнгийн гүйцэтгэлийг дандаа 100 хувиар тавьчихсан байгаад байгаа юм. Гүйцэтгэл нь өөрөө хангалттай биш, он дамнасан, яг бодитой зарцуулалт хийгдээгүй маш олон зардлууд байгаад байгаа. Тэгээд ингээд тавиад өгчихсөн байгаа.

Тэгээд эндээс нэг зүйл асуух гээд байгаа юм. Энэ урсгал зардал, үндсэндээ урсгал зардал дотор энэ нэг тодорхой бус бараа үйлчилгээний 3.9 их наяд төгрөгийн зардлыг хамгийн том 20 ийм төрлийг нь нэг хэлж өгөөч. Яг энэ 3.9 их наяд төгрөгийн зардал дотроо, яг хэмнэлт хийх боломжтой ямар төрлийн үйл ажиллагаанууд энэ хамгийн их зардалтай байгаад байгаа юм бэ? Тэгээд энэ Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт 25 онд улсын хэмжээнд хэдэн яг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл огт хэрэгжээгүй, хэд нь он дамжиж байгаа вэ гэдгийг хэлээд өгөөч. Энэ төслийг хэрэгжүүлэх ер нь бэлтгэл ажил нь хангагдахгүйгээр төсөвт оруулсан хариуцлагыг ер нь хэнд тооцох юм бэ? Ямар асуудал? Энэ дээр нэг тодорхой хариулт хэлж өгөөч.

Дээрээс нь яг энэ Сангийн яам ч гэсэн, Эдийн засаг, хөгжлийн яам төлөвлөгөөгөө гаргаж байгаа, орлогоо хэт өөдрөг тавьсныг тухайн үеийн төсөв хэлэлцэж байхад би ч гэсэн чуулган дээр хэлж л байсан, хэтэрхий өөдрөг өсөлтөө тавьсан. Ингээд энэний яг гүйцэтгэл нь ингээд яг харагдаж байна шүү дээ. Тэгээд энэ KPI үзүүлэлт нь өөрөө дандаа үйл ажиллагаа хэвийн 100 хувь гээд хэрэгжээд тавьчихсан, процессын үзүүлэлтээр үнэлчихсэн байгаад байгаа. Тэгэхээр энэ төсөв өөрөө яг үнэнээ хэлэхэд анх төлөвлөгдсөн дээрээ ч гишүүд хэлж байсан, одоо гүйцэтгэлийнх нь байгаа байдал нь нэг ийм л байна. Энэ орлогын төлөвлөгөө, жишээлбэл, 937 тэрбум төгрөгөөр тасарчихсан, ААНОАТ, НӨАТ, бүх энэ гааль, онцгой албан татварын төлөвлөгөөг дандаа өөдрөгөөр тавьчихсан байсан. Тэгээд энэнээс болоод анхнаасаа энэ чадавхаасаа давсан хөрөнгө оруулалт төсөвлөсөн санхүүжилт бүгд хойшлогдож байгаа. Тэгээд энэний гол шалтгааныг нь Сангийн яам яг тодорхой тайлбарлаад өгөөч. Тэгээд энэ дээр ер нь дахиад.../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсгийн гишүүд олон байгаа учраас гишүүд гараа өргөөд шууд микрофон аваад яваарай. Хэн хариулах вэ? Сангийн яам, Сангийн яамнаас эхэлье. Мэндсайхан сайд хариулах уу? Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Сангийн яам гүйцэтгэл дутуу гараад байна, тэгээд тэрийг гаргасан. Сангийн яам дээр ирсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлүүд яг хугацаандаа гараад явж байгаа. Өнгөрсөн оны энэ төсвийн гүйцэтгэлээс харахад ч гэсэн салбар төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр хэрэгжээгүй ажлуудын хариуцлагыг тухайн яг ямар асуудал байна, та өөрөө аль салбар дээр байна тусгайлаад асуух нь зөв байх. Сангийн яам санхүүжилтийн асуудлаа шийдээд явж байгаа. Тэр төлөвлөсөн орлогын хэт өөдрөг тавилаа гэдэг бол та бид нар сууж байгаад төсвийн хүрээгээ батлаад л, тэр хүрээндээ Сангийн яам төсвөө бэлдэж оруулж ирж байгаа. Энэ асуудал маань тодорхойгүй нөхцөл байдал, эдийн засгийн хүндрэл, татварын орлого, гаалийн татварын орлого гээд энэ ашигт малтмалын ч гэдэг юм уу, АМНАТ-аас орж ирэх орлогын тасалдал үүссэн тохиолдолд бид нар төсвөө тодотгоод, эндээ арга хэмжээгээ тухай бүрд нь аваад явсан.

Ингэхээр зэрэг энэ дээр юу гэдэг юм, Сангийн яам гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр хариуцаж байгаа асуудал бол бид нар төлөвлөлт, гүйцэтгэлээ ямар нэгэн тодорхойгүй нөхцөл үүсэхэд тодотгоод явж байгаа. Нөгөө талдаа бид нар хариуцсан санхүүжилтийн асуудлаа таслахгүй явж байгаа. Яах вэ, он дамжсан хөрөнгө оруулалтын асуудал оны эцэс дээр 770 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт, гүйцэтгэл нь ирэхгүйгээс болоод гэрээ байгуулсан ч гэсэн үлдсэн энэ асуудал нь 1 дүгээр улиралд санхүүжээд, он дамжаад санхүүжээд, санхүүжилтээ шийдэгдээд явж байгаа. Тэр яг асуугаад байгаа төсөл, хөтөлбөрүүдийнх нь дараа Дэлгэржаргал хариулчих. Яг аль төсвийн гүйцэтгэл дээр нь.

Б.Заяабал: Мандхай гишүүний нэмэлт тодруулга минут өгье. Мандхай гишүүн.

М.Мандхай: Хариулт хангалтгүй байгаа учраас тодруулъя. Нийт хөрөнгө оруулалт улсын төсөв 9.5 их наяд, гүйцэтгэл 7 их наяд, 2.4, 2.5 орчим их наяд буюу 26 хувь хэрэгжээгүй, нийт орлогын төсөв өөрөө орлогын төлөвлөгөө 937 тэрбум төгрөгөөр тасарсан. Өндөр урсгалтай зардал буюу цалин, үйлчилгээ давамгайлсан төсөвтэй боловч хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 26 хувиар тасарсан. ХХАА-н салбар дээр төлөвлөсөн гүйцэтгэл төсөв 675.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан боловч 441.6 тэрбум буюу 65.4 хувийн гүйцэтгэлтэй, 233.5 тэрбум төгрөгийн санхүүжилт үлдсэн. Салбарын төсөв бүх аймагт хуваарилагдсан боловч олон аймагт гүйцэтгэл 50 хувиас доогуур байсан мөртөө 100 хувийг гэж үнэлжээ. Энэ олон зөрүү дээр л би тайлбар хүсэх гээд байгаа юм. Энэ дээр ингээд тодорхой холбогдох албан тушаалтнууд хариултаа өгнө үү?

Б.Заяабал: Ажлын хэсгийн 3 номерын микрофон өгье.

Ж.Дэлгэржаргал: Мандхай гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Яг хөрөнгө оруулалтын асуудал дээр нь. Нэгдсэн төсвийн нийт зардлын хөрөнгө оруулалт дотор 3 ангиллаар хөрөнгө оруулалт байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутаг, гадаад зээлийн ашиглалт. Гадаад зээлийн ашиглалт 1.6 их наядаар 100 хувь гарсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалт бид нар 5 сарын 31-нээр гэрээ хийгдээгүй төслүүдийг анх батлагдсан нь 3.8, 535-аар хэмнээд, 3 их наядаас 2.9-ийг олгохоор батлагдсанаас 2.1-ийг олгосон байгаа. Тэгээд 779 бол хөрөнгө оруулалт өөрөө яг гүйцэтгэлд суурилан олгодог зарчимтай.

Яг гүйцэтгэл ирсэн санхүүжилт 286-г бид нар энэ онд нь өгсөн, 493 нь угаасаа гүйцэтгэл ирээгүй. Тэгэхдээ нөгөө талдаа гэрээтэй төслүүд явж байгаа учраас бид нар 27 онд нь гэрээнийх нь үлдэгдлийг тусгаад, төслүүдээ дуусгах бодлого баримтална. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтуудын хувьд орон нутгийн Иргэдийн Хурал батлаад, тэндээ яг гүйцэтгэлүүдээ гаргадаг учраас яг манай дээр ямар салбар, аль төслүүд гэдэг нарийн мэдээлэл нь байдаггүй.

Б.Заяабал: 3 номерын ажлын хэсгийн микрофоныг нээе, нэмж өгье.

Ж.Дэлгэржаргал: Тэгэхээр нийт хөрөнгийн зардлын яг зөрүү 2.2-ын дийлэнх нь орон нутаг, тэр дундаа нийслэлийн хөрөнгө оруулалт байгаа.

Б.Заяабал: Бусад асуудлууд дээр Сангийн яам, бусад агентлагууд гараа өргөөд нэмэлт микрофон аварай. 7 номер, Сангийн яам.

Б.Анар: Мандхай гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Анар. Мандхай гишүүний асуугаад байгаа асуулт, түрүүний хөрөнгө оруулалттай холбоотой 2.4 их наяд хөрөнгийн зардал тасарсан гэж байгаа нь орон нутаг болон улсын төсөв нийлээд хэлээд байгаа дүн. Улсын төсвийн хөрөнгө оруулалт 770 орчим тэрбум төгрөгөөр гүйцэтгэл гараагүй. Үүний түрүүн хэлсэн 270 орчим тэрбум төгрөг нь өөрөө гүйцэтгэл нь ирсэн боловч орлогын гүйцэтгэлтэй уялдаад гаргаж чадаагүй. Үлдсэн дүн нь яг өөрөө гүйцэтгэл нь ирээгүй учраас тухайн төслүүдийн санхүүжилт гарч чадаагүй.

Орлогын гүйцэтгэлтэй холбоотой асуулт та түрүүн асуусан, улсын төсөв дээр татварын орлого 887 орчим тэрбум төгрөгөөр өнгөрсөн онд тасарсан. Энэ дотроо ингээд задлаад аваад үзвэл гол нь импортын нийт төлөвлөсөн импортын хэмжээ маань өөрөө 1.1 тэрбум ам.доллараар буурсан өнгөрсөн жил. Энэ нь өөрөө эдийн засгийн.../минут дуусав/

Б.Заяабал: 7 номерын микрофон нэмж өгье. Нэмэлт тодруулга.

Б.Анар: Импорт өөрөө 1.1 тэрбум ам.доллараар бидний төсвийн хүрээн дээр, төсөв дээр төлөвлөсөн тооноос өөрөө дутсан гэсэн үг. Тэгээд яг үүнтэй холбоотойгоор онцгой албан татвар, гаалийн татвар тасарсан байгаа. Энэ нь өөрөө орлогын тасалдал хамгийн том нөлөөг үзүүлсэн. Дээрээс нь суудлын автомашины импорт буурсан, энэ нь өөрөө гаальтай, онцгойтой ийм импорт байдаг, энэ нь өөрөө нийт орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн. Дээрээс нь өнгөрсөн оны эхний хагас жилд уул уурхайн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний үнэ унасантай холбоотойгоор нийт уул уурхайн салбараас орж ирдэг экспортын орлогууд нэлээн тасалдсан. Энэ нь өөрөө эргээд бүтэн жилийнхээ дүндээ ААНОАТ тодорхой хэмжээгээр тасалдахад нөлөөлсөн байгаа. Эдийн засгийн идэвхжил буурсан гэсэн үг том зургаараа.

Б.Заяабал: Мандхай гишүүн нэмэлт тодруулга.

М.Мандхай: Ингээд би түрүүн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулт авмаар байсан. Ингээд төсвийн гүйцэтгэл ингээд тасалдаж байгаатай холбоотой, ер нь энэ улс орны эдийн засаг, энэ орон нутагт хэрэгжээгүй олон төсөл, хөтөлбөр ингээд ер нь энэ улс орны яг нийт эдийн засгаас гадна ер нь энэ ажлын байр, ажилгүйдэлтэй холбоотой энэ нийгэмд ер нь яг ямар сөрөг нөлөөлөл үзүүлэх

юм бэ гэдэг дээр нэг хариулт өгөөдхөөч. Тэгээд энэ төсвөөс гарч байгаа энэ ер нь үр дүн, үр дүнг ер нь юу гэж харж байгаа юм бэ? Энэ гүйцэтгэл хэрэгжээгүйтэй холбоотой ер нь цаашдаа ер нь ямар арга хэмжээ авах ёстой гэж харж байгаа юм бэ? Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулт өгөөч.

Б.Заяабал: Ажлын хэсгийн нэг номерын микрофон.

Н.Ууганбаатар: Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Мандхай гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт, гүйцэтгэл дутуу гарсантай холбоотойгоор алдагдсан боломжийг тооцсон тооцоо бидэнд одоогоор байхгүй байна. Энийг хийх аргачлал нь ч одоогоор тодорхойгүй, энэ төрлийн тооцоо бид нар одоогоор хийж эхлээгүй байна.

Цаашид ер нь яах ёстой вэ гээд тэгэхээр бидний ойлгож байгаагаар төсөв буюу төлөвлөгөө, тэрний гүйцэтгэл, тэгээд үр дүн гэсэн энэ 3 зүйл хоорондоо уялдаатайгаар хэлэлцэгдэх ёстой бөгөөд гүйцэтгэл дээр энэ бүх зүйл маань буцаагаад тайлбарлагдах учиртай. Одоогийн байдлаар бидний энэ төсвийн гүйцэтгэлийг, дээрээс нь ЗГ-ын санхүүгийн нэгдсэн тайлантай, аудитын дүгнэлттэй ингээд бүгдийг нь нэг дор хэлэлцээд байгаа явдалд жоохон учир дутагдал байж магадгүй гэсэн байр суурьтай байгаа. Дээрээс нь одоогийн хууль, эрх зүйн хүрээнд зарим нэгэн заалтууд хэрэгжихгүй байна. Тухайлбал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.4 дээр байгаа заалтыг бид нар хэрэгжүүлэхгүй байгаад байгаа. Тэнд юу гэж байна вэ гэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн гүйцэтгэл 2-ын хооронд зөрүү гарсан тохиолдолд тэр зөрүү нь.../минут дуусав/

Б.Заяабал: Тэгье, 1 минут, нэг номерын микрофоныг нээе.

Н.Ууганбаатар: Тэр зөрүү дээр дүн шинжилгээ хийж танилцуулах ёстой ийм үүрэг хүлээсэн байгаа. Энэ заалт одоогоор хэрэгжихгүй байгаа. Тэгээд дээрээс нь энийг хэн хийх вэ, яаж хийх вэ гэдэг дээр ямар нэгэн тайлбар байхгүй. Ер нь цаашид энэ төрлийн заалтууд дахиад хэд хэд байх хэрэгтэй юм шиг. Үр дүн, гүйцэтгэл 2, үр дүн, төсөвлөлт 2 хоорондоо зөрүүнүүд нь юунаас болсон бэ гэдэг дээр бид нар бүгдийг нь тайлбарлаж чадах ёстой. Тэгж байж энэ маань цогц систем болж цаашаа хөгжих үндэс нь тавигдах болов уу гэж бодож байна. Тэгээд эндээс гарч байгаа суралцаж авч байгаа lesson гэж яриад байгаа эндээс сургамжуудаа бид нар дараа жилийнхээ төсөвлөлтөд ашигладаг болж байж энэ цикл бүтэн болох болов уу гэсэн ийм байр суурьтай байгаа.

Б.Заяабал: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Бид төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ дандаа ийм цаг тулгасан, материал нь маш оройтож ирсэн, тэгээд энэ Байнгын хороодын хурал давхацсан ийм байдалтайгаар гүйцэтгэлийг маш муу хэлэлцэж байгаа. Тэгээд сая ч гэсэн дээ энэ материал маань их орой ирлээ. Тэгээд л Байнгын хороод давхцаад их тийм тулгамдсан байдалтай төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байна. Уг нь төсөв батлахаасаа илүүтэй энэ гүйцэтгэл дээрээ, энэ татвар төлөгчдийн мөнгийг хэрхэн яаж зарцуулж байгаа дээрээ бид нар нэлээн нухацтай ярих ёстой. Тэгээд аудитын байгууллагаас болохоор жил болгон л төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр ийм хязгаарлалттай дүгнэлт гаргаж байгаа, ийм ийм алдаа, дутагдал гаргасан гээд л

маш олон зүйл танилцуулдаг. Тэгээд та бүхэнд энэ Төсвийн тухай хуулийн тодорхой заалтуудыг нэг ахиж сануулъя гэж бодож байна.

Төсвийн тухай хуулийн 70.3-д төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан зардлыг хэтрүүлсэн, ангилал зөрүүлсэн, зориулалт бусаар ашигласан бро тухайн эрхэлж байгаа албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно гэсэн заалт байна. 70.4 дээр төсвийн ерөнхийлөн захирагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн төслийг боловсруулж батлуулахдаа үндэслэлгүй тоон мэдээнд тулгуурлан батлуулсан нь төсвийн гүйцэтгэлээр тогтоогдсон бол уг албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно гэсэн байна. Тэгэхээр та бүхний энэ аудитын газраас асуух гэж байгаа юм. Та бүхний гаргаад байгаа энэ хязгаарлалттай дүгнэлтүүд, энэ олон алдаа, дутагдлууд, зөрчлүүд илрээд илрээд байгаа энэ Төсвийн тухай хуулиараа ер нь өнгөрсөн хугацаанд ийм сахилгын шийтгэл ногдуулах талаар санал, дүгнэлтүүд энэ тэр явсан юм уу? Одоо энэ танилцуулж байгаа зүйл дээр саяын 2 заалтад хамаарах тийм яг бодитой алдаа, дутагдал, зөрчлүүд юу байна вэ гэдэг тодорхой асуулт байна.

2 дугаарт нь, бид саяхан Хөгжлийн төлөвлөгөө, жилийн хөгжлийн төлөвлөгөөгөө хэлэлцэх гэж бөөн л юм болсон. Тэгээд Хөгжлийн төлөвлөгөөнд саналуудаа тусгуулах гэж гишүүд нэлээн удаан хэлэлцсэн. Тэгээд төсвийн жилийн төлөвлөгөөгөө арайхийж баталж авсан. Гэтэл энэ 2025 оны төсвийн гүйцэтгэл дээр ямар үр дүн гарч байгаа вэ гэхээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан нийт арга хэмжээний ердөө 53.7 хувь нь энэ төсвийн гүйцэтгэлдээ ороод ингээд тодорхой хэмжээнд хэрэгжээд явж байна гэсэн ойлголттой, ийм дүгнэлт байна. Тэгэхээр энэ жил болохоор жилийн төлөвлөгөө сая батлагдаад явчихсан байгаа. Ирэх жилийн төсөвт энэ жилийн төлөвлөгөө чинь ингэж бүтнээрээ ер нь сууж чадах юм уу? Энэ хөгжлийн төлөвлөгөө, тэгээд төсвийн тухай хууль хоёрынхоо зөрүү дээр хэдүүлээ ер нь яаж энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтөө зангидан нэгтгэх юм бэ? Энэ дээр Сангийн яам ер нь ямар байр суурьтай байна вэ гэдгээ асуумаар байна. Цаашдаа ингэж зүгээр нэг ийм цаас батлахын төлөө Их Хурал дээр ч бөөн хэл ам болоод, Засаг дээр ч бөөн хэл ам болоод, тэгсэн хэр нь эцсийн дүндээ ерөөсөө энэ гүйцэтгэлээрээ хэрэгждэггүй энэ байдал байх юм уу? Саяын 2 асуултаа хариулт аваад, тэгээд.../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номер, дараа нь Сангийн яам бэлдэж байгаарай.

3.Цэдэнжав: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн, 70 дугаар зүйлтэй холбоотой Төрийн аудитын байгууллагаас энэ жил нэгдсэн байдлаар бид нар авч үзсэн. Яагаад гэхээр төсвийн захирагчдад төсвийн хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбоотой хариуцлага тооцох асуудал байгаа. Энд бид нар 58 төсвийн ерөнхийлөн захирагчдад төсвийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар албан бичгийг хүргүүлсэн байгаа Төрийн аудитын байгууллагаас, Монгол Улсын Ерөнхий аудитораас.

Мөн тухайлбал энэ Төсвийн тухай хуулийн 70.1 дэх хэсэгтэй холбоотой аудитын шийдвэрийг бид нар ингээд нэгтгээд харах юм бол нийт 2316 зөрчил байгаа, 1 их наяд орчим төгрөгтэй холбоотой асуудал байгаа. Энэ хүрээнд бид 439

төлбөрийн акт тогтоосон байгаа. 70.3, 70.4 дэх заалттай холбоотой асуудлаар мөн Монгол Улсын Ерөнхий аудитораас холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдад албан бичгийг хүргүүлээд, тодорхой хугацаанд энэ асуудлыг шийдвэрлэж хариу мэдэгдүүлэх тухай 58 төсвийн ерөнхийлөн захирагчид албан бичгээр хүргүүлсэн байгаа. Бүх сайд нар, бүх аймгийн Засаг дарга нарт бид нар албан бичгээр шаардлагаа хүргүүлсэн.

Б.Заяабал: Сангийн сайд, хэн өгөх вэ, 7 номер уу, ажлын хэсгийн 7 номер.

Б.Анар: Жилийн төлөвлөгөө төсөвтөө багтаж батлагдаж чадах уу гэж асуусан Жаргалан гишүүн. Жишээ нь сая улсын жилийн төлөвлөгөөг саяхан 6 сарын, 5 сарын сүүлээр батлахдаа урсгал зардлыг жишээ нь 500 тэрбумаар нэмэгдүүлэх нөлөөтэй заалтууд, дээрээс нь хөрөнгө оруулалтын нэлээн олон ажлуудыг нэмээд баталчихсан байгаа. Энэ жилийн байгаа төсвийн нийт урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал нийлээд зарлагын хязгаар нь 32.9 их наяд. Саяхан баталсан төсвийн хүрээгээр баталсан төсвийн хүрээ маань өөрөө нийт зардлыг 2.5, 2.3 их наядаар л нэмэгдүүлэх боломжтой байгаад байгаа юм нэг талдаа. Тэгсэн мөртөө бид нарт ирж байгаа хүсэлтүүд, төсвийн хязгаар батлахад ирүүлж байгаа хүсэлтүүд энд багтаах ямар ч боломжгүй л хүсэлтүүд ирээд байгаа юм. Тэгэхээр нэгдүгээрт мэдээж цалин, тэтгэвэр зардлуудаа.../минут дуусав/

Б.Заяабал: 7 номер нэмэлт нэг минут өгье.

Б.Анар: Тэгэхээр мэдээж төсөв боловсруулахдаа цалин, тэтгэвэр, нийгмийн халамжтай холбоотой зайлшгүй гэсэн зардлуудаа тусгаад, үүний дараа гэрээ нь хийгдчихсэн байгаа хөрөнгө оруулалтуудын ажлуудаа тусгаад, тэгээд нэг ийм байдлаар эрэмбэлээд төсөвтөө тусгах ажлууд хийнэ. Тэрнээс яг бүх хуультай, бүх ирүүлсэн хүсэлтийн дагуу бүх зардлуудыг төсөвтөө багтаагаад оруулах боломж хомс гэдгийг хэлье.

Б.Заяабал: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгэхээр аудитын байгууллагын хариултаас харахад бүх сайд нар чинь ЗГ-ын гишүүд, энэ Төсвийн тухай хуулийнхаа хариуцлага ногдуулах хүрээнд бүгдээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх үндэслэл бүхий зөрчил гаргачхаад байна гэж ойлголоо. Зөв үү?

Дараачийн асуудал, нэгдсэн төсвийн нийт орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, хэт өндөр төсөөлснөөс орлого тасарч, татвар төлөгчдөөс 1 их наяд 248 тэрбум төгрөгийн татвар, хураамжийг урьдчилан төлөвлөж, тайлант оны гүйцэтгэлээр бүртгэсэн байна гэж байна. Бүртгэж тайлагнасан нь дараа оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл үүсгэхээр байна гэнэ. Тэгэхээр одоо та бүхэн энэ жилийнхээ төсөв дээр энэ 1.2 их наяд төгрөгийнхөө асуудлыг ер нь яаж шийдэх гэж байгаа юм бэ гэсэн асуулт Сангийн яамнаас?

3 дугаарт нь татварын бүртгэлтэй өрийн үлдэгдэл 6 их наяд хүрсэн байна, тэгээд ялангуяа сүүлийн жилд энэ татварын өр огцом нэмэгдсэн байна.../минут дуусав/

Б.Заяабал: Аудит тодруулаад, нэмээд Сангийн яамныхан бэлдэж байгаарай. 6 номер уу? Ажлын хэсгийн 6 номер.

Ч.Цэвэгдорж: Үндэсний аудитын газар Цэвэгдорж. Жаргалан гишүүний асуултад нэмж хариулъя. Яг Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлтэй холбоотойгоор, яг өнгөрсөн 25 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлтэй холбоотойгоор явахаар ЗГ өөрчлөгдсөн учраас сайд нар ч өөрчлөгдчихсөн иймэрхүү асуудлууд байсан. Дээр нь ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн УИХ-д толилуулсан тайлангийн хэсэг дээр эд нарыг нэлээн тодорхой мэдээллүүдийг нь оруулж өгсөн байгаа.

Мөн дээр нь түрүүний хэлсэн дээр ЗГ-ын гишүүд болон аймгийн Засаг дарга нар, дээрээс нь УИХ-ын харьяа байгууллагууд болон УИХ-д харьяалагдахгүй, жишээ нь Шүүхийн ерөнхий зөвлөл гэх юм уу иймэрхүү зэргийн бүх байгууллагууд дээр яг Төсвийн тухай хуулийн 70-тай холбоотой зөрчлүүдийг нь бүгдийг нь хавсралтаар нь хүргүүлээд, энэ дээр сахилгын хариуцлага тооцуулах ийм нөхцөл байдал чинь бүрдчихсэн байна шүү, алдаа, зөрчлөө давтан гаргахгүй байх, арилгах энэ тал дээрээ ажлаа зохион байгуулаарай гэсэн иймэрхүү санал хүсэлтээр бичиг.../минут дуусав/

Б.Заяабал: Сангийн яам, 7 номер.

Б.Анар: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу татвар төлөгч өөрөө төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлоод, хуулиар тогтоосон хугацаандаа төсөвт төлөх боломжтой. Тэгэхээр нэг ёсондоо өөрөө татварын шинэчилсэн системээр invoice үүсгээд, өөрөө төлбөрөө төлөөд явах боломжтой. Өнгөрсөн оны эцэст тодорхой хэмжээний татварууд ААН-үүд илүү төлөлт хийсэн байгаа. Татварын өртэй, нийт хуримтлагдсан өртэй холбоотой асуудлыг Татварын ерөнхий газраас хариулсан нь зөв байх.

Б.Заяабал: 3 номерын микрофон дээр суучих уу татвар. 3 номерын микрофоныг нээе.

Р.Мягмаржав: Татварын ерөнхий газар, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Мягмаржав байна. Гишүүний асуултад хариулъя. 2025 оны жилийн эцсийн байдлаар татварын албанд бүртгэгдсэн татварын өрийн үлдэгдэл 5 их наяд 948 тэрбум төгрөгийн өр бүртгэлтэй байгаа. Өрийн дүн өөрөө өсөж байна гэдэг асуудал нь, энэ өөрөө 1990 оноос хойш үүссэн өрнүүдийг бүгдийнх нь нийт дүнгээр нь үзэхээр 5 их наяд 900 болж байгаа. Тайлант он буюу 2024 оны үүссэн өрийн үлдэгдэл 2.4 их наяд төгрөгийн өр байгаад байгаа. Энэ өртэй холбоотой асуудал дээр, яах вэ, дүн шинжилгээ хийгээд үзэхээр бизнес эрхэлж байгаа компаниудын борлуулалтын орлого нэлээдгүй хэмжээгээр өсөж байгаа, тэр хэмжээгээр ногдлын дүн нэлээд их өсөж байгаа. Татварын байгууллагаас өр хураах үйл ажиллагааг Ерөнхий хуульд заасныхаа дагуу ажиллагааг нь хэрэгжүүлээд явж байна. Үүнийхээ дагуу татварын албанаас авч хэрэгжүүлдэг нэхэмжлэх өгөх, данс битүүмжлэх, өр хураах.../минут дуусав/

Б.Заяабал: 3 номерын микрофон нээе, нэг минут.

Р.Мягмаржав: Өр хураах ажиллагаануудыг шат дараатай авч хэрэгжүүлж байгаа. Мөн дараагийн нэг өр үүсэж байгаа гол шалтгаан бол татварын албан дээр хэрэгжүүлж байгаа татварын хяналт, шалгалтаар тавигдаж байгаа нөхөн ногдуулалтын акт төлбөртэй холбоотой өрүүд нэлээдгүй хэмжээгээр нэмэгдчихсэн. Тухайн татвар төлөгч өөрөө хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу Маргаан таслах зөвлөл болоод шүүхэд нэхэмжлэх, гомдол гаргах эрх нь нээлттэй. Тэр шат дээрээ гомдол гаргасан тохиолдолд татварын албанаас өр хураах ажиллагаа болоод ингээд зогссонтой холбоотойгоор өрийн дүн нэмэгдээд явж байгаа.

Б.Заяабал: Жаргалан гишүүний тодруулга нэг минут өгье.

Б.Жаргалан: Энэ ААН-үүдийн татварын өр бүр 2.5 дахин нэмэгдээд байна гэдэг чинь ерөнхийдөө ААН-үүдийн татварын ачааллаас болоод энэ татвараа төлж чадахгүй байдал үүсээд байна гэсэн л үг шүү дээ. Тэгэхээр бид нар энэ эдийн засаг хүндэрч байгаа нөхцөлд энэ ААН, байгууллагууд дээрээ тэр татварын акт энэ тэр тавьдаг асуудал дээрээ арай нэг өөр бодлого л баримтлах ёстой болчихоод байгаа юм. Тэгэхээр бид нарын хийж байгаа дүгнэлтүүд шал өөр байгаад байна л даа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нэг асуух асуулт байна. ЗГ-ын өр 35.4 их наяд төгрөгт хүрсэн байна, тэгээд гол нь ханшийн зөрүүгийн алдагдал 1.7 их наяд болсон байна гэж байна. Тэгээд цаашид ер нь энэ ханшийн эрсдэл хэр байна вэ? Ер нь манай ЗГ-ын өрийн менежмент хэр зохистой түвшинд явж байна вэ? Цаашид энэ тал дээр макро эдийн засгийн түвшинд ямар эрсдэл гарах вэ гэдэг дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэг хариулт хэлээч.

Б.Заяабал: 1 номерын микрофон, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя.

Н.Ууганбаатар: Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Жаргалан гишүүний асуултад товч хариулъя. Бидний эхний дүгнэлтээр ЗГ-ын нийт өр ирэх жилүүдэд өсөх хандлагатай байна гэдэг ийм дүгнэлтийг гаргасан, энэ дээр анхаарах ёстой гэдэг ийм зүйлийг ярьсан. Тэгэхээр бид нар төсвийн тусгай шаардлагуудаасаа, тухайлбал, зарим нэгэн мега төслүүдийг хууль батлаад гадуур нь гаргаж болно, тэгэхдээ тэр маань өрийн бүртгэл дээр бүртгэгдэж явна гэдэг ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр өр цаашдаа ер нь анхаарал хандуулах түвшинд хүрэхээр байна гэдэг эхний зүйл.

2 дахь асуудал нь авч байгаа зээл болон эдийн засгийн өсөлт 2-ын хоорондын зөрүү, тэгээд дээрээс нь төсвийн алдагдал гэсэн иймэрхүү зүйлүүдээр л өрийн ерөнхий динамикийг бид нар голлож хардаг. Тэгэхээр нөгөө нэг эдийн засгийн өсөлт маань 6 орчим хувьтай, тэгээд авч байгаа зээл маань нэг тиймэрхүү багцаагаар бодит дүнгээр нь тооцоолохоор хүү нэг тиймэрхүү түвшинд байгаад байхаар бид нар ерөнхийдөө байгаа газраа хий эргэх, иймэрхүү л макро эдийн засгийн хувьд ирэх жилүүдэд байгаа газраа хий эргэх ийм төлөвтэй байна гэдэг ерөнхий дүр зурагтай байгаа.

Б.Заяабал: Очирбат гишүүн.

Г.Очирбат: Оройн мэнд хүргэе. Жил болгон л нэг ийм үр дүнгүй хэлэлцүүлгүүд л хийдэг боллоо л доо. Ингээд баахан Төсвийн тогтвортой байдлын

зөвлөл, аудит, яам, тамгын газрын хүмүүсийг энд суулгачихсан, тэгээд үр дүн гарч байна уу гэхээр гардаггүй. Асуудал нэлээн хүндэрчихсэн, хууль хоорондын зөрчлөө ч арилгаж чадахгүй ийм байдалтай л байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн байнга хэлээд байгаа шүү дээ, мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлбэ гээд. Мөнгө хэр байна, тэр чинээгээрээ үрдэг. Энэ гай нь ингэж гарч ирж байгаа. Энэ гүйцэтгэл дээр энэ төсвийн тусгай шаардлагыг зөрчиж орж ирж байгаа. ДНБ-ий 2-оос дээшээ хувь байх ёстой юмыг 1.2 хувьтай болгоод оруулаад ирчихсэн, энэ дээр юу гэж бодож байгаа юм манай энэ мэргэжлийнхэн, цаашдаа ингэж яваад байвал ер нь яах юм бэ? Энэ төсвийн чинь өөрийнх нь үндсэн бодлого, концепц алдагдаад байна шүү дээ. Төсвийн тусгай шаардлагуудаа бид нар хангаж чадахгүй бол энийг хэлэлцээд ч хэрэггүй шүү дээ.

Тэгээд аудитаас ингээд баахан дүгнэлт өгөөд байдаг, ерөөсөө хэрэгжүүлдэггүй. Түрүүн Жаргалан гишүүн хэлж байна, тэр Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлтэй холбоотой энэ их зөрчил, маргаан гараад байхад энэ сайд, дарга нар яаж ажлаа хийж сууж чаддаг юм бэ? Тодорхой нэг л асуулт асууя, асуулт тэгэхдээ давхцаж байна. Би энийг чуулган дээр асуусан, дахиж давтаж асууж байгаа юм. Аудитын дүгнэлтээр 1.2 тэрбум төгрөгийг татвар төлөгч нараас түрүүлээд авчихсан, 2026 оны төсвийн орлого тасрах нь тодорхой болчихсон, тодотголоо хийж чадахгүй байгаад байгаа, бараг ээлжит бус чуулган 8 сард ч юм уу хийнэ ухааны юм яриад тодотгол оруулж ирнэ гээд одоо Засаг нь нэг тийм юм яриад байгаа юм шиг байгаад байгаа юм. Тэгэхээр тухайн үед Жавхлан сайд Сангийн сайд байсан, одоо Мэндсайхан сайд, 2 сайд маань хоёулаа сууж байна. Яагаад төсвийн тодотголоо оруулж ирээгүйгээр татвар төлөгч нараас 1.2 их наяд төгрөгийг авсан юм бэ? Ямар компаниас авсан юм, хэзээ авсан юм бэ? Асуултдаа хариулт авчхаад тэгээд ямар хуулийн дагуу шүү, би энэ хуулиудынхаа Мэндсайхан сайдын хэлсэн хуулийн заалтуудыг нь би энд бариад сууж байна. Асуулт нь надад цаглавар хамаарсан хуулийн заалтаар ам тагласан нэг, одоо тэгээд тодорхой яг түрүү жил 2025 онд аль, аль компаниас 1.2 их наяд төгрөгийг татварт түрүүлээд авчихсан юм бэ, ямар хуулийг барьсан юм бэ? Тэгээд тодруулъя.

Б.Заяабал: Ингэе, тусгай шаардлага хангагдсан эсэх гэдэг 1 дүгээр асуулт байсан. Энэ дээр аудит хариулаад, дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулаад, хамгийн сүүлд нь Сангийн яамныхан нэгтгээд бүгдэд нь хариулаад явъя. 5 номерын микрофон.

3.Цэдэнжав: Аудитын тайлангаар нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн суурь тэнцэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаагүй. Тайлант жилийн Төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах бүрдээ төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилдөг байдал давтагдсан гэсэн энэ дүгнэлтийг хийсэн байгаа.

Б.Заяабал: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 1 номер хариулъя.

Н.Ууганбаатар: Сая аудит хэллээ, түрүүн гишүүн өөрөө хэлсэн 6.1.2-т байгаа суурь тэнцэлтэй холбоотой энэ заалт энэ 25 онд анх удаагаа хэрэгжсэн, тэгээд эхнийхээ гүйцэтгэл дээр ерөнхийдөө унасан ийм дүр зураг харагдаж байгаа. Яах вэ, мэдээж шалтгаан нь орлого биелэлт дутуу байсан, дээр нь зээлийн ашиглалт дээр Сангийн яамны төлөвлөсөн хэмжээнд хүрч, зээлийн ашиглалт гараагүй болов уу гэж бодож байна. Цаашид ч гэсэн энэ суурь тэнцэл маань ер нь цаашид 2 хувийнхаа

ашигтайгаар гарах гэдэг эсэх дээр эргэлзээтэй байгаа. Бид энэ дээр анхааруулах нь зүйтэй гэж бодож байна. Өөрөөр хэлбэл 26, 27 онууд ч гэсэн суурь тэнцэл маань дахиад асуудал үүсгэж магадгүй байгаа. Тийм учраас энэ тусгай шаардлагуудаа эргэж харах нь зөв болов уу гэсэн байр суурьтай байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 7 номерын микрофон өгье. Сангийн яамны байр суурь, хариулт өгье.

Б.Анар: Төсвийн суурь тэнцлийн тусгай шаардлагыг хангаж чадаагүй төсвийн гүйцэтгэлээр. 25 оны бид 2 хувийн ашигтай байх ёстой GDP-ийн, одоо яг манай гарсан төсвийн гүйцэтгэлээр 1.2 хувийн ашигтай гарсан. Суурь тэнцэл хангаагүй гол шалтгаан нь энэ орон нутгийн төсөвтэй холбоотой байгаад байгаа юм. Орон нутгийн төсөв дээр юу гээд заачихсан бэ гэхээр Төсвийн тухай хуулийн 57.2 дахь хэсэгт орон нутгийн төсвийг алдагдалгүй батална гээд заачихсан байгаад байгаа юм. Ингээд төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид нар орон нутгийн нийт аймаг, нийслэлийн төсвийг, орлого, зарлагыг хэдээр тооцсон бэ гэхээр суурийг нь 6.9 их наядаар тооцож байсан байгаа байхгүй юу Төсвийн хүрээн дээр. Яг энийгээ орон нутаг батлахдаа энэ чинь ИТХ-ынх нь бүрэн эрх учраас батлахдаа орлогыг 1.5-аар нэмэгдүүлээд, зарлагыг нь 3.7-гоор нэмэгдүүлчихсэн. Гэхдээ энэ яг орон нутаг өөрсдөө хууль зөрчсөн гэх үндэслэлгүй, яагаад гэхээр төсвийн тухай.../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсгийн 7 номерын микрофоныг нээж өгье, нэмэлт хариулт.

Б.Анар: 57.3 дээрээ орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх гээд ингээд хоорондоо логикийн ингээд тэрсэлдээд байгаа 2 заалт байгаад байгаа. Тэгэхээр орон нутаг бондын үлдэгдлээс ч юм уу, өнгөрсөн оны дансанд үлдсэн үлдэгдлээ орлого биш шүү дээ тэр чинь өмнөх оны орлого байхгүй юу, тэрийгээ зарлага талдаа нэмээд санхүүжүүлээд явчихаар угаасаа зардал нь хэтрээд явчхаж байгаа юм. Яг энэ дүнгээрээ ингээд гүйцэтгэл нь гарахдаа орон нутаг нийлээд, бонд, урьд оны үлдэгдлүүд нь нийлээд төсөв нь өөрөө 500 гээд -500-тай гарчхаж байгаа байхгүй юу. Орон нутаг дээр шууд алдагдал гэж ярихгүй, нийслэл дээр алдагдал гэж ярихгүй, орон нутгийн алдагдал нь өөрөө 500 гарчхаж байгаа юм. Тэгэхээр саяын суурь тэнцэл рүү өөрөө сөргөөр нөлөөлөөд явчхаж байгаа юм.

Дээрээс нь яах вэ, нийгмийн даатгал, ЭМД гээд нэгдсэн төсвийн гүйцэтгэл дотор орж байгаа бусад сангуудын төлөвлөгөө нь ашигтай гарсан ч гэсэн бидний төлөвлөж байснаас багаар гарчихсан. Тэгэхээр нэгдсэн төсөв дээрээ эргээд нэгтгэгдээд ирэхдээ энэ нь өөрөө сөрөг эффекттэй ороод ирж байгаа юм. Тэгэхээр нийтдээ суурь тэнцэл маань өөрөө.../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсгийн 7 номерыг нээж өгье.

Б.Анар: 1,2 их наядын ашигтай гарсан, нөгөө 2 хувийн ашгаа барьж чадаагүй үндсэн суурь шалтгаан нь энэ л болоод байгаа юм. Тэгэхээр цаашдаа төсөв төлөвлөлт дээр энэ төсөв хоорондын харилцаатай холбоотой заалтууд, орон нутгийн ялангуяа төсвийн төлөвлөлт, энэ алдагдал үүсгэж байгаатай холбоотой заалтуудыг дахиж харах шаардлага байгаад байгаа юм. Тэгээд энэ ялангуяа өмнөх

оны үлдэгдлийгээ, өмнөх оны дансны үлдэгдлийгээ, бондын үлдэгдлийгээ хэрхэн яаж зарцуулах вэ, энийгээ алдагдалдаа яаж тооцох вэ гэдгээ тооцож явах ёстой. Тэгэхгүй бол нэгдсэн төсөв дотор байгаа бусад төслүүд нь, бусад төсвийн бүрэлдэхүүнүүд нь ингээд алдагдалтай, төлөвлөснөөс өөрөөр гараад яваад байвал тэр алдагдал, ачаалал нь өөрөө улсын төсөв дээр очоод үүрэгдээд байгаа гэсэн үг.

Б.Заяабал: УИХ-ын дэгийн тухай хуулийн 74.4.2 дээр төсвийн гүйцэтгэлийн хоёр дахь хэлэлцүүлэг дээр төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ гэсэн ийм дэг байгаа юм байна гэдгийг дэгийг танилцуулъя. 7 номерын микрофон, нэмэлт гүйцээж хариулаарай.

Б.Анар: Татварын ерөнхий хуулийн түрүүний хэлсэн 28.1 дүгээр заалтаар тухайн ААН-үүд нь өөрсдөө тайлагнаад, нөгөө татварын төрлүүдээсээ хамаараад тайлагнах хугацаа өөр, тэгээд урьдчилаад төлж болно шүү дээ. Энийг хаачихсан, хуулиар хориглочихсон заалт байхгүй. Урьдчилаад төлсөн яг ямар, ямар компани гэдгийг нь би одоо шууд нарийн хэлж мэдэхгүй. Уг нь татварынхан энэ дээр илүү нарийн хариулах байх.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 3 номер.

Р.Мягмаржав: Татварын ерөнхий газар, Татвар хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга Мягмаржав байна. 2025 онд 1 их наяд 247 тэрбум төгрөгийн орлого урьдчилж орсон гэсэн мэдээлэл байгаа. Гэхдээ энэ яг шууд урьдчилж орсон гэсэн хэлбэр биш. Бизнес эрхлэгч байгууллагууд нь өөрсдөө холбогдох хууль тогтоомжид заасныхаа дагуу татвараа дараа сард төлөх ийм зохицуулалтууд байдаг. Үүнийхээ нэг хэлбэр бол ААНОАТ-ын тухай хуульд заасныхаа дагуу бизнес эрхлэгч компаниуд нь улиралд сар болгон, сар болгоныхоо 25-ны дотор ААН-ийнхээ татварыг урьдчилж төлөхөөр зохицуулалттай. Мөн АМНАТ-ийн тухай хуульд заасныхаа дагуу тухайн сард ачсан ачилтынхаа мэдээн дээр тулгуурлаад ачилт дээр үүсэх ногдлыгоо урьдчилаад дараа сарынхаа 20-ныхоо дотор төлөх ийм зохицуулалтууд нь байгаа. Мөн хөрөнгийн татварууд байна. Үл хөдлөх хөрөнгийн татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварууд, энэ нь өөрөө бизнес эрхлэгч компаниуд өөрөө улирлаар тайлагнаж төлдөг, татвар төлдөг. Гэхдээ энэнтэй холбоотойгоор урьдчилаад жил.../минут дуусав/

Б.Заяабал: 3 номерын микрофон нэмээд өгье, нэг минут.

Р.Мягмаржав: Татвар төлөгчдийн хувьд 1 тэрбумаас дээш татвар төлсөн 63 орчим компани байгаа, 1 их наяд 187 тэрбум төгрөгийн татварыг төлсөн урьдчилж. Яг задгайгаар буюу татвар төлөгчөөр нэрээр нь хэлье гэхээр Татварын ерөнхий хуулийн 13-д заасныхаа дагуу нийтэд зарлах тийм хориотой ийм зохицуулалт байгаад байгаа юм.

Б.Заяабал: Очирбат гишүүн нэмэлт.

Г.Очирбат: Би энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнтэй их уулзсан юм. Тэгээд бүлэг дээр яг энэ талаар мэдээлэл авсан юм. Тэгээд энэ борлуулаагүй бараа, бүтээгдэхүүнээс түрүүлж татварыг нь авна гэдэг энэ чинь байж болшгүй зүйл гэж хэлээд байгаа юм. Тэгээд Сангийн сайд надад энэ Төсвийн тухай хуулийн 25.2 гэж чуулган дээр хэлсэн. Энэ зүгээр цаглавар, түрүүлээд тэр ААН-үүдээс татвар авч

байна гэдэг ноцтой асуудал. 2026 оны эхний улиралд төлөх татвараа 2025 оны сүүлээр түрүүлж төлж байна гэдэг, улсын төсөв тасраад тодотгол хийх ёстой байхад тухайн үеийн сайд, дарга нар маань тэр ААН, төрийн өмчит гэдэг юм уу, хувийн өмч ч гэдэг юм уу компанийг дарамталдаг юм уу, юу гэдэг юм юу гэж ойлгох юм, би юу гэж хэлэхээ мэдэхгүй байна. Тэр мөнгийг түрүүлж авч байна шүү дээ, тэр компаниуд нь борлуулаагүй бүтээгдэхүүн дээрээ түрүүлж татвар төлнө гэж ер нь юу байна. Би бүр гайхаад байна. Тэгэхээр тухайн үед энэ Жавхлан сайд байсан.../минут дуусав/

Б.Заяабал: Хариулт авч байж, хангалтгүй байвал нэмэх дэгтэй юм байна. Тэгэхээр Очирбат гишүүн санал хэллээ гэж үзэх үү? 7 номер тэгвэл хариулаарай. Дараа нь нэмэлт.

Б.Анар: ААНОАТ-ын тухай хуулийн 25.2, Татварын ерөнхий хуулийн 28.1, энэ 2 зохицуулалтаар ер нь ААН-ийн татварын тухай хуулийн 20, энэ ийм заалт байхгүй. Сар, хуваарийн дагуу төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор улирлын эцэст гээд цаглавар. Тэгэхээр 25 оны 4 дүгээр улиралд ногдсон ногдлоо татвар төлөгч нь өөрөө заавал дараа оны нөгөө тайлан гаргах үедээ төлөхийг хүлээхгүйгээр урьдчилаад төлөх боломж нь энэ заалтаараа нээлттэй гэсэн үг. Тэгэхээр заавал 2 сард төлнө гэхгүй, шууд тухайн улиралдаа төлөх эрх нь нээлттэй байгаа л гэсэн үг.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга авъя, Очирбат гишүүн.

Г.Очирбат: Ингэж Монгол төрийн бодлогыг завхруулахгүй шүү. Борлогдоогүй бараа, бүтээгдэхүүнээс түрүүлж татвар авна гэдэг чинь тэр ААН-ийг дээрэлхэж байна гэсэн үг. Төр өөрөө. Тухайн үеийн Ерөнхий сайд, тухайн үеийн Сангийн сайд, тухайн үеийн албан тушаалтнууд үгүй ээ, тодорхой биз дээ, та хэд энэ төрийн албан хаагч нар бүгд бодлого тодорхойлдог хүмүүс энд сууж байна. Энэ маягаараа төр цаашаа явах юм бол бүр ингээд дампуурал руу явна шүү. Утгаа алдана шүү дээ. Хууль яах гэж байгаа юм, бүгдэд нь тэгш л үйлчлэх гэж л байгаа. Тэгэхгүй нэгнийг нь дарамталж аваачиж, чи ТӨК болохоор түрүүлж татвар өг, яагаад гэвэл чи мөнгөтэй. Тэгээд амьдрал дээр иргэд рүүгээ гараад харахаар иргэд нь орлого байхгүй, макро эдийн засаг 6.2 хувь өсчихсөн байна гээд байдаг, иргэдийн амьдрал 6.2 хувь өссөн байна уу, үгүй байна уу, хэцүү байна шүү дээ та хэд гараад гэр хорооллоор яваад үз л дээ. Өнөөдөр мөнгөөр бараа авч чадахгүй байна шүү дээ иргэд чинь.

Б.Заяабал: Очирбат гишүүн санал хэллээ. Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Нэг асуулт, нэг мэдээлэл байна Очирбат гишүүнээ, төсвөө сайн унших хэрэгтэй, дутуу ойлгоод байх шиг байна. Наадах чинь борлогдоогүй бараа, бүтээгдэхүүнд биш байхгүй юу, 25 онд гарах борлуулалтаас төлөх татвараа 25 ондоо төлж байгаа байхгүй юу тайлагналын нэгд. Хоёрт, Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт ороод 36 жил болж байгаа юм, 36 жил жил бүр ийм асуудал гардаг. Зарим жилд бид нар бүр өндөр орлоготой жилүүд дээр зарим жилийн эцэст төлөгдөх татваруудыг он дамжуулж хойшлуулдаг. Хэт өндөр ашигтай гаргаж байгаа бол тийм шаардлагагүй байдаг байхгүй юу. Хойшлуулж байсан жилүүд ч байгаа, нааш нь татсан жилүүд ч байгаа. Жил бүр Сангийн сайд нарт ийм зовлон туулдаг, энэ оны эцэст ч ийм юм болно, цаашдаа ч болно. Сая Анар ТНБД хамгийн сүүлийн тайлбар дээр харин маш зөв тайлбарлалаа, яг тэр байхгүй юу.

Тэгэхээр энэ зохицуулалт аль аль ч ЗГ-т байсан, цаашдаа ч байх хэрэгтэй. Энийг халж юм уу, зогсоож болохгүй, энэ ямар ч боломжгүй асуудал.

Дээрээс нь би Сангийн сайдад нэг захиас байна. Түрүүн Анар ТНБД цухас дурдлаа, тэр чинь 57.2 биш, 57.3 нь шүү, 57.3-ыг энэ гишүүдэд нэг сонсгоорой. Энэ дээр ийм заалт байдаг байхгүй юу. Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл наад 25 оны алдагдал чинь 24 онд батлагдсан орон нутгийн төсвийн зарлагын үлдэгдэл байхгүй юу. Тухайн жил батлагдсан орон нутгийн зарлагыг зарлагадаж амжихааргүй бол тэрийг нь хойтонгийн жил дээр улсын төсөв зарлагадаж өгнө гэдэг үүрэг авчхаж байгаа юм энэ заалтаар. Тэгэхээр энэ 26 оны гүйцэтгэл хойтон гарахад энэ 26 оны орон нутгийн төсвөөс үлдсэнийг нь ЗГ хойтон заавал зарлагадах үүрэг хүлээхэж байгаа юм. Тэгэхээр энэ маш буруу заалт, яах вэ сүүлийн 5 жил жил бүр харилцан адилгүй өөр өөр л байлаа, тусгай шаардлагыг заавал биелүүлээд ирсэн, өөрөөр хэлбэл аль ч жилд засгийнхаа нэг аминд хүртэлгүй энэ шаардлага энэ 57.3-ыг биелүүлээд ирсэн байгаа юм.

Тэгээд би юу захиж гэж байна вэ гэхээр энэ орон нутгийн төсвийн зарлагдаагүй үлдэгдлийг шууд хураадаг байх хэрэгтэй, шууд хэмнэлтэд оруулж тооцдог байх хэрэгтэй. Тэгэхгүй ингээд он дамнуулчихаар маш сахилга батгүй, орон нутаг бүр зах хязгааргүй давсан төсөв батлаад, тэр нь дараа жилийнхээ ЗГ-ынхаа алдагдлыг дүүргэхээд байгаа байхгүй юу. Бид бараг хар даа, наад хагас жилээр төсвийн алдагдал гээд гараад байгаагаа задлаад хараарай. Тэрийгээ задлаад ярих хэрэгтэй байхгүй юу, тэрний чинь бараг 80, 90 хувь нь орон нутгийн төсвийн алдагдал явж байгаа. Ингээд хагас жилээр орон нутгийн төсөв чинь төсвийн хүрээгээр арайхийж батлуулсан.../минут дуусав/

Б.Заяабал: Жавхлан сайдын нэг минутыг өгье.

Б.Жавхлан: Ингээд хагас жилээр бүр ингээд төсөв дундаа ч ороогүй байхад дүүргэчихдэг учраас үлдсэн хугацаандаа улсын төсөв зөвхөн орлогодоо тааруулж л зарлагадах ийм юм руу яваад орчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр ойрын жилүүдэд ер нь гадаад нөхцөл байдал, эдийн засаг маш ийм тодорхойгүй байдлууд байгаа ийм үед та нар энэ заалтаа нэг эргэж харж янзлахгүй бол болохгүй шүү. Энэ хэзээ нэг өдөр, аль нэг ЗГ-ын аминд хүрэх ийм заалт болно. Энийг тэгэхээр 27 оны төсөв өргөн барихдаа энийг намар бүр хэлэлцүүлэг болгох ёстой, тэгээд энийгээ янзлах ёстой байхгүй юу. Энэ яах вэ 16-аас 20 онд, уучлаарай зарим гишүүдийн би нэрийг нь хэлэхгүй, зүгээр орон нутгийн төсөв барьдаг байсан гишүүд энийг санаачлаад ийм өөрчлөлт оруулчихсан юм. 11 сарын 15-нд улсын төсөв батлангуут, дараа нь 12 сарын 5-нд орон нутгийн төсөв баталдаг байхгүй юу. Өөрөөр хэлбэл сарын дараа баталдаг гэсэн үг орон нутагт төсвөө. Гэтэл сарын дараа баталдаг юмыг улсын төсөв батлахдаа УИХ энийг.../минут дуусав/

Б.Заяабал: Гишүүд, асуулт биш санал хэллээ. Гишүүд асуулт асууж дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Жавхлан гишүүнээр тасаллаа. Очирбат гишүүний микрофоныг нээе.

Г.Очирбат: Би үг хэлээд араас нь Жавхлан сайд үг хэлж цэвэршүүлэх юм байна. Ер нь тийм юм руу явчихлаа. Би энэ яг цагаан дээр хараар бичсэн аудитын тайланг барьж байгаа шүү. Санаанаасаа зохиогоод, Төсвийн тухай хуулийг санаанаасаа юм яриад байгаа юм байхгүй Жавхлан сайдаа. Уншиж үзүүлнэ. Нэгдсэн төсвийн нийт орлогыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй, хэт өндөр төлөвлөснөөс татварын орлого тасарч, татвар төлөгчдөөс 1 их наяд 247 тэрбум төгрөгийн татварын хураамжийг урьдчилан төлүүлж, тайлант оны гүйцэтгэлээр бүртгэж, тайлагнасан нь дараа оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл үүсгэхээр байна гээд, тэгээд албан шаардлага хүргүүлчихсэн бүр ийм байгаа шүү. Тэгэхээр би аудитын байгууллагад итгэдэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөндөө итгэдэг. Энэ хүмүүс Их Хурлын нүд, чих болсон хүмүүс, байнга үгийг нь авдаг, цаашдаа ч авах болно. Тэгэхээр энэ зөвлөмжүүдээ аваад, дүгнэлтдээ тааруулаад ажлаа сайжруулах энэ шаардлага нь манай ЗГ-т байгаа юм. Жил болгон хэлдэг, юу ч хийдэггүй, жил болгон сануулдаг, юу ч хийдэггүй, жил болгон зөвлөдөг, ямар ч өөрчлөлт байдаггүй.

16 оноос хойш гэж байгаа юм. Төсвийн тухай хуулийн 57.2, 57.3 зөрчилтэй хуулийн төсөл гэдгийг нь мэдсээр байж байгаад Жавхлан сайд 10 жил явуулсан байна шүү дээ. Ямар гишүүд энэний лоббиг нь хийснийг нь ч би хэлнэ. Тэгэхдээ гишүүнийх нь нэрийг хэлэхгүй гэж байна. Тэгэхээр 10 жил, та 16 оноос хойш түрүүн ингэсэн шүү дээ, 20 оны хооронд батлагдсан гэсэн биз дээ, тэгээд миний 16 гэдэг сонссон үгээрээ л би хэлж байна. Өнөөдөр 26 он, 10 жил Жавхлан сайд Сангийн сайд хийхдээ мэдсээр байж энэ хуулийн төсөл зөрчилтэйг мэдсээр байж нэг ч өөрчлөлт хийгээгүй. Тэгээд бусад энэ яамдынхандаа энийгээ намар янзлаад оруулаад ирээрэй гэж хэлж байгаа чинь ичгэвтэр сонсогдож байна шүү, Жавхлан сайдаа. Та энэ Монгол Улсын сан хөмрөгийг хэдэн жил барьж явлаа. Монгол Улсын төрийг хэдэн жил та төлөөллөө, тэгээд юм асуухаар өөдөөс нэг үгээр нэг жижигхэн хөөрхөн өгүүлбэрээр ч юм уу хариу өгөөд, тэгээд хүмүүс юм ярихаар хуулиа унш гэдэг та хэд нэг ярьдаг юмтай болсон. Та хэдээс айгаад сүүлдээ бид нар чинь ийм дандаа баримттай ярьдаг болсон шүү дээ. Ингээд харах даа та, бүгд ингээд ягаан, шараар ингээд тэмдэглээд ингэж байж л ярина. Тэгэхдээ нэг юмыг би хатуу хэлье. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, аудитын зөвлөмжөө Их Хурлын гишүүд бүтэн сайн уншиж байгаа. Бүтэн танилцаж байгаа. 2025 оны төсвийн гүйцэтгэлийг оруулж ирэхэд, чуулганаар орж ирэхэд нэгхэн хоногийн өмнө мянган хуудас материал тараасан шүү. Яаж мянган хуудас материалыг нэг урдах өмнөх өдөр нь, чуулган чинь бараг шөнийн 10 хүртэл хуралдсан, 10 11-хэн цагийн хооронд уншиж асуулт асуух юм. Ингээд л бод, юм болгоныг та хэд ингэж яг ингээд наадам дөхүүлж орж ирээд л шахаад л, шахаад л, шахаад л яваад байгаа.

Гэхдээ энэ нэг юм чинь удахгүй нэг дуусна, Жавхлан сайдаа. Тэгээд юм ярихаар өөдөөс, яах вэ мэдээж алдаа, оноотой зөндөө л энэ цаг хугацаа өнгөрч байгаа юм, зөвийг нь зөвөөр нь, бурууг нь буруугаар нь авчихгүй өөрөө энэ Монгол төрийг төдийгөөс өдий хүртэл олон жил төлөөлчхөөд одоо ингээд 10 жилийн өмнөх хууль шүү, одоо засаарай гээд ярьж байгаа чинь ичгэвтэр байна шүү. Тэгээд үг авахаар заавал араас нэг үг авч, нэг цэвэршүүлэх гэж байгаа юм шиг өгүүлбэр хэлдгээ та зүгээр л больчих хэрэгтэй. Мэдээж залуу хүмүүс бид алдаж, онож байгаа юм байгаа, та хэдээс сурах юм зөндөө байгаа, сурахгүй хаях юм ч байгаа. Тэгэхдээ хэлэх үгээ хаана ч хэлнэ, бид уншдаг, судалдаг, хуулийн дагуу ажиллах гэж оролдож байна. Та хэдийн 10 жил хийсэн завхралыг янзлах гэж бүх юмыг ил тод, шилэн, нээлттэй иргэд маань сонсооч гэдэг чиглэл рүү ажлаа хийж байгаа шүү. Баярлалаа.

Б.Заяабал: Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Очирбат гишүүнээ, тайван бай, би бас үг хэлэх эрхтэй байх гэж бодож байна. Анх удаа өөрийнх чинь ард минийх кноп таарчихлаа, өөртэй чинь би хэзээ ч ингэж ярьж үзээгүй. Анх удаа өөрийн чинь ингэж ярьж байгааг бараг сонсож байна. Тэгэхээр та өөрөө наад ярьж байгаа юмаа сольж, холиод байна. Сая хэдхэн хоногийн өмнө 5 сарын 31-нд бид 27 оны төсвийн хүрээ баталсан. Төсвийн хүрээг Эдийн засгийн хөгжлийн яам оруулж ирдэг. Тэрэн дотор чинь орлого тооцуулаад ороод ирж байгаа. Өөрөөр хэлбэл Сангийн яам Эдийн засгийн хөгжлийн яамнаасаа үүрэг авдаг гэсэн үг. Тэнд орлого, зарлагыг чинь бүх юмыг нь тооцоолоод, Сангийн яам энэнээс доош орлого алдаж болохгүй шүү, танай орлогын доод хэмжээ чинь энэ байна шүү гээд төлөвлөж орж ирдэг. Тэрний ардаас Сангийн яам явдаг Очирбат гишүүнээ, та төсвийн хүрээ батлахад сая батлалцсан байх, дахиад ч олон жил батлах байх. Тэгэхээр төсвийн хүрээгээ баталж байх үедээ та орлогод нь хэрвээ эргэлзэж байвал тэр үед нь ярих хэрэгтэй. Энэ гүйцэтгэл Сангийн яам нэгэнт ЗГ-аар ороод, Эдийн засгийн хөгжлийн яамаар тооцоолоод, УИХ баталчихсан төлөвлөгөөнийхөө хүрээнд ажилладаг гэсэн үг, энийгээ сайн ялгаж, салгаарай.

Тэр 57.3-тай холбоотой заалтыг одоо бид янзлах цаг нь болчихсон, тэр цаашаагаа энэ тусгай шаардлагатайгаа огт нийцэхгүйгээр маш хүнд явна шүү, маш хүнд явна. 27, 26 оны гүйцэтгэл ч нэг иймэрхүү гарна, 27 онд ч нэг иймэрхүү гарна. Бид орлого талдаа огт ажиллаагүй маш их зардал нэмэх, татварын орлого бууруулах ийм олон зохицуулалтуудыг оруулж ирж байсан, ар араасаа оруулж ирж байгаа. 27 оны төсөв яаж боох юм ерөөсөө санаанд орохгүй байгаа, маш хүнд боогдоно доо. Тийм учраас ер нь намар энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд би төсвийн шинэчлэл нэг дор нэг жил дуусахгүй, цаашаа үргэлжилнэ л гэж ингэж харж байгаа. Тийм учраас энэ төсвийн сахилга батыг чангаруулахад маш чухал заалт шүү. Ялангуяа сая тэр нийслэлийн төсвийг ярьж байхад гишүүд бүгд сайн ойлгосон байх гэж бодож байна. УИХ-аас, ЗГ, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны тооцооллоос гадуур орон нутгийн төсөв батлагддаг болчихсон, өөрөө удирдах ёс гээд. Тийм учраас энийг нийт төсвийнхөө хязгаар дотор оруулж, төлөвлөгөөг нь өгч баталдаг болох хэрэгтэй, яг төсвийн хүрээний мэдэгдэл шиг. Тийм л зүйл захъя даа.

Б.Заяабал: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 25 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 25 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд УИХ-ын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүн би танилцуулчихъя, Заяабал уншиж танилцуулна.

18.42 цаг

Тав.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна. Үүрийнтуяа гишүүнийг урья. Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээе.

Д.Үүрийнтуяа: УИХ-ын даргын 2025 оны 529 дүгээр захирамжаар Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 сарын 8-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл, энэхүү төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн УИХ-ын тогтоолын төсөл, мөн 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг нийт 29 гишүүнтэйгээр байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг 2026 оны 6 сарын 19-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг хэлэлцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбоотойгоор УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу зарчмын зөрүүтэй 20 санал, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураасан 5 санал дээр зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцүүлж, санал хураалгахаар Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байна.

Гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу дараах ойлголтын хүрээнд саналыг томъёоллоо. Хуулийн төслийн нэрийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль байхаар өөрчлөх, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн 34-өөс 100 хувь 100 хүртэл гэснийг 1/3-ээс гэж өөрчлөн, өмчлөлийн ангиллыг компанийн эрх зүйн зохицуулалттай нийцүүлэн, төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны эсхүл нийтийн үйлчилгээний гэж ангилах.

Ногдол ашгийн бодлогыг бүхэлд нь шинэчлэн найруулж, төрийн болон орон нутгийн өмчит компаниуд ногдол ашиг хуваарилахдаа аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэх, компанийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ, мөнгөн урсгал, санхүүгийн тогтвортой байдал болон нийтийн үйлчилгээний үүргийг харгалзан үзэх зохицуулалтыг тусгасан. Мөн арилжааны зорилготой ТӨК-ийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30-аас доошгүй хувиар ногдол ашиг хуваарилах зарчим тогтоож, тодорхой үндэслэл бүхий тохиолдолд уг хэмжээг бууруулах боломжийг бүрдүүлсэн. Харин нийтийн үйлчилгээний чиг үүрэгтэй компанид энэхүү доод босго хамаарахгүй байхаар тусгалаа.

ТУЗ-ийн хараат бус байдлыг бэхжүүлж, хараат бус гишүүдийн оролцоо болон нээлттэй сонгон шалгаруулалтын зохицуулалтыг боловсронгуй болгох. Мөн ТӨК-ийн аудит, хяналтын тогтолцоог шинэчилж, төрийн аудит болон хөндлөнгийн

аудитын зохицуулалтыг тодорхой болгох, төрийн болон орон нутгийн өмчит компани нь энгийн хувьцаа нэмж гаргах, дотоодын болон гадаадын хөрөнгийн зах зээлд санал болгох, давхар бүртгэл хийх, төрийн эзэмшлийн хувьцааг арилжих эрх зүйн үндсийг нарийвчлан зохицуулсан.

Түүнчлэн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг компанийн өрсөлдөх чадвар, засаглал, ил тод байдлыг сайжруулах, иргэд болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилготой уялдуулж, хувьцааны төвлөрлөөс сэргийлэх, хөрөнгө оруулагчдын ангиллыг тогтоох, стратегийн ач холбогдол бүхий ТӨК-ийн хувьцааг худалдах асуудлыг УИХ-аар шийдвэрлэхээр зохицуулалтыг тусгасан. Мөн ажилтанд опцион эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг шинээр бий болгохыг орууллаа. Энэ хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх шилжилтийн хугацааг тогтоож, ТУЗ-ийн шинэчилсэн шаардлагыг төрийн болон орон нутгийн өмчит компаниудад үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгалаа. Мөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хуульд заасан шаардлагад нийцүүлэн, мөн арга хэмжээг 2028 оны 1 сарын 1-ний өдрийн дотор хэрэгжүүлэхээр тусгасан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, дээрх хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Сүхээгийн Тэнгис Монгол Улсын Ерөнхий сайдын засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор, Бат-Эрдэмийн Төрбат ЗГХЭГ-ын ахлах референт, Цэрэндаваагийн Баяр-Эрдэнэ ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Даваахүүгийн Нарангэрэл ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Батсуурийн Ариунзаяа Үндэсний аудитын газрын Тамгын газрын хуулийн менежер, Ганхуягийн Давааням Монгол Улсын Хууль зүйн их сургуулийн багш, доктор, Сарангэрэлийн Батбаяр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол ХХК-ийн мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч, Очирсайханы Баярмагнай Эрдэнэс Монгол ХХК-ийн Ерөнхий аудитор гэсэн ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг төсөлд тусгасан төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-д заасны дагуу гишүүд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгаас асуулт асуух боломжтой. Ингээд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Сэддорж гишүүнээр тасаллаа. Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Ажлын хэсэг дээр яригдсан. Энэ аймгуудын уурын зуухны нүүрс, ДЦС-ын нүүрсийг бэлдэж байгаа 3, 4 аймаг дээр байна уу, тэр 8.3 дээрээ ер нь яаж орж байгаа вэ? Ажлын хэсэг дээр ярьсан гишүүдийн саналаар орж байгаа юу? Энэ уурын зуухны ч юм уу, ДЦС-ын нүүрсээ хангаад ингээд хэвийн явж байгаа, цаашдаа

ДЦС барих гээд байгаа тэр аймгуудын асуудлыг ингээд төр рүү авах гээд байгаа нь буруу уур амьсгал байсан. Энийг ажлын хэсэг ойлгосон байх. Тэгээд энэ дээр тодорхой хариулж өгөөч, протоколд.

Б.Заяабал: Ажлын хэсгээс хариулах уу? Ажлын хэсгийн ажлын хэсгийн дэд хэсгийн ахлагч Сайнзориг хариулъя. Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Ер нь та нэлээн зарчмын асуудлуудыг хөндөж тавьсан. Зарим Өмнөговь байдаг юм уу, Өвөрхангай байдаг юм уу, Сүхбаатар аймаг зэрэг аймгууд тодорхой энэ орон нутгийн хэрэгцээгээ хангах, заримдаа ч экспортын үйл ажиллагааг дэмжсэн ийм үйл ажиллагаануудыг хийж байгаа, энэний эерэг нөлөө мэдээж байна. Тийм учраас Үндсэн хуулийнхаа зөрчилд оруулчихгүйгээр уг асуудал дээрээ өнөөдрийн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явж байгаа орон нутгийн компаниудын хэвийн үйл ажиллагааг хангах зохицуулалтыг хуулийн төслийн 51.5 дээр оруулж өгсөн байгаа. Энэ дээр ямар нэгэн байдлаар өмнөх байгуулагдсан хуулийн этгээдүүд рүү эргэж буцахгүй. Гэхдээ цаашдаа эдгээр компаниуд маань компанийн засаглалын энэ шаардлага, энэ зүйлүүдийг баримтлаад явах ёстой, ТУЗ-ийн гишүүдээ нээлттэй сонгон шалгаруулдаг болох ёстой, ТУЗ-ийн гишүүдэд нь улс төрчид орж болохгүй. Ийм зүйлүүдийг дагаж мөрдөөд явна. Тэгээд өмнөх уул уурхайн компаниуд хэвийн үйл ажиллагаа явуулна.

Б.Заяабал: Мандхай гишүүн. Мандхай гишүүний микрофоныг нээе.

М.Мандхай: Хууль санаачлагчаас 3 асуулт асууя. Энэ хуулийн нэрийг, зорилго нь "Бүтээмж" гэдэг нэрийг ер нь хасаж байгаа юм байна, тийм үү? Ил тод гээд арай өөр нэртэй болж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ бүтээмж гэсэн агуулга хасагдаж байгаа нь өөрөө энэ ТӨК-ийн бүтээмж, хөрөнгийн өгөөж, алдагдал бууруулах энэ яг KPI үзүүлэлт дээр яг ямар заалтаараа яг баталгаажуулах юм бэ? Өнөөдөр яг үндсэндээ манайд ТӨК-удын засаглалтай шууд энэ бүтээмж шууд хамааралтай байгаад, бүтээмж ерөөсөө байхгүй, өсөхгүй байгаа учраас компанийн өөрөө энэ ашигт ажиллагаа, компанийн засаглал өөрөө алдагдалтай, алдаатай байгаа нэг илрэл юм. Тэгэхээр энэ хасагдаж байгаа энэ заалт дээр яг бодит үр ашиг, энэ хөдөлмөрийн бүтээмж, хөрөнгийн өгөөж, алдагдал гээд энийг бууруулахтай холбоотой яг үндсэн KPI энэ хэмжих үзүүлэлт нь өөрөө тодорхойгүй харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр яг яагаад энийг хасчхав, тэгээд энэ яг ямар заалтаар баталгаажуулах юм бэ гэдгийг нэг тодруулъя?

2 дугаарт, энэ хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй гэдгийг яг ямар эдийн засгийн шалгуур, зах зээлийн шинжилгээгээр нотлох юм бэ?

3-д нь ТӨК-ийн хувьцааг нийтэд санал болгох үед компанийн яг энэ үнэлгээ, компанийн үнэлгээг яг ямар аргачлалаар, хэн ямар хараат бус хяналттайгаар зохион байгуулах юм бэ, эсвэл тогтоох юм бэ гэдэг асуултыг асууя?

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Би 1, 3 дахь асуултад хариулъя. Ажлын хэсгээс 2 дахь асуултыг тэгээд нэмж хариулах зүйл байвал нэмээд хариулаарай. Бүтээмж, ил тод

байдал, засаглалыг сайжруулах хууль гээд нэр томьёон дээр ажлын хэсгийн хүрээнд нэлээн ярилцсан. Зөвхөн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль байх уу ч гэж ярьсан. Сая гүйцээн боловсруулах чиглэл дээр яг энэ нэрэн дээрээ өөрчлөлт аваад, засаглал гэдэг үгийг бид сая нэмж оруулж ирж байгаа. Ер нь бүтээмж, ил тод байдал өөрөө засаглалын л нэг бүрэлдэхүүн хэсэг, засаглалын л нэг агуулгын хэсэг. Яг энэ ЗГ-аас өргөн барьсан, хууль санаачлагчийн өргөн барьсан энэ агуулгаар илүү их процессын асуудал орж ирээд байна гэж манай гишүүд үзэж байгаа юм. Процесс, бүтээмжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах гэдэг ерөөсөө процессын асуудлаар хуулийг нэрлээд байна гэдэг ийм шүүмжлэлүүд дагуулсан.

Ер нь ТӨК-удын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд засаглалын хамгийн оновчтой бүтцээр ажиллах нь суурь асуудал болчихоод байгаа юм. Засаглалын асуудлуудыг шийдэх ёстой. Бүтээмжийг хэмжих шалгуур үзүүлэлт нэгж, анхнаасаа ажлын хэсэг, анхнаасаа хууль санаачлагчийн хувьд яг бүтээмжийн шалгуур үзүүлэлт, нэр нь бүтээмж гэдэг боловч тэрэн дотор бүтээмжийг тусгайлан зүйл, заалтаар оруулж ирсэн зүйл байгаагүй. Би өөрөө УИХ-ын гишүүний хувьд яг анх энэ хэлэлцэх эсэхийг нь явж байхад энэ асуултыг асууж байсан. Засаглалыг сайжруулснаараа, компанийг ил тод болгосноороо, нээлттэй болгосноороо энэ бүтээмж нэмэгдэх боломж, суурийг нь олгож байгаа гэдэг үндсэн концепцоор үзэл баримтлалаа тайлбарлаж байсан. Тэгэхээр энэ хүрээнд ойлгож болно гэдгийг хэлье.

2 дахь асуудал хувийн хэвшлийн дангаараа хийх боломжгүй ажил дээр ажлын хэсгээс хариулъя.

3 дахь дээр нь ямар санал орж ирлээ энэ дээр чинь? Энэ дээр ажлын хэсэг 2 дахь дээр нь хариулчихъя, ажлын хэсэг нэмээд хариулчихъя.

Б.Заяабал: Ажлын хэсгээс хэдэн номер вэ? 4 номерын микрофон нээе.

Д.Цолмон: Мандхай гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. ЗГХЭГ Цолмон. Хуулийн төсөл дээр ер нь хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх энэ зарчмыг тодорхой тусгасан байгаа. Хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, санхүүгийн үр ашиггүй тохиолдолд нийтийн үйлчилгээний зорилгоор ТӨК байгуулахгүй гэдэг энэ санал хэлэлцүүлгийн явцад тусгагдаад явж байгаа. Тэгэхээр хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй гэдгийг бид нар яаж үнэлэх аргачлал нь энэ хуулийн төсөлд тодорхой тусгагдаагүй. Гэхдээ тухайн төрлийн ТӨК-ийг үүсгэн байгуулах энэ санал дээр тодорхой зах зээлийнхээ судалгааг хийж ирэх, тухайн салбар дээр хувийн хэвшил дангаараа тэр ажил, үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй байгаа гэдгээ тухайн компанийг үүсгэн байгуулах санал гаргаж байгаа салбарын ЗГ-ын гишүүн маань энийгээ судалгаа хийж орж ирэх ёстой ийм байдлаар ойлгож байгаа.

Б.Заяабал: 2 номерын микрофон, ажлын хэсгийн 2 номерын микрофон гүйцээгээд хариулъя.

С.Батбаяр: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хууль зүйн сургуулийн багш Батбаяр байна. Эхний асуулттай холбоотой нэмэлтээр хэлэхэд, засаглал юуг, бүтээмжийг нэмэгдүүлэх гэдгийг авснаараа хуулийн төсөлд жишээлбэл ямар

тодорхой заалтаар энийг үлдээж байгаа вэ гээд, хуулийн төслийн 39 дүгээр зүйл болон 40 дүгээр зүйл дээр компанийн бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, 40 дүгээр зүйл дээр компанийн гүйцэтгэлийн үнэлгээ гэсэн ийм 2 шалгуур үзүүлэлтүүдийг яг тэр ашгийн төлөө зорилготой компаниуд дээр ямар байдлаар үнэлэх вэ, нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлж байгаа компаниуд дээр ямар байдлаар үнэлэх вэ гэдгийг нэг бүрчлэн нарийвчлан тодорхойлоод, тэгээд гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын зохицуулалт дээр компанийн үр ашиггүй буюу 2 жил дараалан үр ашиггүй ажиллуулсан бол гэдэг компанийн ажлаас нь чөлөөлөх ийм үндэслэлүүд болсон гэдэг байдлаар энэ бүтээмжийг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг оруулж өгсөн. Дээр нь нэмээд төрийн болон орон нутгийн өмчийн компани ногдол ашиг хуваарилах ногдол ашгийн бодлого дээрээ хуваарилах үүрэгтэй. Зорилтот хувийг.../минут дуусав/

Б.Заяабал: Мандхай гишүүн тодруулга.

М.Мандхай: Би 3 асуулт асуусан, нэгэнд нь яг бодитой хариулж чадсангүй. Би ойлгохдоо Corporate Governance буюу компанийн засаглал өөрөө энэ компанийн зүгээр удирдлага, хяналт, тэр хариуцлага, ил тод байдлын шийдвэр гаргалтыг илүү гаргаж өгдөг гэж хардаг. Бүтээмж гэдэг Productivity арай өөр шүү. Энэ өөрөө илүү нөгөө хөдөлмөр, хөрөнгө, нөөц, үр ашигтай холбоотой асуудал байхгүй юу. Зүгээр засаглал сайжирснаар компанийн бүтээмж сайжирна гэдэг ойлголт буруу юм. Ил тод байдал гэдэг чинь угаасаа засаглалын нэг хэлбэр болохоор өөрөө ингээд бараг засаглалыг задлаад ингээд нэр томъёог нь биччихсэн. Манайд өнөөдөр улсад ерөөсөө ашиггүй энэ төсвийн зарцуулалт ашиггүй энэ байгаад байгаа асуудал ерөөсөө шууд бүтээмжтэй холбоотой юм. Тийм учраас би "Бүтээмж" гэдэг үгийг ер нь оруулж өгвөл яасан юм бэ гэдэг саналтай байна.

2 дугаарт, энэ хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй гэдэг дээр хууль санаачлагч өөрөө тодорхой оруулж ирээгүй юм байна.

Б.Заяабал: Ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн дарга Сайнзориг дарга, Үүрийнтуяа дарга, дараа нь Сайнзориг дарга нэмье.

Д.Үүрийнтуяа: Бүтээмж бол гарц, орцын харьцаагаар л тодорхойлогддог үзүүлэлт л дээ. Хамгийн бага орцоор хамгийн их бүтээгдэхүүн гарцыг үйлдвэрлэх л зорилготой. Тэр орцонд олон төрлийн хүчин зүйл нөлөөлдөг. Түүнд санхүү, хөрөнгө, хүч, түүхий эдээс гадна менежментийн асуудлууд гээд олон зүйл ордог. Эцсийн дүнд гарч байгаа бүтээгдэхүүн гарц хамгийн үр дүнтэй, чанартай, өгөөжтэй байхыг л бүтээмжээр хэмжиж байгаа хэмжүүр л дээ энэ бол. Тэгээд таны асуусан ТӨК-ийн үнэлгээг хэрхэн, яаж хийх вэ гэдэг дээр минут хүрсэнгүй. Би нэмээд энэ дээр хариулъя, тэгээд энэ олон улсын үнэлгээний компаниар хийлгэдэг бид жишигтэй л дээ, одоо ч ТӨК-уд тэгж хийлгэж байгаа. IPO хийлгэх компани нэн шаардлагатай хувьчлах гэдэг юм уу, шаардлагатай компани, энэ компани олон улсын аудит хийх ёстой юм гэдгийг ЗГ-аас гаргаж өгөх юм. Нэрсийг нь гаргаж өгөх юм энэ хуулиар, тэр гаргаж өгсөн компаниуд дээр олон улсын аудит.../минут дуусав/

Б.Заяабал: Нэмэлт хариулт Сайнзориг гишүүн өгөх юм уу, ажлын хэсгийн дэд дарга Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Би Үүрийнтуяа даргатай давхцуулахгүйгээр хэлчихье гэж бодож байна. Ер нь зүгээр засаглалын хүрээнд мэдээж энэ агуулгууд багтаж байгаа. Тэгэхдээ энэ төрийн өмч гэдэг юм уу энэ талдаа, төрийн байгууллага талдаа бүтээмж дээр энэ аливаа энэ асуудлууд үйл ажиллагаа явуулах процессын асуудал байдаг. Процесс нь ямар нэгэн байдлаар шударга, ил тод байх асуудал. Энэ дээрээ мэдээж засаглалыг дагаад үр ашигтай ажиллах, энийг нөгөө төсвийн бодлоготойгоо уялдуулах, энийгээ дагасан урамшуулал, хариуцлагын асуудал гээд бүх л юугаараа орчхож байгаа учраас таны санаа зовниж байгаа энэ асуудлууд бүгд багтсан байгаа гэдэг зүйлийг би Мандхай гишүүнд хэлмээр байна.

Хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжгүй гэдэг үндсэндээ тодорхой сектор болгон дээр зах зээлийн судалгаа хийнэ. Энэ хуулийн 9.4 дээр ямар, ямар асуудлуудыг үнэлж авч үзэх вэ гэдэг энэ судалгаануудыг үндэслэж байж компанийг байгуулах эсэх асуудал шийдэгдэх юм. Тэгээд энэ судалгааг хийж байж 8 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу компани байгуулах асуудал яригдана. Тийм учраас.../минут дуусав/

Б.Заяабал: Мандхай гишүүний нэмэлт тодруулга өгье.

М.Мандхай: Энэ ТӨК-ийг олон нийтэд нээлттэй болгох процесс дээр угаасаа олон улсын аудитаар үнэлгээ хийлгэдэг л дээ. Тэгсэн гээд тэр компанийг хэрэв төрийн өмчийн эзэмших хувь хэмжээ өөрөө давамгай байвал дахиад л нөгөө засаглалын асуудал чинь алдагдана. Тэгэхээр энэ төрийн өмчит компанийн засаглалыг сайжрууллаа ч гэсэн хэрэв төр өөрөө л давамгай 51-ээс дээш хувь эзэмших л юм бол манай засаглалын асуудал яг сайжирна гэдэг ийм баталгаа ер нь харагдахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ стратегийн хөрөнгө оруулагчид худалдах энэ зохицуулалтыг ер нь энэ төрийн өмчийг үнэгүйдүүлэх, хаалттай хэлэлцээр хийх энэ эрсдэл байгаа шүү дээ. Тэгэхээр энийг яаж энэ эрсдэлээс хамгаалах юм бэ?

Б.Заяабал: Ажлын хэсгийн дэд дарга Сайнзориг гишүүн хариулна.

П.Сайнзориг: Мандхай гишүүн уг нь чухал юм ярьж байна. Хуулийн төслийг бид нар том зургаар нь яг харвал таны яриад байгаа асуудлууд хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр тусгагдаж байгаа. Энэ ТӨК-ийн талаар баримтлах өмчлөлийн бодлого гэдэг зүйлийг УИХ батална, компани компаниар. Энэ компанийн ямар хувийг, 10 хувийг энэ жилдээ, засаглалыг нь сайжруулаад олон нийтийн хяналтыг бий болгох замаар дахиад дараагийн жил үнэ цэнийг нь өсгөж байгаад 15 хувийг нь ч гэдэг юм уу, энэ шийдвэр гаргах энэ зүйлүүд нь УИХ-даа хадгалагдаж байгаа. Тийм учраас энэ хууль батлагдсан тохиолдолд хэрэгжихээс өмнө энэ бодлогын бичиг баримтыг ЗГ-аас өргөн барина. Өнөөдөр төрийн өмчит 100 орчим компанийн 14 орчмыг нь нэгтгэж нийлүүлээд явж байна. Цаашдаа үлдэж байгаа компаниудыг ямрыг нь авч үлдэх, ямрыг нь олон нийтийн болгох, ямрыг нь хэдий хугацаанд, аль хугацаанд олон нийтийн болгох вэ, ямар хувь хэмжээгээр вэ гэдэг зүйлийг бид нар УИХ намар энэ өмчлөлийн бодлого дээрээ ярих юм. Тэгэхээр энэ асуудлууд.../минут дуусав/

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Санал хураалтыг Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу нэгтгэж санал хураалтаа явуулъя.

19.04 цаг

Зургаа.Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудлын дараагийн хэлэлцэх асуудалд орцгооё. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудтай холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд хуулийн төсөлтэй холбоотой санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Санал хураалтыг мөн нэгтгэж явуулъя.

19.05 цаг

Дараагийн хэлэлцэх асуудал. Уг хуулийг дагалдаж мөн Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр товд тусгачихсан. Энэ хэлэлцэх асуудал нь хуулийн санал хураалт дээр 37 дугаар зүйлийн санал хураалтын дагуу тодорхой болох, хэлэлцэх асуудал нь тодорхой болохоор байгаа. Тийм учраас энэ асуудлыг санал хураалтын дараа болгож хойшлуулъя.

Дараагийн хэлэлцэх асуудал, 8 дахь асуудал, Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслүүдийг нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулахаар байгаа. Ажлын хэсэг сая хуралдаж, дөнгөж дуусаад, саналын томъёоллуудаа гишүүдэд хүргүүлэх, хувийг олшруулах ажлын хэсгийн ажилтай байгаа учраас энэ асуудлыг мөн хойшлуулж хэлэлцье.

Долоо.Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Ингээд хэлэлцэх асуудлын тов дээр байгаа 9 дэх асуудал болох Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайвангийн Бат-Амгалан танилцуулна. Бат-Амгалан сайдын микрофоныг нээе. Ажлын хэсэг мөн оруулаарай, ажлын хэсгийг оруулаарай. Бат-Амгалан сайдын микрофоныг.

Э.Бат-Амгалан: Эдийн засгийн байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд иргэдийн орон

сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, хот, суурин газрын төлөвлөлтийг боловсронгуй болгох, бүсчилсэн хөгжлийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Орон сууцжуулалтын тухай болон Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай анхдагч хуулийн төслүүдийг боловсруулж, 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслүүдийг УИХ дахь намын бүлэг, зөвлөлүүдээр хэлэлцүүлээд байна.

Өнөөдөр Монгол Улсад 1 сая орчим өрх амьдарч байгаагаас 1/3 орчим нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцад, үлдсэн хэсэг нь гэр болон стандартын шаардлага бүрэн хангаагүй сууцад амьдарч байна. Агаар, хөрсний бохирдлын дийлэнх эх үүсвэр нь эдгээр бүсээс шалтгаалж байгаа нь орон сууцжуулалтын бодлогыг шинэ шатанд гаргах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал, ипотекийн зээлийн хөтөлбөрөөр нийт 11 их наяд төгрөгөөс давсан санхүүжилт олгож, 144 мянга гаруй өрхийг орон сууцтай болгоход дэмжлэг үзүүлсэн хэдий ч гэр хорооллын бүсийн хэмжээ дорвитой буураагүй байна. Мөн орон сууцны үнэ жил бүр инфляцын түвшнээс давсан буюу дунджаар 15 орчим хувиар өссөөр байгаа нь орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн зөрүү нэмэгдэж, зөвхөн эрэлтэд суурилсан санхүүжилтийн бодлогоор асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 16 мянга орчим орон сууц ашиглалтад орж байгаа ч ипотекийн зээлийн эрэлт үүнээс давж, жил бүр 19 мянга орчим шинэ хүсэлт арилжааны банкнуудад ирж байна. Гэвч дунджаар 9.5 мянган хүсэлтийг шийдвэрлэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 47 мянга гаруй өрхийн хүсэлт хуримтлагдаж, 6.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн хэрэгцээ үүсээд байна.

Түүнчлэн өрхийн орлогын судалгаагаар нийт өрхийн 70 орчим хувь нь ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр бүрдүүлэх боломжгүй байгаа нь орон сууцны санхүүжилтийн хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна. Ялангуяа бага, дунд орлоготой болон залуу өрхүүд орон сууцтай болох боломж хязгаарлагдмал хэвээр байна. Нөгөө талаас орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд газар хөгжүүлэлт, инженерийн дэд бүтцийн асуудал гол саад болж байна. Дэд бүтэцгүй газарт орон сууцны төсөл хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг урт хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага бий болсон. Иймээс орон сууцжуулалтын бодлогыг зөвхөн ипотекийн зээлээр хязгаарлах бус газар хөгжүүлэлт, дэд бүтэц, орон сууцны нийлүүлэлт, санхүүжилтийн тогтолцоо, нийгмийн хамгааллын бодлоготой уялдуулан цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн төслүүд батлагдсанаар төрөөс хэт хамааралтай санхүүжилтийн тогтолцооноос зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоонд шилжинэ. Орон сууцны зээлийн хүртээмж нэмэгдэнэ. Төрийн санхүүгийн ачаалал буурна. Хөрөнгийн зах зээл хөгжиж, санхүүжилт нэмэгдэнэ. Төрөөс орон сууцны төслүүдийг бодлогоор дэмжиж, батлан даалт гаргана. Зорилтот бүлгийн иргэдэд зээлийн батлан даалт гаргана. Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулна. Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг уялдуулж, цогцоор нь шийдвэрлэнэ. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, урт хугацааны тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкыг байгуулна. Тус банк нь зах зээлээс эх үүсвэр татан төвлөрүүлж, арилжааны банкнуудаар дамжуулан ипотекийн зээлийн санхүүжилтийг тогтвортой хангах бөгөөд төрийн эзэмшлийн хувь хэмжээ 34 хүртэл хувь байна.

Мөн Орон сууцжуулалтын тухай хуулийн хүрээнд Үндэсний орон сууцны корпорацыг байгуулж, ижил төстэй чиг үүрэг хэрэгжүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн оновчтой болгохоор төлөвлөж байна. Энэ хүрээнд Төрийн орон сууцны корпорац болон Нийслэлийн орон сууцны корпорац зэрэг ижил төстэй байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэж, орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, түрээсийн орон сууцны санг хөгжүүлэх, зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хүртээмжийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна. Эдгээр хуулийн төслүүд хэрэгжсэнээр орон сууцны нийлүүлэлт нэмэгдэж, санхүүжилтийн хүртээмж сайжирч, гэр хорооллын дахин төлөвлөлт эрчимжихээс гадна урт хугацааны иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарыг дээшлүүлэх чухал нөхцөл бүрдэх юм. Иймд Орон сууцжуулалтын тухай болон Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай анхдагч хуулийн төслүүдийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Б.Заяабал: Бат-Амгалан сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Энхтайвангийн Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД, Оюуны Одбаяр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын дарга, Бямбабаатарын Сүхбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга, Содномдаржаагийн Бүжмаа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Баярсайханы Марал Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцны бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Базарсадын Мөнхзул Монголбанкны Санхүүгийн зах зээл, валютын газрын Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн захирал, Өлзийбатын Мөнх-Ундарга Монголбанкны Хуулийн газрын Гэрээ, эрх зүйн нийцлийн хэлтсийн захирал, Батжаргалын Энхдалай Монголбанкны Санхүүгийн зах зээл, валютын газрын Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн ахлах эдийн засагч, Цогтбаатарын Мягмарчулуун Монголбанкны Санхүүгийн зах зээл, валютын газрын Дотоод зах зээлийн үйл ажиллагааны хэлтсийн ахлах эдийн засагч. Ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Гишүүдийн нэрс авъя. Мандхай гишүүнээр тасаллаа. Мандхай гишүүний микрофон өгье. Сэддорж гишүүн нэмэгдсэн байна, Сэддорж гишүүнээр тасаллаа.

М.Мандхай: Яг үнэнээ хэлэхэд энэ хуулийг нарийн сайн уншиж судалж амжсангүй. Гэхдээ энэ ирсэн материалууд дээр ингээд харахаар энэ ипотекийн санхүүжилт нэмэгдэхийн хэрээр энэ орон сууцны эрэлт өөрөө өсөх ийм төлөвтэй харагдаад байгаа. Орон сууцны үнэ жилд дунджаар 25-аас 30 хувь өсөх ийм хандлагатай гэсэн ийм тооцоолол байна. Тэгээд энэ төсвийн болон өрийн эрсдэл яг үндсэндээ яг бүрэн тооцогдсон юм уу? Корпорац баталгаа гаргах юм байна, батлан даалт гаргана, үнэт цаас, өрийн бичиг гаргана, зээл авах боломжтой гээд. Тэгээд энэ батлан даалт хэрэгжих үед улсын төсөвт өр үүсэх үү гэдэг асуулт байна?

Сангийн яамны энэ эрсдэлийн үнэлгээ, дээд хязгаар, энэ УИХ-ын хяналт жишээлбэл ямар байх нь тодорхой харагдахгүй байгаад байна.

2 дугаарт, ипотекийн батлан даалтын эх үүсвэрийн нийлүүлэлт гээд энэ дэд бүтцийн бэлэн байдалгүйгээр нэмэх юм бол эрэлт угаасаа, эрэлтийг дэмжиж орон сууцны үнэ өсөх эрсдэлтэй байгаа. Тэгэхээр энэ үнэ тогтворжуулах янз бүрийн энэ бодит нэмэгдлийг хэмжих тийм хэмжүүр үзүүлэлт KPI байна уу гэдгийг асууя?

3 төрлийн энэ хөрөнгө оруулалт, нийгмийн орон сууц гэж байгаа юм. Яах вэ, жишээлбэл Англи улсад консул хаус гээд байдаг. Тэгээд энэний зохицуулалтыг яаж хийх юм бэ? Ингээд хүсэлтээ өгөөд процессын хувьд, жишээлбэл би байргүй ахмад настан байлаа гэж бодъё, тэгээд энэ улсын нийтийн энэ орон сууцад хамрагдъя гэвэл процессын хувьд яг яаж явах юм бэ? Хэр удаан хугацаанд амьдрах юм бэ, эсвэл энэ дээр үүсэх эрэлтийг яаж зохион байгуулна гэж харж байгаа юм бэ гэдгийг тодруулъя? Эхлээд хариултаа авчхаад, тодруулъя.

Б.Заяабал: Бат-Амгалан гишүүний микрофоныг нээе. Бат-Амгалан сайд хариулъя.

Э.Бат-Амгалан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Ер нь зүгээр улсын төсөв дээр ямар нэгэн дарамт ирэх үү гэж, улсын төсөв дээр ер нь ямар нэгэн дарамт ирэхгүй. Харин өнөөдөр явагдаж байгаа энэ 6 хувь, 3 хувийн аймаг, орон нутагт шилжин ажиллаж байгаа иргэдийн ипотекийн зээлийн татаасанд жил болгон тодорхой хэмжээний татаасыг улсын төсвөөс өгч байгаа. Энэ хууль батлагдсанаар цаашдаа энэ татаас олгохгүйгээс гадна цэвэр бизнесийн зарчмаараа явна, 1 дүгээрт.

2 дугаарт, энэ төрөлжсөн банк гэдэг маань ер нь бөөний банк гэж ойлгож болно. Түүнээс арилжааны банкнуудтай өрсөлдөөд, иргэдэд зээл олгоод ийм зүйл байхгүй. Урт хугацааны эх үүсвэрийг л босгож, өнөөдөр явагдаж байгаа, ажиллаж байгаа арилжааны банкнуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, өнөөдөр үүсчихсэн байгаа, өргөдлөө өгчихсөн байгаа 47 орчим мянган иргэдийн 4-өөс 5 жил хүлээх дарааллыг 1-ээс 2 жил рүү шахах ийм л процессын гол ажил байгаа 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт, тэр таны тантай яг санал нэг байна. Тэр Англид явагдаж байгаа тэр түрээсийн орон сууцны энэ асуудлууд, ипотекийн асуудлуудыг бид нэлээд олон газруудад, олон улсын судалгаанууд бид хийгдсэн. Тийм учраас яг өнөөдөр Үндэсний орон сууцны корпорац байгуулагдсанаараа энэ дахиад нэг шинэ байгууллага байгуулах гээгүй. Өнөөдөр жишээ нь нийслэл дээр Нийслэлийн орон сууцны корпорац, Нийслэлийн Улаанбаатар орон сууц юу билээ гээд нэлээ хэдэн, Төрийн орон сууцны корпорац гэсэн нэлээд хэдэн байгууллагуудын чиг үүргийг нэгдсэн нэг ойлголттой, давхардалгүйгээр болгож өөрчлөн байгуулж, татан буулгах замаар энэ Үндэсний орон сууцны корпорац ажиллах юм.

Энэ Үндэсний орон сууцны корпорац энэ иргэдэд зээл олгохгүй. Өнөөдөр газар чөлөөлөлт дээр ажиллаж байгаа, дэд бүтэц дээр ажиллаж байгаа үндэсний хэмжээний дунд, жижиг компаниудыг тэр дэд бүтэц хийхэд нь, тэр барилга орон сууц барихад нь бас бэлэн мөнгө олгохгүй. Зүгээр батлан даалт гаргах журмаар, арилжааны банкнуудад батлан даалт гаргах журмаар энэ дотоодын компаниудыг

дэмжиж, төр, хувийн хэвшил хамтарсан энэ үйл ажиллагаа явуулна гэж ингэж харж байгаа.

Дараагийн тэр нөгөө ипотекийн зээлийн асуудал. Өнөөдөр өнгөрсөн хугацаанд ипотекийн зээл авсан нийт иргэдийн дундаж нас 36 нас байгаа. Гэтэл 18-аас 34 насны залуучууд энэ зээлд хамрагдахгүй, шалгуур хангах үзүүлэлтүүдээ дийлэхгүй байгаа. Урьдчилгаа, энгийнээр хэлэх юм бол урьдчилгаа төлбөрөө төлж дийлэхгүй байгаа, тэр энэ хуулийн зохицуулалт, энэ хуульд суусан байгаа. Жишээ нь 30 хувийн урьдчилгааг 50 хувиар бууруулах ийм боломж байгаа. Тэр нөгөө Англид яг хэрэглэгддэг түрээс буюу түрээслээд өмчлөх энэ хэлбэрийг бид нар энэ хуульдаа Монголын нутагт нутагшуулж, зохицуулж оруулсан. Энгийнээр хэлэх юм бол өнөөдөр 100 метр квадрат талбайтай байрыг 50 хувийг нь ипотекийн зээлд хамрагдана, 50 хувийг нь түрээслээд өмчлөх энэ хэлбэр рүү иргэний өөрийнх нь санхүүгийн боломж дээр тулгуурлаж хийх ийм зохицуулалтууд явсан. Тэр гэрээ хийж байгаа тухайн үеийн нөхцөлийн зах зээлийн үнэлгээгээр энэ 10 жилийн дараа, 20 жилийн дараа төлбөрөө хийхдээ тэр үнэлгээгээрээ оруулах ийм олон давуу талуудыг энэ хуулийн зохицуулалтдаа оруулж өгч байгааг хэлье.

Б.Заяабал: Мандхай гишүүн тодруулъя. Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр энэ нөгөө 3.15 тэрбум төгрөг гэхихсэн нэг ийм зардлын тооцоон дээр байсан. Тэгэхээр энэ орон сууцны татаас, дэд бүтэц гээд та түрүүн хэллээ шүү дээ, газар чөлөөлөлт гээд батлан даалт хэрэгжих үед яг энэ болзошгүй ер нь өр төлбөрийн тооцоо яг юу гэж гарсан юм бэ гэдгийг нь холбогдох хүмүүсээс нь асууя? Ер нь ийм өр төлбөр гарах уу?

2 дугаарт, корпорацын энэ төлөвлөлт, санхүүжилт, баталгаа, төслийн санхүүжилт, сонгон шалгаруулалт, орон сууцны сангийн хуваарилалт гээд энэ нэг олон чиг үүрэг ингээд давхацсан байдлыг хариуцах юм байна. Тэгэхээр энд янз бүрийн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах ямар зохицуулалтыг оруулж өгөх юм бэ гэдгээс?

3 дугаарт, энэ түрүүн хэлсэн нийгмийн орон сууц нь 50 хувь юм байна, хөлсний орон сууц нь 15 хувь юм байна. Тэгээд хөлслөөд өмчлөх орон сууцны хувь хэмжээ нь хэд вэ? Тэгээд энийг ямар судалгаагаар, тооцоогоор үндэслэж гаргаж ирсэн юм бэ? Энэ нь өөрөө зорилтот бүлгийн бодит хэрэгцээнд яг.../минут дуусав/

Б.Заяабал: Ажлын хэсгийн нэг номерыг өгье.

Э.Батболд: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Инженерийн хэлтсийн дарга Батболд. Батлан даалт гаргахыг корпорац өөрийн тогтоосон дүрмийн сангийнхаа хэмжээнд тооцож, батлан даалт гаргахаар тооцсон. Мөн дээрээс нь өөрийн дүрмийн сангийн 20-оос хэтрэхгүй хувь дээр нэг төсөл дээр батлан даалт гаргах зохицуулалтуудыг оруулж ирсэн байгаа. Мөн Зээлийн батлан даалтын сангийн хуультай адилхнаар өөрийн эх үүсвэр, дүрмийн санг 20 дахин нэмэгдүүлсэн хэмжээнд тийм батлан даалт гаргах нөхцөлийг зохицуулж байгаа. Тэгэхээр энэ дээрээ тааруулаад зээлээ олгоно.

Нийгмийн орон сууц маань тухайн төслийн 5 хүртэл хувь дээр байгаа, 15 хүртэл хувь дээр нь хөлсний орон сууц, 25 хүртэл хувь дээр нь хөлслөөд өмчлөх

орон сууц байгаа. Энэ тооцоо, хувь хэмжээг гаргахдаа тухайн төслийн өөрийнх нь өртөг дээр нь суурилж, зорилтот бүлэгтээ чиглэсэн орон сууцныхаа хувь хэмжээ дээр тооцсон. Яг нийгмийнхээ бүлэгт нь тааруулсан тоогоор биш, илүү төслийнхөө илүү үр ашигтай, урт хугацаанд санхүүгийн байдал тогтвортой байх үүднээс нь энэ тооцооллыг гаргаж оруулсан байгаа.

Б.Заяабал: Мандхай гишүүн, нэмэлт хариулт дээр Бат-Амгалан сайд нэмэлт тодруулга өгчихье.

Э.Бат-Амгалан: ЗГ-аар энэ хөлслөөд өмчлөх, хөлслөх энэ нийгмийн орон сууцны байрнуудыг зохицуулах журам гарч батлагдсан байгаа. Энэ журмын дагуу энэ таны асуусан асуулт, ашиг сонирхлын зөрчлийг яаж барих вэ гэж энэ журмаараа явна. Энэ журам нь болохоор урьд нь зүгээр байгууллагын дарга нэг ажлын хэсэг гаргаад гэдэг юм уу, нэг удирдах зөвлөлийн маягаар шууд шийдээд явчихдаг байсан. Одоо цахим болсон, санамсаргүй тохиолдлоор, сонгон шалгаруулалтаар авна. Саяын хэлдэг нөгөө жишээ нь зорилтот бүлэг гээд ингэхэд зорилтот бүлэг дотроо 10-аас 15 хувь нь ахмадуудад гэж байвал нийт төрийн өмчийн саяын төслийн байрнуудаасаа 10-аас 15 хувьд нь ахмадууд оруулна. Энэ нь сонгон шалгаруулах журмаар, цахимаар, санамсаргүй байдлаар шалгаруулах ийм зохицуулалт орсон байгаа, ЗГ-аас баталсан журмын дагуу.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга, Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр энэ тооцоолол чинь өөрөө одоо хүсэлт гаргачихсан байгаа нийт төлбөрийн ер нь чадваргүй зорилтот бүлэгт нийт хүсэлт гаргачихсан байгаагийн хэдэн хувийг энэ хууль хэрэгжсэнээр 2027 он, 2028 он хүртэл ч гэдэг юм уу эхний 3 жилийн байдлаар хамруулах вэ гэдэг нэг асуулт байна?

2 дугаарт, би Монголбанкнаас асууя. Эдний ингээд энэ хуулийн дагуу яриад байгаа батлан даалт гаргахдаа дүрмийн сангийн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх гэдэг тооцоолол байгаа. Тэгээд энэ нь өөрөө батлан даалт, дэд бүтэц, газар чөлөөлөлт, орон сууцны татаас гээд энэ олон зардлын тооцоо үүснэ. Тэгээд энд үүсэж болзошгүй ер төлбөрийн тооцоон дээр ер нь эрсдэл байгаа гэж харж байгаа юу гэдгийг Монголбанкнаас асууя?

Б.Заяабал: Ажлын хэсэг хэдэн номер вэ? Ажлын хэсгийн 3 номер.

Б.Мөнхзул: Мандхай гишүүний асуултад хариулъя. Яг энэ Орон сууцжуулалтын тухай хуулийнх нь дагуу энэ орон сууцны корпорац гэж орж ирж байгаа, корпорац нь өөрөө орон сууцныхаа нийлүүлэлтийн тал дээр ажиллана. Зөвхөн дэд бүтэц, газар чөлөөлөх болон түүнтэй холбогдуулан бүтээн байгуулалттай холбоотой ААН-үүдийг зээл авахад нь батлан даалт гаргана. Тэгэхээр энэ яг цэвэр зах зээлийнхээ механизмаар л явна. Арилжааны банкнууд, Хөгжлийн банкин дээр ААН-үүдэд нь зээл олгоод, зээлийнх нь барьцаа хөрөнгө дээр дутагдалтай бол батлан даалтын үйл ажиллагаа энэ сангаар дамжаад л явна. Хэрвээ ямар нэгэн байдлаар ер төлбөр үүсэх юм бол энэ өөрөө цэвэр ААН-ийнхээ зарчмаар явна. Зээлийг нь арилжааны банкнууд олгоод явна. Төсөв дээр ямар нэгэн дарамт болон төсвийн өмнөөс хүлээх үүрэг хүлээгдэхгүй энэ дээр. Одоо байгаад байгаа энэ Зээлийн батлан даалтын хууль болон одоо энэ яг явагдаад байгаа санхүүгийн схемийн дагуу энэ цэвэр арилжааны банк.../минут дуусав/

Б.Заяабал: 3 номерын микрофон нээе, хариултаа гүйцээе.

Б.Мөнхзул: Цэвэр арилжааны банкнууд болон төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниудын өөрсдийн л гэрээний эрх зүйн эрх, үүргийн харилцаа болно. Арилжааны банкнаас авсан зээлээ хэрвээ төлөхгүй байх юм бол энэ барьцаанд тавьсан эд зүйлсээ хураалгаад, шүүхийн журмаар үйл ажиллагаа нь дараагийн шатандаа л явна гэсэн үг. Энэ дээр төсөв болон орон нутгийн болон улсын төсөв дээр ямар нэгэн ачаалал огт ирэхгүй.

Б.Заяабал: Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Энэ чухал хуулийг дэмжиж байгаа. Санхүүжилт нь ипотекийн банкнаас юм байна, тийм үү? Тэгээд Бат-Амгалан сайд, Бат-Амгалан сайд таны хамгийн гол бодох ёстой зүйл энэ төвлөрлийг сааруулъя гэж ярьж байгаа. Төвлөрлийг яаж сааруулах юм бэ гэхээр ерөөсөө таны энэ ипотекийн зээлээс чинь л болно. Та Улаанбаатарт их зээл өгөөд байвал бүгд л энд төвлөрнө. Тэгээд 21 аймагтаа таруу яаж амьдрах вэ гэдэг чинь ерөөсөө наад танай яамны бодлогоос шалтгаалах гээд байна. Монголбанкны бодлого энэ тэр ипотекийн зээлийг хаана хуваарилаад байгаа юм бэ? Тэгэхээр 21 аймагт чинь энэ зээлийг авах гэсэн, тэр аймаг руу шилжих гэсэн, тэр уул уурхайн төслүүд дээр ажиллах гэсэн, энд ажилгүй байснаас тэр хил дээр очиж ажлын байртай болох гэсэн ийм хүмүүс маш их байгаа.

Тэгэхээр энэ дээр та ямар бодолтой байна, яам ямар бодлоготой байна, энэ хууль энийг яаж дэмжих вэ? Энэ хамгийн чухал асуудал шүү. Улаанбаатар хот аяндаа өөрийнхөө инерцээрээ цаашдаа улам сайхан болно, энэ хөдөө 21 аймаг, энэ аймгуудад чинь амьдрал байна, ажлын байр маш их байна, Монголд ажилгүйдэл ер нь байхгүй шүү. Өдөрт 150 мянган төгрөгөөр ажил хийх хүн олдохгүй байна гэж байна шүү дээ зарим газар. Тэгэхээр ажилгүйдэл гэдэг чинь сонин ойлголт болчихоод байгаа юм. Тэгэхээр ерөөсөө таны яамны бодлого л хамгийн чухал байна. Энэ дээр нэг бодол санаагаа хэлж өгөөч.

Б.Заяабал: Бат-Амгалан сайд хариулъя.

Э.Бат-Амгалан: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Тантай яг санал нэг байгаа, энэ хуулийг өргөн барьж байгаа гол агуулга нь өнөөдөр Монгол Улсын хүн амын 50-аас дээш хувь нь газар нутгийнхаа 0.3 хувьд амьдарч байгаа энэ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг багасгах, утаа, хөрсний бохирдлын асуудлыг шийдэх ийм л гол үндсэн зорилготой. Өнгөрсөн 13 жилийн хугацаанд ипотекийн зээлийг нэг талд нь зөвхөн энгийнээр хэлэх юм бол эрэлт талыг дэмжиж явснаар 2013 онд 1 сая 500-аас 600 байсан барилгын метр квадратын үнэлгээ өнөөдөр 4.9 сая шинэ байр, хуучин байр 4.7 сая төгрөг метр квадрат нь буюу 3 дахин ихэссэн байгаа. Тэгээд хотын төвлөрөл ерөөсөө саараагүй. Харин эсрэгээрээ хотын гэр хорооллын утаа, яндангийн асуудал саараагүй байгаа. Ийм тооцоолол байгаа. Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтаар, хуулийн төсөл батлагдсанаар ялангуяа хөдөө аймаг, орон нутаг, сумдын төвүүдээр энэ ипотекийн зээлийн хамгийн бага хүү буюу 6 хувийн хүүг, мөн нийслэл Улаанбаатар хотын захуудаар инженерийн дэд сүлжээнд, дэд бүтцэд хамрагдаж болох энэ боломж, бололцоотой хотын захаар, аймаг, орон нутгийн сумын төвүүдээр 6 хувийн хүүтэй зээлийг олгох, бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа юм. Хотын төвүүдэд

бусад төрлийн бүтээгдэхүүний зээлийг олгохоор 10, 12, 14, 16 гэсэн хувийн хүүнүүдийг олгохоор ийм байгаа.

Ташрамд нэг зүйлийг Их Хурлын гишүүддээ хэлэхэд энэ хууль батлагдсанаар төр зөвхөн дундаж бүлгийн, дундаас доош бүлгийн, зорилтот гэж хэлдэг бүлгийн иргэдэд зориулсан энэ орон сууцад ААН-үүд, компаниуд, худалдан авагч нарт зориулсан нь нэг талдаа эрэлтийг дэмжих ипотекийн зээл, нөгөө талдаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих батлан даалт гаргах зарчмаар энэ бүлэг рүү л түлхүү анхаарлаа хандуулж ажиллах юм. Түүнээс өнөөдөр ажиллаж байгаа барилгын салбарын хувийн хэвшлийн, хувийн ААН-ийн компаниудтай өрсөлдөх ийм асуудал байхгүй. Өнөөдөр ажиллаж байгаа ААН-үүд, компаниуд өнөөдөр ажилладаг зарчмаараа ажиллаад явна. Энэ 2 хууль батлагдсанаараа, хэрвээ энэ хууль батлагдахгүй өнөөдрийн зарчмаараа явах юм бол, саяын өнгөрсөн 13 жилийн хугацаанд бид нар гаргасан алдаагаа засахгүйгээр урагшлах юм бол 2030 он гэхэд метр квадратын үнэлгээ нийслэл Улаанбаатар хотод дунджаар 10 сая төгрөг орчим болох ийм тооцоо, судалгаа байгаа. Энэ тооцоо, судалгааг холбогдох яамдынхан, Эдийн засаг, хөгжлийн яам, манай яам нийлж гаргасан ийм тооцооллууд байгаа.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Мандхай гишүүнээр тасаллаа. Сэддорж гишүүнээр тасаллаа. Мандхай гишүүний микрофон өгье.

М.Мандхай: Энэ түрүүн би сайдыг буруу сонсоогүй бол таны энэ хууль дээр 7.4.4, 7.4.5 дээр нийгмийн орон сууцад хамрагдах иргэний сард төлөх төлбөрийн хэмжээ хөдөлмөрийн доод хэмжээний 25 хувь байна, 7.4.5 нь энэ заасан иргэний сард төлөх төлбөрийн зөрүүг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний жил бүрийн төсөвт тусгана гээд оруулчихсан байгаад байгаа. Тэгээд яг энэ тооцооллоор харахаар энэ маш их хэмжээний төсөв улсын төсөвт зардал болж орох гээд байгаа юм шиг харагдаад байх юм. 1 метр квадрат нь 15840 байх, хэрвээ 30 метр квадрат бол сардаа 475 мянга төлөх ёстой харагдаад байгаа юм. Хэрвээ 25 хувиар төлнө гэж тооцох юм бол 198 мянган төгрөг л төлөхөөр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр зөрүү нь өөрөө 198 мянган төгрөг улсын төсвөөс гарна, сар бүр, 1 хүн дээр. Тэгэхээр энэ зөв үү энэ тооцоолол? Тэгэхээр яг улсын төсөвт, ЗГ-ын харьяа яамны, ЗГ-ын гишүүн нь жил бүрийн төсөвт ойролцоогоор хэдий хэмжээний төсөв яг суух юм бэ гэдгийг та нар тооцохгүй бол энэ огт мөнгө гарахгүй биш байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр анхаармаар юм байна.

Б.Заяабал: Мандхай гишүүн үг хэллээ. Сэддорж гишүүний микрофон өгье.

Р.Сэддорж: Би түрүүнд асуусан асуултынхаа дагуу л үг хэлье. Тэгээд энэ хүүгээр хүүгийн хуваарь яаж байгаа юм байна, тийм үү хөнгөлөлт үзүүлж байгаа юм байна аймаг, бусад хотуудад. Наадах чинь нэг их оновчтой биш, яг квотоор л явах хэрэгтэй, мөнгөн дүнгээрээ л явах хэрэгтэй. Наад хүү чинь тэгж их зөрүү байхгүй дээ. Тийм учраас яг Дархан, Эрдэнэтэд хэдэн хувь нь юм, бусад хотуудад, аймгуудад хэдэн хувь нь юм. Улаанбаатартаа л хамаг юмыг нь шингээгээд байвал тэгээд ингээд төлөвлөж ч чадахгүй байгаа биз дээ? Тийм учраас энийгээ та нэг тодорхой ярилцаач, энэ бодлого чинь хамгийн чухал байна. Энд ажилгүй байгаа хүмүүс ажлын байр руу явахад бэлэн байна, гэр бүлтэйгээ явахад бэлэн байна, яг наад ипотекийн зээл чинь л хэрэгтэй байна гэж хэлье.

Б.Заяабал: Баярлалаа, гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-т заасны дагуу нэгтгэж санал хураалтаа явуулъя.

19.33 цаг

Найм.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал руугаа оръё. Дараагийн асуудал, Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийг, хууль тус бүрээр хэлэлцэх дэгтэй учраас Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаар хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Э.Бат-Амгалан: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд иргэдийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, хот, суурин газрын төлөвлөлтийг боловсронгуй болгох, бүсчилсэн хөгжлийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Орон сууцжуулалтын тухай болон Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай анхдагч хуулийн төслүүдийг боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслүүдийг УИХ дахь намын бүлэг, зөвлөлүүдээр хэлэлцүүлээд байна.

Өнөөдөр Монгол Улсад 1 сая орчим өрх амьдарч байгаагаас 1/3 орчим нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцад, үлдсэн хэсэг нь гэр хороолол болон стандартын шаардлага бүрэн хангаагүй сууцад амьдарч байна. Агаар, хөрсний бохирдлын дийлэнх эх үүсвэр нь эдгээр бүсээс шалтгаалж байгаа нь орон сууцжуулалтын бодлогыг шинэ шатанд гаргах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал ипотекийн зээлийн хөтөлбөрөөр нийт 11 их наяд төгрөгөөс давсан санхүүжилт олгож, 144 мянга гаруй өрхийг орон сууцтай болгоход дэмжлэг үзүүлсэн хэдий ч гэр хорооллын бүсийн хэмжээ дорвитой буураагүй байна. Мөн орон сууцны үнэ жил бүр инфляцын түвшнээс давсан буюу дунджаар 15 орчим хувиар өссөөр байгаа нь орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг нэмэгдүүлж байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 16 орчим мянган орон сууц ашиглалтад орж байгаа ч ипотекийн зээлийн эрэлт үүнээс давж, жил бүр 19 мянга орчим шинэ хүсэлт арилжааны банкнуудад ирж байна. Гэвч дунджаар 9.5 мянган хүсэлтийг шийдвэрлэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 47 гаруй мянган өрхийн хүсэлт хуримтлагдаж, 6.7 их наяд төгрөгийн ийм санхүүжилтийн хэрэгцээ үүсээд байна.

Нөгөө талаас орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, газар хөгжүүлэлтийн инженер, дэд бүтцийн асуудал гол саад болж байна. Дэд бүтэцгүй газарт орон

сууцны төсөл хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг урт хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага бий болсон. Иймээс орон сууцжуулалтын бодлогыг зөвхөн ипотекийн зээлээр хязгаарлах бус газар хөгжүүлэлт, дэд бүтэц, орон сууцны нийлүүлэлт, санхүүжилтийн тогтолцоо, нийгмийн хамгааллын бодлоготой уялдуулан цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн төслүүд батлагдсанаар төрөөс хэт хамааралтай санхүүжилтийн тогтолцоо зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоонд шилжинэ. Орон сууцны зээлийн хүртээмж нэмэгдэнэ, төрийн санхүүгийн ачаалал буурна, хөрөнгийн зах зээл хөгжиж, санхүүжилт нэмэгдэнэ. Төрөөс орон сууцны төслүүдийг бодлогоор дэмжиж, батлан даалт гаргана. Зорилтот бүлгийн иргэдэд зээлийн батлан даалт гаргана. Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулна. Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг уялдуулж, цогцоор нь шийдвэрлэнэ. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, урт хугацааны тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкйг байгуулна. Тус банканд зах зээлээс эх үүсвэр татан төвлөрүүлж, арилжааны банкнуудаар дамжуулан ипотекийн зээлийн санхүүжилтийг тогтвортой хангах бөгөөд төрийн эзэмшлийн хувь хэмжээ 34 хувь хүртэл байна.

Эдгээр хуулийн төслүүд хэрэгжсэнээр орон сууцны нийлүүлэлт нэмэгдэж, санхүүжилтийн хүртээмж сайжирч, гэр хорооллын дахин төлөвлөлт эрчимжихээс гадна урт хугацаанд иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарыг дээшлүүлэх чухал нөхцөл бүрдэх юм. Иймд Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай болон Орон сууцжуулалтын тухай хуулийн анхдагч төслүүдийг УИХ-ын нэгдсэн хуралдаанд хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Б.Заяабал: Бат-Амгалан сайдад баярлалаа. Ажлын хэсэг өмнөх Орон сууцжуулалтын тухай хуулийн төслийн ажлын хэсэг хэвээрээ байгаа гэдгийг хэлье. Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Энхцэцэг гишүүнээр тасаллаа. Баатархүү гишүүнээр тасаллаа, Баатархүү гишүүн. Баатархүү гишүүний микрофон өгье.

Ц.Баатархүү: Би харин нэлээн тодруулах шаардлагатай зүйлүүд гарч байна л даа. Энэ орон сууцны бодлого эдийн засгийн суурь, тэргүүлэх бодлогуудын нэг. Тэгээд энэ банк байгуулах юм уу, орон сууцны НОСК, ТОСК хоёроо нийлүүлсэн ТӨК байгуулж байгаа юм уу, 1 дүгээрт яг засаглалын хэлбэр нь юу юм бэ, сан юм уу, банк юм уу, ТӨК юм уу, Зээлийн батлан даалтын сан өгдөг газар юм уу, эсвэл зээл өгдөг газар юм уу гэдгийг нь 1 дүгээрт ялгаж хэлж өгөөч?

2 дугаарт нь одоо байгаа МИК-ийн тогтолцооноос ялгаа нь юу юм бэ? Энэ Орон сууцны банк буюу корпорацыг байгуулснаар зах зээл дээр орон сууцны үнэ ханш хөөсрөөд нэмэгдэхгүй байх яг баталгаа нь юу юм бэ? Энэ суурь судалгааг хийсэн судалгааны баг, судалгааны дүгнэлт байна уу? Жишээлэх юм бол бид бүхэн ипотекийн зээлийг хямд эх үүсвэртэйгээр МИК-ээр дамжуулж олгож байгаа нь нэг талдаа зөв боловч зээлийн хүүг бууруулах тусам орон сууцны метр квадратын үнэ өссөн байдаг. Эрэлт нэмэгдэхээр үнэ өсдөг. Тэгэхээр эрэлт, нийлүүлэлт, зээлийн хүү, зээлийн хүртээмж, нийлүүлэлт гэдэг энэ алтан гурвалжингаа авч явахгүй бол наад орон сууцны бодлого чинь нэг тал руугаа хазайгаад, хэдэн жилийн дараа хөөс нь хагарахад маш олон Монголын ААН-үүд дампуурдаг. Үүний жишээ АНУ-д үл

хөдлөх хөрөнгийн энэ хөөс хагарч байсан. Тэгэхээр энэ нэг ийм нэг талыг ингэж хэт бодсон, сонгууль дөхсөн үед энэ иргэдийн хамгийн их эрэлт хэрэгцээтэй байдаг зүйлээр хамаагүй бодлогогүй, судалгаагүй шийдвэр гаргах нь эргээд урт хугацаандаа Монголын энэ эдийн засагт сөргөөр нөлөөлдөг учраас энэ дээр нэг тодорхой хариултыг өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт энэ танай энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа тэр суурь судалгааг ер нь ямар багийнхан хийсэн юм бэ гэдгийг ингэж асууж байгаа шүү. Баярлалаа.

Б.Заяабал: Бат-Амгалан сайд хариулъя.

Э.Бат-Амгалан: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Тантай ер нь санал нэг байгаа. Тийм учраас энэ 2 хуулийн төслийг оруулж ирж байгаа юм. Өнгөрсөн хугацаанд, энэ 13 жилийн хугацаанд яг таны хэлснээр энэ ипотекийн зээлийн эх үүсвэрийг бид нар орон сууц худалдан авах хүсэлтэй иргэдэд олгосон. 11 их наяд төгрөгийг 144 мянган өрхөд буюу иргэнд олгосон байгаа. Ингэснээр 2013 онд 1.5 сая байсан орон сууцны метр квадратын үнэлгээ өнөөдөр 13 жилийн дараа, Улаанбаатар хотын хэмжээнд ярьж байгаа юм, дунджаар 1 метр квадрат шинэ орон сууцны үнэ 4.9 сая буюу 3 дахин өсчихсөн байгаа. Өнгөрсөн 13 жилийн хугацааны алдааг дүгнэж үзсэнээр энэ 2 хуулийг оруулж байгаа юм. Бид нар нийлүүлэлт талдаа ерөөсөө зохион байгуулалт хийгээгүй, эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөөгүй, дүрэм журмыг нь зааж өгөөгүйгээс шалтгаалаад саяын алдаа гарсан.

Тэгэхээр та асуусан, энэ чинь банк юм уу, Үндэсний орон сууцны корпорац юм уу гэж. Нэг талдаа эрэлт, нийлүүлэлтийг нь, эрэлтийг нь дэмжих төрөлжсөн банк байгаа. Энэ төрөлжсөн банк арилжааны банкнуудад урт хугацаатай эх үүсвэр олгох, төрийн оролцоотой, төрийн оролцоо нь 34 хүртэл хувь, үлдсэн 66-аас дээш хувийг нь арилжааны банкнууд, хөрөнгө оруулагч нар, гадна, дотнын хөрөнгө оруулагч нар орж хөрөнгийн зах зээл дээрээс хувьцаа эзэмшигч болж ажиллах. Үндсэндээ бизнесийн олон улсад явагдаж байгаа зах зээлийн зөв зарчмаараа явна гэж ингэж харж байгаа юм. Нөгөө талд нь Үндэсний орон сууцны корпорац нь нийлүүлэлт талыг нь дэмжихээр, бидний өнгөрсөн 13 жилийн хугацаанд гаргасан алдаагаа бид нар одоо энэ 2 хуулиараа засах гэж байгаа юм. Тэгснээрээ ядаж инфляцын түвшинд юм уу аль эсвэл энэ барилгын материалын импортлогч орон шүү дээ манайх, барилгын материалын үнийн өсөлтөөс хэт давуулахгүйгээр бид нар энэ орон сууцны метр квадратын үнэ, үнэлгээг барих боломжтой юм гэж харж байгаа юм.

Үндэсний орон сууцны корпорац гэхээр нэг шинэ байгууллага байгуулахгүй. Өнөөдөр зөвхөн нийслэл Улаанбаатар хотод гэхэд Төрийн орон сууцны корпорац, Нийслэлийн орон сууцны корпорац, Улаанбаатар орон сууцны менежмент, Гэр хорооллын бодлого зохицуулалтын газар гээд 4-өөс 5 ижил төстэй ийм байгууллагууд байгаа, 200-аас 300 орчим төрийн албан хаагчид ажиллаж байгаа. Энийг цомхон хүрээнд Үндэсний орон сууцны корпорац болгож татан буулгаж, давхардлыг арилгаж, 1 нэгдсэн цонхоор харж ажиллахын тулд энэ корпорацыг байгуулж байгаа юм. Энэ корпорацын гол хийх юм болохоор зээл өгөөд байхгүй. Батлан даалт гаргах зарчмаар үндэсний ААН, Монгол компаниудыг, Монгол дэд бүтцийн компаниудыг, Монгол барилгын компаниудыг дэмжиж явах батлан даалт гаргах зарчмаар, яг ямар зарчмаар ажиллах гэж байна вэ гэвэл өнөөдөр төрд байгаа төрийн мэдэлд тодорхой хэмжээнд байгаа, нөөц бүрдүүлсэн газрын хөгжүүлэлтүүд

дээрээ бид нар ажиллах боломж, бололцоотой. Энэ газрыг дэд бүтцээр нь тодорхой хэмжээнд хангаж, батлан даалт гаргаж, үндэсний дунд хэмжээний компаниудыг энд дэд бүтцийн ажлыг нь хийлгэх, барилга угсралтын ажлыг хийлгэх ийм л зорилттой. Тэнд нь тодорхой хэмжээний батлан даалт гаргах, нэг үгээр базаж хэлэх юм бол эрэлт, нийлүүлэлтийг хангасан, тэгээд орон сууцны метр квадрат цаашдаа өсөхгүй байх магадлал түрүүн хэлсэн инфляцын түвшинд юм уу, импортын бараа, бүтээгдэхүүний түвшинд барих ийм л бодлоготой 2 хуулийн зохицуулалт орж ирж байгаа.

Б.Заяабал: Баатархүү гишүүн тодруулъя.

Ц.Баатархүү: Энэ Орон сууцны корпорац гэдэг нь барилгаа барьж байгаа талаа менежментийн хувьд дэмжих корпорац юм байна гэж ойлголоо, Орон сууцны банк гэж байгуулах юм байна гэж ойлголоо, зөв үү? 2 институт байгуулагдаад эрэлт, нийлүүлэлтээ ингээд тэнцүүлээд явах юм уу, нэг институт байгуулагдах гээд байгаа юм уу гэдгийг дахиад нэг тодруулж өгөөч гэж хүсэж байна?

2 дугаарт нь нэг ийм моделиуд яваад байна. Сингапурын модель бол нийтийн орон сууц болон орлогод нийцсэн орон сууцаа төр өөрөө менежмент хийгээд барьчихдаг, ингээд шийддэг. Америк маягийн загвар нь хөрөнгийн зах зээлтэйгээ холбоод, хувийн даатгалын компаниуд оролцож ирээд, арилжааны банкнуудын зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбоод явдаг. Энэ моделийг Монголд Монголын ипотекийн корпорац хийчихсэн байгаа гэж би хараад байгаа юм. Тэгэхээр байгаа энэ системээ төр шүүрч аваад.../минут дуусав/

Б.Заяабал: Бат-Амгалан сайд, дараа нь Монголбанк, 3 номер бэлдэж байгаарай.

Э.Бат-Амгалан: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Ер нь Баатархүү гишүүнээ, яг таны хэлж байгаа санаа чинь зөв. Төр нь тодорхой хэмжээнд ороод, оролцохдоо өнөөдөр ажиллаж байгаа барилгын салбарын бусад компаниудын энэ зах зээлтэй давхар өрсөлдөхгүй, зөвхөн зорилтот бүлгийн гэж бидний ярьдаг залуу гэр бүлүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, олон хүүхэдтэй, өрх толгойлсон гэх мэт журмаар тодорхойлсон өрхүүд рүү буюу дунд буюу дундаас бага орлоготой иргэд рүү чиглэсэн энэ орон сууцжуулалтын асуудлыг зохицуулахаар энэ 2 хуулийг оруулж байгаа юм. Монголбанк хариулах уу?

Б.Заяабал: Монголбанк, 3 номер.

Б.Мөнхзул: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Яг одоо явж байгаа систем ерөөсөө өөрчлөгдөхгүй. Яг одоогийн систем ипотекийн 6 хувийн зээлийг эх үүсвэрийг нь Монголбанк өгөөд, арилжааны банкнуудаар дамжуулаад, зээлийг нь үнэт цаасжуулаад, Монголын ипотекийн корпорац үнэт цаасжуулаад гаргасан бондыг нь Төв банк эргэж худалдаж аваад явдаг энэ схем байгаа. Тэгэхээр яг энэ Орон сууцны санхүүжилтийн банк болохоор дунд хугацаанд урт хугацаатай эх үүсвэрийг зах зээл дээрээс төвлөрүүлээд, арилжааны банкнуудад эх үүсвэрийг нь өгөөд, банкнууд яг зээл олгодог схемээр яг зээлээ гаргаад явна. Банкнуудын гаргасан зээлийг МИК үнэт цаасжуулдгаараа үнэт цаасжуулаад явна. Эргээд МИК-ийн гаргасан бондыг буюу үнэт цаасыг нь энэ Орон сууцны санхүүжилтийн банк худалдаад аваад явдаг энэ схем рүү явж байгаа юм. Тэгэхээр Монголын ипотекийн

корпорацийн үйл ажиллагаа илүү өргөжиж тэлнэ гэсэн үг. Монголбанк одоо худалдаж аваад яваад байгаа энэ төсвийн шинж чанартай санхүүжилт гэж яриад байгаа энэ схемээс Төв банк бүрэн гарч байгаа гэсэн үг.

Б.Заяабал: Очирбат гишүүний микрофоныг нээе.

Г.Очирбат: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банктай больё гэж Засгаас орж ирж байгаа юм байна, тэгээд мэдээж шаардлага байгаа гэж харж байгаа. 2, 3-хан тоон мэдээлэл асуух гэсэн юм. Энэ төрөлжсөн банкнаас ойролцоогоор нийт ямар үнийн дүнтэй ер нь үнэт цаас гаргах юм бэ? Тэгээд ЗГ, 34 хувь гээд байгаа юм, ЗГ-ын ногдох нийт үнийн дүн нь урьдчилсан тооцоогоор ер нь хэд орчим гэж тооцож байгаа юм бэ? Дараагийнх нь ЗГ мөн ямар үнийн дүн бүхий үнэт цаас гаргаж Монголбанканд худалдахаар тооцоолж байгаа юм, тэгээд энэ 3 дээр нэг яг тоотой, судалгаатай мэдээлэл авчихъя, тэгэх үү? Тэгээд тодруулъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Мөнхзул: Өргөн барьчхаад байгаа хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар энэ Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ эхний ээлжид 200 тэрбум төгрөг байна. 200 тэрбум төгрөгийг ЗГ бүрдүүлнэ. Яг одоогийн байдлаар 66 орчим хувь дээр нь орох тийм арилжааны банкнууд болон хөрөнгө, үгүй нийтдээ өөрийн хөрөнгө нь 200, энийг эхний ээлжид ЗГ-аас байгуулаад явж байгаа.

Орон сууцны санхүүжилтийн банк нь зах зээл дээр хэдэн хувийн хүүтэй үнэт цаас гаргах юм бэ гэж байгаа юм. Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийг дагаж Хүн амын орлогын албан татварын тухай хууль, ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт орж байгаа, энэ хуулийн төсөл дагаж орж ирж байгаа. Энэ хуулиар Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны зах зээл дээр гаргаж байгаа үнэт цаасыг татвараас чөлөөлж өгч байгаа юм. Тэгэхээр яг одоогийн байдлаар Төв банкны үнэт цаас 12 хувьтай гарч байгаа. Энэ дээр банкнууд худалдаж авахад 25 хувийн татвар төлдөг. Тэгэхээр ЗГ-ын үнэт цаастай ижилхэн болгоод татварын хөнгөлөлт үзүүлчихээр яг одоогийн нөхцөл байдалд бид хэдийн тооцож байгаагаар энэ Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны үнэт цаас 10 орчим хувьтай зах зээл дээр гарах болов уу. Тэгэхдээ энэ маань өөрөө Төв банкны үнэт цаас Төв банкны нөгөө бодлогын хүүтэй уялдаад явна гэсэн үг. Ер нь Төв банкны тухайн үеийн бодлогын хүүгээс нэг ойролцоогоор 2 орчим хувиар бага орчим хүүтэй зах зээл дээр гараад явах болов уу гэсэн тийм тооцоолол байна. Нөгөөх нь өөр ямар тоо байсан билээ.

Гарах үнэт цаасны хэмжээн дээр Төв банк энэ дээр эрэлт, нийлүүлэлт. Энэ хууль дээр эрэлт, нийлүүлэлтийг нь зохицуулж, эрэлт, нийлүүлэлтийнхээ үндсэн дээрээс энэ хэмжээг тогтооно гэсэн байгаад байгаа. Тэгэхээр яг энэ Орон сууцны санхүүжилтийн банк нь өөрөө гаргах үнэт цаасныхаа хэмжээг тухайн үеийнхээ барилгын салбар дээр хүлээгдэж байгаа нийлүүлэлтийн хэмжээ, барилгын зах зээл дээр зарагдаж байгаа орон сууцныхаа тоотой уялдуулаад зээлийнхээ хэмжээг тооцоод явах байх.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Баатархүү гишүүнээр тасаллаа. Баатархүү гишүүний микрофон өгье.

Ц.Баатархүү: Энэ эрсдэлийг нэлээн нэг дор төвлөрүүлж байгаа. Тийм учраас систем өөрөө буруу ажиллавал, системийн нэг хэсэг буруу ажиллавал маш том эдийн засагт савлагаа үүсгэнэ. Энийг энэ эдийн засагчид, яг энэ чиглэлийн судлаачид, зах зээл дээр ажиллаж байгаа, энэ орон сууцны эдийн засгийн чиглэлээр судалгаа хийж байгаа судалгааны институцүүдийг оруулсан уу гэж би асуугаад байгаа, энийг би дахиад тодруулъя. Тэгэхээр нэг зүйлийг анхааруулахад энэ хуулийн үзэл санааг бид нар илүү сайн нягтлах хэрэгтэй, хамгийн зөвөөр нь энэ нийгэмд гаргаж ирэх хэрэгтэй. Дэлхий дээр байгаа орон сууцны бодлого хийдэг 3 том загварыг ингээд Монгол Улс нийлүүлж байна л даа. Монгол Улс их сонин байна шүү дээ. Түгжрэлийг бууруулах бүх төслийг нийлүүлээд 7 төсөлд зүтгүүлж байна. Орон сууцыг бий болгох 3 янзын том классик энэ загварыг нийлүүлээд зүтгүүлж байна л даа. Тэгээд энийг яах вэ би хувь хүнийхээ хувьд дэмжиж байна, тэгэхдээ илүү нягтруулна, энэ маш том эрсдэлтэй. Эргээд энэ эрсдэл нь их томоор улс орны эдийн засагт савлагаа үүсгэнэ.

2 дугаар эрсдэл нь улс төрийн эрсдэлтэй, энэ буруугаар ашиглагдвал улс төрийн эрсдэл үүснэ, улс төржинө, ийм зүйл болно гэдгийг хэлье.

3 дугаарт энэ маш их иргэдийн хүлээлт, давлагаа үүснэ. Тэгээд миний энэ дараалал хэдэд байгаа юм бэ гэдэг нь ил тод биш байвал энэ авлигын уул уурхай болно, дарааллыг зардаг ийм жижиглэнгийн бизнес бий болно. Өнөөдөр газраа өмчилж авъя гэдэг иргэн эзэмших гэрчилгээгээ өмчлөх болгох гээд хүсэлт гаргахад би яг хэдэн хүний дараа юм бэ гэдэг нь Монголд ойлгомжгүй байдаг. Зүгээр цахим цонхоор хүлээгээд авдаг. Тэгэхээр нэг ахмадын орон сууцад оръё гэж байгаа ахмадын өргөдлийг авлаа гэхэд хэдэн хүний дараа, хэзээ шийдэгдэх юм бэ гэдэг нь тодорхой биш байсаар байвал энэ асуудал зүгээр төрийн дунд шатанд маш их тийм дарааллыг зардаг ийм авлигын жижиглэнгийн, дунд гарын ийм бизнесийг цэцэглүүлсэн ийм төсөл болно шүү гэдгийг анхааруулж хэлье. Баярлалаа.

Б.Заяабал: Гишүүддээ баярлалаа. Үг хэлж дууслаа. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-т заасны дагуу саналуудаа нэгтгэн санал хураалтаа дараа явуулъя.

19.54 цаг

Ес.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудал. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Нэгтгэсэн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Болдын Жавхлан танилцуулна.

Гишүүний микрофоныг нээе. Ажлын хэсэгтээ баярлалаа. Санал хураалт үлдсэн учраас ажлын хэсгийн гишүүд явж болно. Жавхлан гишүүний микрофоныг нээе.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 сарын 26-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Ингээд хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт нийт 11 гишүүн ажилласан. Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Болдын Жавхлан миний бие, ажлын хэсгийн гишүүдэд УИХ-ын гишүүд Батбаяр, Батболд, Батнайрамдал, Наранбаатар, Туваан, Ундраа, Уянга, Мөнхсоёл, Үүрийнтуяа, Эрдэнэбүрэн нар ажиллаж байна. Ажлын хэсэг нийт 2 удаа хуралдаж, нэг удаа мэдээлэл сонсож цуглацгаалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэгт УИХ-ын гишүүдээс нийт 50 зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн бөгөөд ажлын хэсэг 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж, дээрх зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, тайлбар сонсож, дэд ажлын хэсгийг ажиллуулж, 41 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж санал хураалгах нь зүйтэй гээд бэлдээд ирлээ. Ажлын хэсэгт танилцуулагдсан УИХ-ын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй 9 саналыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Болдын Жавхлан.

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагч Жавхлан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт оролцохоор хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Пүрэвжавын Баянбаатар Ашигт малтмал, газрын тосны газар /АМГТГ/-ын дарга, Намсрайн Мөнхбилэг ҮГА-ны албаны дарга, Сэр-Одын Ган-Очир АМГТГ-ын Хайгуул, ашиглалтын газрын дарга, Мөнхсайханы Энхтулга АМГТГ-ын Кадастрын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэлэлцүүлгийн явцад 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу тухайн

зүйлтэй холбогдуулан хууль санаачлагч болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой байгаа. Үүнтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгийн оруулж ирсэн танилцуулгатай холбогдуулж, сая Жавхлан сайд уншиж танилцуулсан, тэрэнтэй холбоотой.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол гээд гишүүдэд тараагдсан байгаа. Тэгээд энэнтэй холбоотойгоор ерөнхий байдлаар асуулт асуух гишүүд, ажлын хэсгийн танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье гэж байгаа юм. Очирбат гишүүнээр тасаллаа. Очирбат гишүүний микрофон өгье.

Г.Очирбат: Энэ Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр нөгөө АМНАТ-ийн татвар орж ирсэн, нийгэмд их асуудал үүсгээд байгаа. Өчигдөр Монгол Ардын намын УИХ-ын гишүүн Батнайрамдал гишүүн сошиал хуудсаар ажлын хэсэг бараг хаалттайгаар хуралдаж, тэгээд дээрээс нь энэ Ашигт малтмалын АМНАТ-ийн татварыг зориудаар буулгаж, уул нь МАН-ын бүлэг дээр татварын хэсгийг нь ингээд дараа болъё гээд хойшлуулчихсан байсан юмыг ажлын хэсэг маань авч оруулж ирж, ажлын хэсгийг нь Болдын Жавхлан дарга ахалж, ингээд энэ татварыг буулгах ийм маягтай мэдэгдлийг олон нийтэд хийсэн.

Тэгэхээр энэ дээр Дамдинням сайд, энэ Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хорооны орж ирж байгаа, Дамдинням сайд биш, Болдын Жавхлан сайд юм байна. Ажлын хэсгийн ахлагч болохоор энэ тал дээр ер нь яг ажлын хэсэг дээр юу яригдав? Яг тэр татварыг анх нөгөө Засгаас өргөн барьснаар нь үлдээсэн юм уу? Нэг бол та хэд маань Батнайрамдал гишүүний яриад байгаа шиг татварынхаа татвараа, АМНАТ-ийн татварыг ингээд бууруулах зүйл заалтыг хөндөж оруулж ирж, бууруулахыг нь дэмжиж ажлын хэсэг дээр ингэж орж ирсэн юм уу гэсэн ийм асуултыг асууя? Яагаад гэвэл энэ нийгэмд ийм төөрөгдөл үүсээд байгаа юм. Нэг тал нь болохоор МАН бүлгээрээ энэ хуулийг авч хэлэлцээд тэр татварын хэсгийг нь ингээд үлдээсэн гэж яриад байдаг. Нөгөө талдаа болохоор энэ хуулийн төсөл дээр нэлээн шүүмжлэлтэй хандаж байсан Батнайрамдал гишүүн бол олон нийтэд үгүй ээ, ажлын хэсэг дээр ингээд хуучин Засгаас өргөн барьснаар нь буюу бүлгийнхээ шийдвэрийг өөрчлөөд, хүлээж авахгүй, бүлгийн шийдвэрийг хүлээж авахгүйгээр Засгийн өргөн барьсан тэр чигээр нь ингээд явахаар ийм хандлага, чиг зураг гарч байна гэсэн. Тэгэхээр энэ тал дээр ажлын хэсэг маань ямархуу байр суурийг барьж ажилласан юм бэ? Ингээд асуултдаа хариулт аваад, тодруулъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагч Жавхлан сайд, нэмэлт шаардлагатай бол салбарын сайд хариулъя. Жавхлан сайдын микрофон өгье, гишүүний микрофон өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулт өгье. Ажлын хэсэг ил, далд хуралдана гэдэг тийм дэг байхгүй. Дэгийн хуулиараа зааж өгсөн өрөөнд нь ажлын хэсэг хуралдаад явдаг ийм байгаа. Манай Батнайрамдал гишүүн ажлын хэсэгт өөрөө орчихсон байгаа, гадаад томилолттой явсан байна. Бид явуулаагүй, өөрөө явсан байх. Тэгээд тэнд явж байхдаа сошиал дээр юм тавьсан байна лээ, тэрийгээ өөрөө тайлбарлана биз. Батнайрамдал гишүүн сүүлийн ажлын хэсгийн хурал дээр байгаагүй, ямар ажлын хэсгийн хурлаа хойшлуулалтай нь биш. Гэхдээ

Батнайрамдал гишүүний гаргасан санал дээр гишүүд маш хүндэтгэлтэй хандаж байгаа.

Тийм учраас бүлэг дээр ч гэсэн мөн хойшлуулах, хугацааг нь хойшлуулах хэрэгтэй гэсэн ийм чиглэл өгсөн байгаа. Тийм учраас ажлын хэсэг дээр энэ АМНАТ-ийн шинэ зохицуулалтыг тэр яригдаад байгаа Онтрэ-гийн хэлэлцээрт ямар нэг нөлөөгүйгээр, ямар нэг эрсдэл гарахгүйгээр хугацааг хойшлуулж тавьж ингэж орж ирж байгаа. Тэгэхээр ингээд та тэвчээртэй хүлээвэл хэдхэн минутын дараа энэ зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн уншиж санал хураана. Тэрэн дээр маш ойлгомжтой томъёолоод орж ирнэ. Тэгээд тэр үед нь та дахиад асуусан ч болно, яасан ч болно.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Санал хураалтыг УИХ-ын дэгийн тухай хуулийн 10.12-т заасны дагуу нэгтгэж зохион байгуулъя. Ажлын хэсэг явж байж болно.

20.03 цаг

Байнгын хорооны өмнөх хэлэлцсэн асуудлуудыг Дэгийн тухай хуульд заасны дагуу нэгтгэж санал хураалтыг явуулахаар байгаа. Байнгын хорооны хурлыг 30 минут түр завсарлуулж байна, 30 минутын дараа эргээд хуралдацгаая.

Хуралдаан 20 цаг 03 минутаас 20 цаг 57 минутад завсарлав.

Байнгын хорооныхоо гишүүдийн оройн амгаланг айлтгая. Байнгын хорооныхоо хуралдааныг үргэлжлүүлъя. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэх асуудлуудын санал хураалтыг явуулж эхэлъя.

Эхний асуудал Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалт санал хураалтыг явуулж эхэлъя. Монгол УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Саналын томъёоллыг уншъя.

1.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3 хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4 хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5 хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх, аль байгаа юм. Сая ярьсан шүү дээ. 3, 4, 5 бүгдийг нь уншсан шүү дээ, уншсан.

6 дахь санал, 6 дахь санал хураалт хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Батсүмбэрэл танилцуулах уу? Батсүмбэрэл танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

21.04 цаг

Дараагийн асуудал Төрийн болон орон нутгийн өмчийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг дээр санал хураалт явуулна. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг үндэслэн хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, Байнгын хороонд шилжүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Саналын томьёоллыг уншиж танилцуулж эхэлье. Санал хураалтаа эхэлье.

Төслийн нэрийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй” гэснийг “засаглалыг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Дээрх 1, 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан энэ хууль болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг “засаглалын” гэж тухай бүрд өөрчлөх. Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах “Тайлбар” хэсэг нэмэх:

“Тайлбар: -Энэ хуульд заасан “үр ашигтай байх” гэж арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд оруулсан капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс өндөр түвшинд байхаар үйл ажиллагаа явуулж, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхийг ойлгоно. Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд нийтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, боломжит бага зардлаар үзүүлэхийг ойлгоно.

Тайлбар: -Энэ хуульд заасан “зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх” гэж хуульд зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй, төрийн болон орон нутгийн өмчийг зах зээлийн үнэ, нөхцөлөөс доогуур ашиглахгүй, зөвшөөрөл, эрх олгох болон төрийн худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэхгүй, дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн нийтлэг журмаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдөхгүй байхыг ойлгоно.” гэсэн байна. Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “, хэлбэр” гэснийг хасаж, 6.1.2, 6.2.2 дахь хэсгийн “34-өөс” гэснийг “гуравны нэгээс” гэж тус тус өөрчилж, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны, эсхүл нийтийн үйлчилгээний гэж ангилах бөгөөд энэ талаар тухайн компанийн дүрэмд тусгана.” Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулж болно:

8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, санхүүгийн үр ашиггүй нөхцөлд нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялгийг ашиглах;

8.1.3.зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, харилцаа холбоо, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжих, холбогдох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.5.хуульд тусгайлан заасан бол” гэж. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл. Ногдол ашгийн бодлого

16.1. Төрийн болон орон нутгийн өмчит компани нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан ногдол ашгийн бодлоготой байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ батална.

16.2. Ногдол ашгийн бодлогод тухайн компанийн үйл ажиллагааны зорилго, хөрөнгө оруулалтын бүтэц, мөнгөн урсгалын онцлогоос хамааруулан дараах хэлбэрийн аль нэг, эсхүл хосолсон хэлбэрийг тусгана:

16.2.1. аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах цэвэр ашгийн тодорхой хувиар;

16.2.2. жил бүр хөрөнгө оруулагчид тогтвортой хуваарилахаар урьдчилан тогтоосон ногдол ашгийн зорилтот хэмжээ болон түүнд тооцох өсөлтийн хувиар;

16.2.3. аудитлагдсан санхүүгийн тайланд туссан хувь нийлүүлсэн хөрөнгө, чөлөөт мөнгөн урсгал, хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг, эсхүл хүү, татварын өмнөх ашиг зэрэг санхүүгийн үзүүлэлтээр урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр;

16.2.4. бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалж урьдчилан тооцоолоогүй орлого бий болсон тохиолдолд түүний урьдчилан тогтоосон тодорхой хувиар.

16.3. Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компанийн ногдол ашгийн бодлогод дараах зарчим, шаардлагыг тусгана:

16.3.1. ногдол ашгийг аудитлагдсан санхүүгийн тайланг үндэслэн тогтоох;

16.3.2. компанийн батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.3.3. нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалт, зориулалтын хөрөнгийг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.3.4. компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагааг дордуулахгүй байх;

16.3.5. бусад хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.

16.4.Арилжааны зорилготой төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь ногдол ашгийн бодлогод заасны дагуу ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан компанийн тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээ, ногдол ашиг тооцох хэлбэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилготой компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн хэмжээ, эсхүл энэ хуулийн 16.8-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.7.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.6-д заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.8.Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.5, 16.6-д заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно:

16.8.1.компанийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд цэвэр ашгаас дахин хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага үүссэн;

16.8.2.компанийн ногдол ашгийн бодлогод тусгасны дагуу хуримтлагдсан алдагдлыг нөхөх шаардлага үүссэн;

16.8.3.эрх бүхий байгууллагаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг хангуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах шаардлага үүссэн.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах баримт бичгийг хавсаргана:

16.9.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;

16.9.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;

16.9.3.зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоолол.

16.10.Энэ хуулийн 16.9-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.” Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8.Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.4.Төлөөлөн удирдах зөвлөлгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд түүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хэрэгжүүлнэ.” Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

9.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “авлигын,” гэсний дараа “нийтийн албаны ашиг сонирхлын,” гэж нэмж, 24.1.2 дахь заалтын “тухайн салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд” гэснийг “төрийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд таваас доошгүй, орон нутгийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд хоёроос доошгүй жил” гэж, “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, 24.1.6.а. заалтын “өөрөө” гэснийг “дангаараа” гэж өөрчилж, “дангаараа болон” гэснийг хасах,” санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.4, 24.5, 24.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“24.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь сондгой тооны таваас ес хүртэлх гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн болон орон нутгийн төлөөллийн нэг гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал болгож, томилогдсон этгээд байна.

24.6.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй бол хоёроос, 7 гишүүнтэй бол гурваас, 9 гишүүнтэй бол дөрвөөс доошгүй нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүнийг Компанийн тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.” Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Төслийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “нийтийн зориулалттай дэд бүтэц,” гэснийг хасаж, “таваас илүүгүй сондгой тооны” гэснийг “таван” гэж, “хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны албан хаагч, хоёроос доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байж болно” гэснийг “хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.8.Энэ хуулийн 24.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн төлөөллийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох бөгөөд төрийн захиргааны албан хаагч нэрээ дэвшүүлж, сонгон шалгаруулалтад оролцож болно.” Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

13.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсанаас бусад тохиолдолд оролцож, удирдамж, чиглэл өгөхийг хориглоно:

29.6.1.ногдол ашгийн бодлогыг батлах, хэрэгжүүлэх;

29.6.2.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.” Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

14.Дээрх 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.7, 29.8, 29.9 дэх хэсэг нэмэх:

“29.7.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компанийн ашиг сонирхол, хуульд заасан үүрэг, хариуцлагыг тэргүүн ээлжид баримтлах бөгөөд энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн баримтлах эсэхийг бие даан шийдвэрлэнэ.

29.8.Төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөл нь энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг баримталсан, эсхүл баримтлаагүй нь түүнийг Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөх, үндэслэл болохгүй.

29.9.Энэ хуулийн 29.6-д заасан удирдамж, чиглэлийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч бүртгэж хадгална.” Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

15.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 36.1.2 дахь заалтын “3” гэснийг “хоёр” гэж, 36.1.3 дахь заалтын “өргөдөл” гэснийг “хүсэлт” гэж, 36.1.13 дахь заалтын “3 жил дараалан хангалтгүй” гэснийг “хоёр жил дараалан өөрчлөлттэй” гэж тус тус өөрчилж, 36.1.4 дэх заалтын “ноцтой” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, 36.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.5.Энэ хуулийн 36.1.1-д заасан тохиолдол төрийн болон орон нутгийн өмчит нийтийн үйлчилгээний компани, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон төслийн санхүүжилттэй компанид хамаарахгүй.” Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

16.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа баталгаажуулах, хараат бус мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор санхүүгийн тайлангийн аудит хийлгэнэ.

37.5.Төрийн аудитын байгууллага тайлант жилийн улсын хөгжлийн бодлого, тухайн жилийн санхүүгийн төлөв байдал, урьдчилсан судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж, өмнөх оны гүйцэтгэсэн аудитын дүн, хүний нөөц, төсөв, санхүү бусад хүчин зүйлд үндэслэн санхүүгийн тайлангийн аудит хийх төрийн болон орон нутгийн өмчийн компанийг сонгон гүйцэтгэнэ.

37.6.Төрийн аудитын байгууллагаас энэ хуулийн 37.5-д зааснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдэд тавигдах тусгай шаардлагыг Засгийн газарт хүргүүлнэ.” Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

17.Дээрх 16 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.7, 37.8 дэх хэсэг нэмэх:

“37.7.Энэ хуулийн 37.6-д заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна.

37.8.Энэ хуулийн 7.1-д заасан өмчлөлийн бодлогод нийцүүлэн тухайн жилд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх төрийн өмчит компанийн жагсаалт болон аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

18.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийг хасаж, 41.4 дэх хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “04 дүгээр сарын 15-ны” гэж өөрчлөх. Санал хураалт. 73.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

19.Төслийн 44 дүгээр зүйлийн дугаарыг 43 болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43 дугаар зүйл.Энгийн хувьцаа нэмж гаргах, арилжих

43.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани энэ хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн энгийн хувьцаа нэмж гаргаж, дараах хэлбэрээр үнэт цаасны зах зээлд санал болгож хөрөнгө оруулалт татаж болно:

43.1.1.хуульд заасны дагуу нийтэд санал болгох, эсхүл хаалттай хүрээнд санал болгох;

43.1.2.хуульд заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгүүлэн санал болгох;

43.1.3.хуульд заасан бусад хэлбэрээр дотоодын болон гадаадын үнэт цаасны зах зээлд санал болгох.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

43.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавх, тогтвортой байдлыг дээшлүүлэх;

43.3.2.компанийн засаглал, ил тод байдал, хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах;

43.3.3.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, тэтгэврийн сан болон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх;

43.3.4.газрын хэвлийн баялгийн өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд хүртээмжтэй, ил тод, зах зээлийн зарчмаар хүргэх;

43.3.5.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлэх.

43.5.Энэ хуулийн 43.3.1-43.3.5-д заасан зорилго болон 43.6.2-т заасан зарчмыг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгохдоо хөрөнгө оруулагчийн төрлийг дараах байдлаар дангаар болон хослуулан тогтоож болно:

43.5.1.Монгол Улсын иргэн;

43.5.2.мэргэжлийн хөрөнгө оруулагч;

43.5.3.стратегийн хөрөнгө оруулагч;

43.5.4.бусад хөрөнгө оруулагч.

43.6.Энэ хуулийн 43.4-д заасны дагуу хөрөнгө оруулагчдын төрөл, захиалгын доод болон дээд хэмжээ, хуваарилалтын аргачлал, төвлөрлөөс сэргийлэх арга хэмжээ болон шаардлагатай тохиолдолд нэг этгээдийн эзэмших дээд хэмжээг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд мэргэжлийн оролцогчдын санал, дүгнэлтийг үндэслэн Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

43.7.Төрийн өмчит компанийн энгийн хувьцааг нийтэд санал болгоход дараах зарчмыг баримтална:

43.7.1.шударга, ил тод оролцох боломж олгох;

43.7.2.дангаар болон холбогдох этгээдэд хувьцаа эзэмшлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх;

43.7.3.хувьцааны үнэ, үнэлгээ, эрсдэл, ногдол ашиг, саналын эрх, хязгаарлалт, захиалгын нөхцөлийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх;

43.7.4.захиалга давсан тохиолдолд хувьцааг урьдчилан зарласан журмын дагуу хуваарилах;

43.7.5.Монгол Улсын иргэний хувьцааг богино хугацаанд төвлөрүүлэн худалдан авах, дамжуулан худалдах, зах зээлийг урвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэх зохицуулалт тогтоох;

43.7.6.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан бусад энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хуульд өөрөөр заагаагүй бол хангах.

43.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг дараах хэлбэрээр арилжиж, худалдаж болно:

43.8.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд төрийн болон орон нутгийн эзэмшлийн энгийн хувьцааг хоёрдогч зах зээл дээр арилжих;

43.8.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт, хэлэлцээрийн аргаар стратегийн хөрөнгө оруулагчид худалдах;

43.8.3.өөр төрлийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр солих;

43.8.4.хуульд заасан бусад.

43.9.Энэ хуулийн 43.8-д заасны дагуу төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг арилжих, худалдах шийдвэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хувьцаа эзэмшигчийн хувиар гаргана.

43.10.Энэ хуулийн 8.1.2-т заасан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, арилжих шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

43.11.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ур чадвартай ажилтныг тогтвортой ажиллуулах, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн ажилтнуудад опцион эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж болно.

43.12.Энэ хуулийн 43.10-д заасан хөтөлбөрийн нөхцөл, эзэмшлийн дээд хэмжээ, шилжүүлэх хязгаарлалт, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн саналын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал Засгийн

газрын зөвшөөрлийг үндэслэн батална.” Санал хураалт. 73,9 хувийн уг санал дэмжигдлээ.

20.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3, 51.4, 51.5 дахь хэсэг нэмэх:

“51.3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг энэ хуулийн 8.3-т заасан үндэслэлд нийцүүлэх арга хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

51.4.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг 2028 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

51.5.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 8.3-т заасан зөвшөөрөл хамаарахгүй.” Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2 дахь бүлэг санал санал, хураалгах санал буюу Байнгын хорооны ирцэд орсон гишүүний 2/3-оор уг саналууд дэмжигдэнэ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:

1.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагааны зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.” Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг хасах. Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийг хасах. Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.4.Компанийн гүйцэтгэх удирдлагыг хуульд заасан шаардлагыг хангасан хараат бус, мэргэжлийн багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 37.6 дахь хэсгийг өөрчлөн найруулах санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед дэмжигдсэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах саналыг хүчингүй болгох. Санал хураалт. 78.3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэнтэй холбоотойгоор хэлэлцэх асуудалд тусгагдсан тов дараалалд тусгагдсан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх шаардлагагүй болж байгаа юм.

21.34 цаг

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудтай холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гишүүдээс санал гаргаагүй байна. Ингээд хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсгийг үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна.

Горимын санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Саналын томьёоллыг уншъя. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсгийг үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа уншиж танилцуулна.

21.36 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Саналын томьёоллыг уншъя.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2 хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3 хамт өргөн мэдүүлсэн Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4 хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5 хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6 хамт өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Тийм байна. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт нэг орхигдсон байна. 5 дахь санал хураалт хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7 хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8 хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Баатархүү гишүүн танилцуулах уу? Золжаргал гишүүн танилцуулъя. Золжаргал гишүүн танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудал. Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулж эхэлье.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Саналын томъёоллыг уншъя. Орчихсон уу? Уянгахишиг гишүүн.

Саналын томъёолол. Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2 хамт өргөн мэдүүлсэн Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3 хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4 хамт өргөн мэдүүлсэн Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5 хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6 хамт өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн хэн танилцуулах вэ? Очирбат гишүүн танилцуулах уу, хэнээр танилцуулах вэ? Золжаргал гишүүнээр, тэгье Уянга гишүүн, Уянга гишүүн танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Уянга.

Дараагийн асуудалдаа оръё. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан. Ингээд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэлэлцүүлгийн явцад 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагч болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой юм байна. Ингээд ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Ажлын хэсгийн оруулж ирсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж эхэлнэ.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.40 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.40.“гэрээ байгуулах боломжтой талбай” гэж энэ хуулийн 4.1.39-д заасан гэрээг байгуулах боломжтой тусгай зөвшөөрөл олгогдоогүй, ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаагүй, сонгон шалгаруулалтын талбайд хамрагдаагүй, эсхүл сонгон шалгаруулалтыг хоёр удаа зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй, геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэхээр тогтоосон талбайг;” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жавхлан, Батбаяр, Батболд, Батнайрамдал, Наранбаатар, Туваан, Ундраа, Уянга, Мөнхсоёл, Үүрийнтуяа, Эрдэнэбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. 73.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.39 дэх заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 3 дахь заалтын 15^{1.1} дэх хэсгийн, 15^{1.7.5} дахь заалтын “геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Үндэсний геологийн албанд” гэж, 15^{1.3} дахь хэсэг, 15^{1.4} дэх хэсэг, 15^{1.8} дахь хэсэг, 15^{1.9} дэх хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “Үндэсний геологийн албатай” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.2.4} дэх заалтын “чадавхыг тусгасан” гэсний дараа “геологийн суурь судалгаа, эрлийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.7.6} дахь заалт, 15^{1.7.7} дахь заалт, 20.5.7 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15^{1.9} дэх хэсгийн “15^{1.1}-д” гэснийг “4.1.40-д” гэж, “мэдээлнэ” гэснийг “мэдээлж байна” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19^{1.2.1} дэх заалтын “гэрээний хэрэгжилтийн тайлан” гэснийг “гэрээ дүгнэсэн акт” гэж, 19^{1.2.3} дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл авах” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19^{1.8} дахь хэсгийн “зөвшөөрөл олгосон” гэсний дараах “даруйд энэ” гэснийг хасаж, “нийтэд ил тод” гэсний дараах “мэдээлнэ” гэснийг “, нээлттэй мэдээлж байна.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 27.1.15 дахь заалтын “ирүүлэх” гэснийг “хүргүүлэх” гэж өөрчилж, 27.1.16 дахь заалтын “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Зэрэгцүүлж санал хураалгах 1 санал байгаа юм байна. МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-д төслийн зүйл, заалт, зүйл, хэсэг заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжээгүйд тооцож тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэж заасныг үндэслээд ажлын хэсгийн боловсруулсан 9 дэх саналыг Наранбаатар гишүүний саналтай хамт танилцуулж санал хураалгая.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 28¹, 29¹ дүгээр зүйлийн гарчгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 28^{3.4} дэх хэсгийн “28^{3.4}” гэснийг “28^{3.3}” гэж, 29^{1.1} дэх хэсгийн “хаягдал чулуулгийн” гэснийг “хаягдлын” гэж тус тус өөрчилж, 28^{1.1} дэх хэсгийн “зөвшөөрөлтэй” гэсний дараа “хуулийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дараагийн нөгөө санал нь Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын “ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ” буюу “АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТ” бүлгийг хасах. Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар гэсэн ийм санал байгаа юм. Эхний уншсан 9 дэх саналын томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя ажлын хэсгийн саналыг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

10 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 42^{1.1} дэх хэсгийн “олон нийтэд” гэснийг “олон нийт, орон нутгийн иргэдэд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.20 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.20.Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах эрдэс, элементээс бусад эрдэс, элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахгүй бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах эрдэс, элементийн төрөл, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дахь заалтын 64^{1.1} дэх хэсгийн “саад учруулахыг” гэсний өмнө “хууль бусаар” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.2 дахь хэсгийн “19^{1.5}-д заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн” гэснийг “19^{1.4}-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан талбайн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийн 2 дахь баганын “Ашигт малтмалын нэр төрөл” гэснийг “Бүтээгдэхүүний нэр төрөл” гэж, 5 дахь баганын “ам.доллар” гэснийг “ам.доллороор” гэж, 6 дахь баганын “Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь” гэснийг “Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

15.Төслийн 4 дүгээр зүйлийн “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “байгаль орчны менежментийн” гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.32.“чухал ашигт малтмал” гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт явчихсан байгаа. Жаргалан гишүүн горимын санал.

Б.Жаргалан: Энэ 16 дугаар зарчмын зөрүүтэй санал дээр ажлын хэсгээс тайлбар хүсэлтэй байгаа тул саяын санал хураалтыг цуцалж өгнө үү. Тайлбар дээрээ болохоор 4.1.32-т чухал ашигт малтмал гэдэг ойлголтоо томъёолсон байгаа. Тэгээд анх төсөл дээр орж ирсэн нь болохлоор олон улсын өндөр технологид ашиглагддаг эрэлт хэрэгцээ өндөртэй, эдийн засгийн ач холбогдол бүхий ашигт малтмалыг гэсэн байсныг Ажлын хэсгээс оруулж ирсэн санал нь болохлоор чухал ашигт малтмал гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл гэххээд дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг гээд ер нь нөгөө олон улсын тэр нэг ойлголтыг нь нэлээн эвдээд, дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмал юу ч байж болохоор л уншигдаад байна л даа. Тэгэхээр энэ ажлын хэсгээс тайлбар авахыг хүсэж байна.

Б.Заяабал: Жаргалан гишүүний микрофон өгье.

Б.Жаргалан: 16 дугаар зарчмын зөрүүтэй санал дээр энэ техникийн саатлаас болоод санал өгч амжаагүй учраас санал хураалтыг цуцалж өгөхийг хүсье.

Б.Заяабал: Жаргалан гишүүний гаргасан горимын саналаар уг саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал хураалт хүчингүй боллоо. Ингээд 16 дугаар зүйлтэй холбоотой нэмэлт тайлбарыг ажлын хэсгээс өгье. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон өгье.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Уул уурхайн бодлогын газар Намчинсүрэн. Жаргалан гишүүний асуулт нэмэлт тайлбар өгье. Бид нарын зүгээс ЗГ-аас өргөн барихдаа өөр томъёололтой орж ирсэн. Ажлын хэсэг дээр Батбаяр гишүүнээс чухал ашигт малтмал гэж олон улсын зах зээл өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах шаардлагатай ашигт малтмалыг гэж томъёолсон байгаа. Бид нарын зүгээс ЗГ-аас өргөн барихдаа эдийн засгийн ач холбогдолтой гэдэг давхар томъёолол нэмж явж байсан тэр хэсэг нь хасагдчихаад байгаа юм. Зүгээр бид нарын зүгээс чухал ашигт малтмал гэж олон улсын зах зээлд эрэлт хэрэгцээ өндөртэй, эдийн засгийн ач холбогдол бүхий өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өргөн хэрэглэгддэг, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад зайлшгүй шаардлагатай ашигт малтмалыг гэж найруулгын тийм санал оруулчихвал зүгээр юм болов уу гэсэн бодолтой байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гишүүн Уянга гишүүнд нэмэлт тайлбар өгье, саналаа тайлбарлая, микрофоныг өгье.

Б.Уянга: Ажлын хэсэг дээр яг энэ чухал ашигт малтмалын тодорхойлолтыг хэлэлцэж байх үед ажлын хэсгийн гишүүнээс гарсан санал байгаа. Тэгээд дэмжсэн, олонхоороо дэмжсэн шалтгаан нь үйлдвэрлэгч орнууд ихэвчлэн чухал ашигт малтмалаа тодорхойлдгийг Жаргалан гишүүн сайн мэдэж байгаа. Тэгээд тэр хүрээндээ ажлын хэсгийн гишүүний гаргасан санал нь ирээдүйд Монгол Улсад үйлдвэрлэл хөгжинө, тэндээ дотоодынхоо эх үүсвэрийг хангадаг байя, тасалддаггүй байя гэдгээр тайлбарлаад л оруулж ирэхээр нь дэмжсэн байгаа юм. Тэгээд бүгдээрээ гүйцээн боловсруулах аваад янзалж болж байна, эсвэл унагааж болж байна.

Б.Заяабал: 16 дугаар санал дээр санал хураалтыг явуулъя. Томъёоллыг дахиж уншъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.32. “чухал ашигт малтмал” гэж олон улсын зах зээлд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд, эсхүл дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр хангахад шаардлагатай ашигт малтмалыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.38 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

18.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.43 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

19.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч” гэж, мөн хэсгийн “гаргаж болно” гэснийг “гаргана” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

20.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.9.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нь 25-3000 гектар бол 20000 нэгж, 3000 гектараас дээш бол 20000 нэгж дээр нэг гектар тутамд 7 нэгж нэмж тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

21.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 29¹ дүгээр зүйл, 29² дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

22.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

23.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 32.1 дэх хэсгийн “35 нэгж” гэсний дараа “, 6-9 дэх жилд 50 нэгж” гэж нэмэх, 5 дахь заалтын 33.1.5 дахь заалтын “6 дахь жилд” гэснийг “7-9 дэх жилд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

24 дүгээр санал зэрэгцүүлж хураалгах саналтай. Санал орсон байгаа юм байна. Ингээд 24 дүгээр зүйл. Одоо шууд 25 руу орох юм байна. МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20-т төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэж заасныг үндэслээд ажлын хэсгийн 25 дахь саналыг Бадамсүрэн, Наранбаатар, Батболд нарын гишүүний саналтай хамт танилцуулж, хураалгая.

25.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны

байгууллагатай гэрээ байгуулж ажиллаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал бол яг энэ ажлын хэсгийн уншсан саналаар эхэлж санал хураалгах юм байна. Гэхдээ адил санал гаргасан гишүүдийн саналыг мөн унших дэгтэй учраас бусад саналуудыг уншъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар орон нутагтай хамтран ажиллах гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нарын нэгдсэн шийдвэрт үндэслэсэн саналаар байгуулж ажиллана.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бадамсүрэн.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, уг гэрээг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.” Санал гаргасан УИХ-ын Наранбаатар.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 42.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Батболд гэсэн ийм санал байна. Гишүүд санал гаргасан саналынхаа талаар тайлбар өгөх дэгтэй. Энэ дэгийн дагуу санал гаргасан УИХ-ын гишүүн Бадамсүрэнд микрофон өгье.

М.Бадамсүрэн: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ, энэ санал их чухал санал юм. Ер нь орон нутгийг дэмжих хамтран ажиллах чиглэлээр ер нь үг болгоны ард үр дагавар гарна. Тийм учраас 1 дүгээрт миний хувьд энэ сумын гэж томъёолж өгсөн тэгээд энд сум гээд хураалгачихсан байна лээ. Тэгэхээр энэ хооронд ялгаа гарна гэсэн үг. Өөрөөр хэлбэл аймаг сумын гээд таслал, нийслэл дүүргийн гэж ингэж зааглаж өгч байгаа. Өөрөөр хэлбэл аймаг сум нь нэг, нийслэл дүүрэг нь тусдаа гэдэг санаа. Тэгэхээр энэ дээр ийм санал хураалгахад гишүүний гаргасан саналын “ын” гэдэг үгийг өөрчилснөөр энд үр дагавар гарч байгаа, өөрөөр хэлбэл энэ нь асуудалтай болно гэсэн үг. Хэрвээ би асуудал тавивал 1.

2 дугаарт нь ингээд Батболд гишүүн, Наранбаатар гишүүн 3 гишүүн энэ дээр санал гаргасан. Бид 3 арай өөр, өөр томъёоллоор гаргасан байна лээ. Гэхдээ ерөнхий санаа нэг байгаа бид нарынх. Тэгэхээр энэ юу харуулж байна гэхээр энэ заалт өөрөө их чухал заалт шүү гэж байгаа юм. Жишээлбэл Өмнөговийн Засаг даргаар Наранбаатар гишүүн ажиллаж байсан, хамгийн том уул уурхайтай, миний хувьд Дорнод аймаг уул уурхай газрын тостой. Тэгээд практик дээр энэний үр дагавар яаж гарах вэ гэдгийг тооцчихсон учраас энэ дээр санал гаргасан гэдгийг та бүхэндээ тайлбарлаж хэлье.

Дараагийнх нь энэ хуулийн бусад заалттай зөрчилдөнө. Яг энийг одоо ингээд ажлын хэсгийн саналаар явах юм бол. Яагаад гэвэл гэрээ байгуулж ажиллаж болно

гэж байгаа юм. Өмнө хууль дээр гэрээ байгуулж ажиллана гээд заачихсан байгаа. Хэрвээ болно гэдгээр явчихвал нөгөө би яг заалтыг нь мэдэхгүй байна, манай яамныхан мэдэж байгаа. Уулын ажлын төлөвлөгөөг УУЯ, Ашигт малтмалын газар батлахдаа бүрэлдэхүүн болдог 10 хэдэн бүрдлийнх нь нэгэнд нь орон нутагтай хамтран ажиллах гэрээ ордог байхгүй юу. Энэ гэрээ байхгүй бол уулын ажлын төлөвлөгөө батлагддаггүй УУЯ мэдэж байгаа. Тэгэхээр тийм учраас нөгөө энийг болно гээд үүрэгжүүлэхгүй орхичихоор нөгөө хуулийнхаа гол заалттай ингээд зөрчилдчихөж байгаа юм. Тийм учраас энэ заавал ажиллана гэдгээр үүрэг болгож тусгай зөвшөөрөл эзэмшигчид өгч байгаа заалт байхгүй юу. Тэгтэл болно гэнгүүт ингээд байгуулахгүй ч байж болох юм шиг болчихоод, тэгэхээр нөгөө уулын ажлын төлөвлөгөө чинь тэндээ байж байгаа угаасаа батлагдахгүй.

Би энэний хоорондын уялдаа нюансыг нь маш сайн мэдэж байгаа учраас хэлж байгаа юм. Түүнээс энийг ерөөсөө энэ Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулахыг эсэргүүцээгүй. Харин энэний үр дагавар нь өөрөө цаашаа зөв явж, орон нутгийн хөгжлийг дэмждэг байгаасай гэсэндээ л ажил хэрэгчээр энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргасан гэдгийг та бүхэндээ хэлье. Тэгэхгүй бол энэ нөгөө зөвхөн ингээд нутгийн захиргааны байгууллага гэж өмнө байсан юм. Энийг хуулиар аймгийн тамгын газар, сумын Засаг дарга, Тамгын газрыг нутгийн захиргааны байгууллага гэнэ гээд заачихсан. Өмнө практик дээр аймаг, сум хоёулаа байгуулж явдаг байсан. Одоо зөвхөн сум гээд заачихаар энэ өөрөө аймгийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй болоод энэ төслийн хувьд хүндрэлтэй асуудал гарна практик дээр. Тийм учраас ингээд аймаг, сумын Засаг даргын нэгдсэн шийдвэрт хүрсэн саналаар байгуулна гэдэг нь аймаг, сумын Засаг дарга хамтарч гэрээний нэг талд саналаа боловсруулж гарын үсэг зурна гэсэн үг. Ингэвэл энэ төсөл тогтвортой үйл ажиллагаа явуулж чадна. Үгүй бол ингээд эсвэл сумын дарга нь байгуулаад, эсвэл аймгийн дарга нь дангаараа байгуулаад, эсвэл 2 тусдаа ингээд 3 гэрээ байгуулаад ингээд энэ нэг л болохгүй болно доо. Тэгээд манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан практик дээр ямар асуудал гарч байгааг мэдэж байгаа учраас тэн дээрээ бид нарын Наранбаатар гишүүн, Батболд гишүүн бид нарын дэвшүүлээд байгаа санал ер нь зөв үү, буруу юу гэдгийг мэргэжлийн үүднээс тайлбарлах хэрвээ дэгд байдаг боломжтой байх гэж бодож байна. Байдаггүй бол энэ дээр та бүхэн анхаарч өгөөч. Энэ их тийм үр дагавартай шүү.

Хуулийн бусад заалттай зөрчилд нь 1, 2 дугаарт миний гаргасан саналыг сумын гэдгийн “ын” гэдгийг нь орхиод хураалгасан байна. 3 дугаарт нь 3 гишүүн яг адилхан төстэй санал гаргасан. 4-д нь аймаг, сумын Засаг дарга хамтарч саналаа нийлээд нэгдээд гэрээний нэг талд гарын үсгээ зурвал орон нутгийг төлөөлөөд нутгийн захиргааны байгууллагуудын хувьд хамгийн зөв байдаг юм гэдгийг практик дээрээс хэлж байгаа. Та бүхэн тэгээд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын гэсэн энэ нээлттэй сайт дээр байгаа гэрээнүүдийг ажлын хэсэг үзэж болно. Тэгээд аль нь илүү оновчтой байна гэдгийг. Баярлалаа, дэмжиж бүхий та бүхнээсээ хүсье.

Б.Заяабал: Ажлын хэсгийн ахлагч ажлын хэсгийн гаргасан саналтай холбоотой нэмэлт тайлбар өгч болно. Жавхлан ажлын хэсгийн ахлагч гишүүний микрофон нээе.

Б.Жавхлан: Гишүүдээ, энд ийм юм болсон юм. Хэд хэдэн гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргасан, ихэнх гишүүдийг ажлын хэсэг дээр ирж яг энэ тайлбарыг

биеэр ирж хийгээгүй. Тийм учраас ажлын хэсгийн гишүүд бид өөрсдийнхөөрөө уншиж тайлж ойлгосон байгаа юм. Тэгэхээр энэ заалт өөрөө хөндөгдсөн яамнаас хөндөж орж ирсэн учраас ийм санал гаргах боломж гарч ирж байна гэсэн үг шүү дээ. Тэгээд бид нарын ойлгосноор энэ ингээд аймгийн дарга, сумын дарга нар ч ингээд бүгдээрээ орж ирээд, тус бүрд нь ингээд нөгөө том үндэсний компаниуд нөгөө том компаниуд орж ирнэ шүү дээ энэ чинь. Рио Тинтотой Засаг дарга сумын дарга очиж л хэлэлцээрт орох гээд байна шүү дээ. Ингээд яатал ялих ялихгүй юмнаас томоохон төслүүд маань өөрөөр хэлбэл саатал үүсэх, ингээд эвгүйгээр хэлбэл янз янзын л юм болно шүү дээ. Тийм учраас яах юм бэ, одоо ингээд юмыг нь чөлөөлье, дэмжье, ямар нэг шат дараа хүнд сурталгүй явъя, явуулъя гэдэг ийм үүднээс ингэж ойлгоод ингээд дэмжээгүй.

Ингээд 3 гишүүнийхийг Бадамсүрэн гишүүн, Наранбаатар гишүүн, Батболд гишүүнийх үндсэндээ яг нэг ийм ойлголтоор аль алийг нь дэмжээгүй. Ингээд нөгөө суурь санал нь ингээд ажлын хэсгийн саналаар үлдэж байгаа гэсэн үг. Ийм л байдалтай ийм л зүйл болсон. Тийм тэгээд сая өөрийнхөө зарчмын зөрүүтэй саналыг гишүүн маань өөрөө тайлбарлах шиг боллоо. Тэгээд гишүүд санал хураагаад шийднэ биз дээ.

Б.Заяабал: Батболд гишүүний микрофон өгье, өөрийн гаргасан саналаар санал гаргах эрхтэй. Батболд гишүүний микрофон өгье.

Р.Батболд: Яах вэ ер нь энэ 7 дахь заалтын 42.1-ийг хасчихъя гэсэн санал гаргасан юм. Тэгээд энийг хасчихаар угаасаа нөгөө хууль дээр байгаа заалт нь тэр чигээрээ үлдээд ингээд явчих гээд байсан юм. Тэгэхээр нь хасахаа ер нь санал хураалгасан. Тэгэхдээ дэмжигдээгүй. Ер нь юу гэж заасан байгаа вэ гэхээр 42.1 дээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана гэхчхэн байсан юм. Энийг бид харин ажлын хэсэг дээрээ зөөллөсөн, ажиллаж болно гэж байгаа юм. Тэгэхээр бид хууль дээр одоо тэртээ тэргүй мөрдөгдөж байгаа тэр хууль дээрээ ажиллана гээд заачихсан учраас одоо тэрэнтэй чинь холбоотой асуудлууд зөндөө байна шүү дээ. Энэ уул уурхайн шантааж нь дийлддэггүй, байнгын хаана гэрээ хийсэн газар байна тэр нь байнга дуудаж байдаг, үйл ажиллагаа нь явуулаагүй байгаа уурхайнуудын захирлууд хүртэл зарим нь үгээ хэлчихсэн явж байгаа шүү дээ. Би ингээд үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаад байдаг. Аймаг дээрээс юм уу, суман дээрээс дуудаад ингээд хандив өг гээд байх юм. Тийм ч наадам боллоо ийм ч юм боллоо гээд ингээд яваад байдаг. Энэ чинь аягүй их дарамттай байна гэдэг юм яриад байгаа.

Тийм учраас бид энэ уул уурхайн энэ шантаажийг ер нь багасгасан нь дээр. Түрүүн ажлын хэсгийн дарга ярьж байна л даа. Рио Тинтотой жишээлбэл сум нь юм уу гэрээ хийх болох ч юм уу ийм юмнууд яригдаад байгаа юм. Гэтэл бид тэр томуудаа хараад байгаа болохоос жижиг ААН-үүдээ ерөөсөө харахгүй байгаа юм. Жижиг ААН-үүд дээр чинь энэ чинь бүр маш их дарамттай байдаг асуудал тийм, тийм. Тэгэхээр зөөллөөд ажиллаж болно л гэж байгаа юм. Тэгэхээр яах вэ тэр юугаа хасъя гэдгээ татаад байдаг юм уу, одоо татна ч гэж байхгүй байх уншихсан юм чинь. Ажлын хэсгийнхээ саналыг дэмжээд явъя л гэсэн байр суурьтай байгаа юм.

Б.Заяабал: Батболд гишүүн гаргасан саналаа татаж авч, ажлын хэсгийн саналыг дэмжихээр болж байна. Батболд гишүүн саналаа татсантай холбоотойгоор УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 39.20-д заасны дагуу эхлээд ажлын хэсгийн саналаар санал хураалгана. Дараа нь хамгийн эхэнд ирүүлсэн саналын томьёоллоо хамгийн эхэнд ирүүлсэн гишүүний саналаар эхэлж санал хураалгах юм байна. Ингээд ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,2 хувийн саналаар ажлын хэсгийн санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн санал дэмжигдсэн учраас бусад гишүүний гаргасан саналаар санал хураалт Дэгийн тухай хуулийн дагуу явуулахгүй юм байна.

26.Төслийн 4 дүгээр зүйлээс “4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний,” гэснийг “засагт нөлөөлөхүйц,” гэж” гэснийг хасаж, төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

4.1.12.“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

27.Төслийн 4 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.29” гэснийг “11.1.28” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

28.Төслийн 4 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “1 удаа” гэснийг “2 удаа” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

29.Төслийн 6 дугаар зүйлээс “15 дугаар зүйл,” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн “16 дугаар” гэсний өмнө “15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “мэдэгдэж бүртгүүлнэ” гэснийг “мэдэгдэнэ” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

30.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг хууль зүйн техникт нийцүүлж, өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.1/Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 19¹.4 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “нь” гэж нэмэх.

1.2/Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15¹.3.2 дахь заалтын “талаар” гэснийг “тухай” гэж, 15¹.7 дахь хэсгийн “ажил” гэснийг “ажлыг” гэж, 10 дахь заалтын 29².1.2 дахь заалтын “талаар санал дүгнэлт” гэснийг “тухай санал, дүгнэлт” гэж, 12 дахь заалтын 35.13 дахь хэсгийн “байгууллагуудын” гэснийг “байгууллагын” гэж, 13

дахь заалтын 42¹.2.2 дахь заалтын “байгууллагуудтай” гэснийг “байгууллагатай” гэж, 2, 4 дүгээр зүйлийн “16 дугаар зүйл” гэснийг “16 дугаар зүйлийн гарчгийн” гэж тус тус өөрчлөх.

1.3/Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 48.15 дахь хэсгээс “тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

УИХ-ын гишүүдээс гаргасан саналын томъёоллоор санал хураалтаа явуулж эхэлье. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 32.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэнгүүн. Цэнгүүн гишүүн гаргасан саналтайгаа холбоотой тайлбар хэлнэ, Цэнгүүн гишүүний микрофон өгье.

С.Цэнгүүн: Оройн мэнд хүргэе. Энэ 32.5 дахь заалт маань болохоор ийм заалт байгаа. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг ҮСХ-ноос зарласан хэрэглээний үнийн индексийг өмнөх жилийн өсөлтийн хувиар индексжүүлэн тооцно гээд ингэсэн байгаад байгаа юм. Тэгээд энэ маань болохоороо инфляцтай уялдуулах гэсэн үндсэн санаа байгаа юм байна гэж ойлгоод байгаа. Гэтэл ерөнхийдөө уул уурхайн салбарт чинь урт хугацааны хөрөнгө оруулагчид орж ирэх гэж байгаа юм. Тэгж байхад бид бүхэн маань нөгөө инфляцтайгаа хэрэглээний үнийн индекстэй ингээд нэмээд тэгж нөгөө дүнгээ тооцно гэхээр энэ чинь өөрөө тооцоолох боломжгүй байдал үүсгээд байгаа юм. Тэгэхээр нөгөө хөрөнгө оруулалтын орчин дээр чинь энэ чинь өөрөө урьдчилан тооцоолох боломжгүй байдал үүсгэх нь зохимжгүй юм уу гэдэг үндэслэлээр энэ заалтыг хасаад, тэгээд өөрсдөө зүгээр яг жишиг үнээ тогтоогоод тогтоогоод явах нь хөрөнгө оруулагч талаасаа бодитой тодорхой заалт болох юм болов уу гэж харж байна.

Б.Заяабал: Ажлын хэсгийн дарга мөн тайлбар хэлнэ саналтай холбоотой. Жавхлан гишүүний микрофон өгье.

Б.Жавхлан: Юунаас яамнаас тайлбар хэлээрэй. Тэгэхдээ энд зүгээр нэг ийм юмнууд байгаа юм шүү, энэ ингээд санал гаргасан УИХ-ын гишүүн гээд нэрснүүдийг нь тавьчихсан зарим нь шууд ажлын хэсэг гээд тавьчихсан байгаа. Ялгаа нь ийм байгаад байгаа. Ер нь ихэнх нь тийм, гишүүдийн гаргасан саналыг ажлын хэсэг дээр санал хураагаад хэрвээ дэмжсэн бол цаашаагаа ажлын хэсэг гэж явж байгаа, дэмжигдээгүй ажлын хэсэгт дэмжигдээгүй санал гаргасан гишүүнийхээ нэрээр бичигдээд ингээд явж байгаа. Нэг ийм дэгтэй болчихсон юм байна лээ. Тэгээд үндсэндээ бараг цаашдаа гишүүд анхаарна биз. Ажлын хэсэг бараг илүү болж байгаа байхгүй юу. Ажлын хэсгийн дэмжсэн санал, дэмжээгүй гэж хуучин уншдаг байсан бол тэр нь байхгүй болчихсон. Одоо зүгээр дэмжсэн бол ажлын хэсэг гэж л доор нь нэрээ бичүүлэхийн тулд л энэ Байнгын хороон дээр орж ирж тэгж уншихын тулд л нэг санал хураадаг юм шиг, ажлын хэсгийн үүрэг нь ерөөсөө тэр юм шиг ийм болчихсон сонин, аягүй сонин дэгтэй болчихсон юм байна лээ. Тэгэхдээ Мягмарцэрэн дэгээ тайлбарлаарай. Би яг тийм дэгийн заалт уншаад олж харахгүй байгаа шүү.

Тэгэхээр яах вэ зүгээр саяын Цэнгүүн гишүүний гаргасан санал дээр гишүүдэд нөгөө тайлбар хийж өгөхдөө ойлголтоо яаж ойлгосон талаараа яамныхан хариулчхаарай. Би энийг мартчихаж. Ямар учраас хэдүүлээ дэмжигдээгүй билээ?

Ингээд энэ гишүүний нэрснүүд нь байгаа 3 санал бол гурвуулаа 4 санал байна. Цэнгүүн гишүүний 3, Батнайрамдал гишүүний 1 гээд эдгээр нь энэ 4 санал нь ажлын хэсэг дээр дэмжигдээгүй ийм саналууд гэсэн үг. Агуулгын хувьд нь яамныхан нэг тайлбарлачхаарай. Тэгээд Мягмарцэрэн энэ дэг чинь зөв үү? Ажлын хэсэг гэж байгуулах ямар ч шаардлагагүй юм шиг болчхож байгаа байхгүй юу.

Б.Заяабал: Хуралдааны дэгийн асуудлаар Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Мягмарцэрэн танилцуулга хийнэ. Мягмарцэрэн зөвлөхийн микрофон өгье.

Д.Мягмарцэрэн: Дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйл дээр Байнгын хороогоор анхны хэлэлцүүлэг явуулах тухай асуудал байж байгаа. Энэ дээр гишүүн 39.16 дээр гишүүн холбогдох Байнгын хороонд харьяалагдах эсэхээс үл хамаараад тухайн хэлэлцэж байгаа хуулийн төсөлд энэ хуулийн 4.1.4-д заасан шаардлагыг хангасан зарчмын зөрүүтэй санал ирүүлж болох бөгөөд санал гаргасан гишүүн хуралдаанд оролцсон эсэхээс үл хамааран гаргасан саналыг нь хэлэлцэж санал хураалт явуулна гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл ажлын биш ээ, гишүүн санал гаргавал энэ чинь Байнгын хороонд л гаргаж байгаа санал байхгүй юу. Ажлын хэсэг байгуулах тухай зохицуулалт болохлоор урд нь байж байгаа.

Энэ 37.1 дээр холбогдох Байнгын хороо шаардлагатай бол анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө Их Хурлын тухай хуулийн 24.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслүүдийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж болно гэж байгаа юм. Тэгээд юу яаж байгаа юм, гишүүдийн гаргасан саналыг ер нь дэмжинэ, дэмжихгүй, төсөлд тусгана, тусахгүй гэдгийг ер нь 126 гишүүн хагалж шийдэх ёстой байдаг. Тийм учраас Байнгын хороон дээр ирсэн саналуудыг бүгдийг нь Байнгын хороо дэмжсэн, дэмжээгүй гэж чуулганд оруулдаг. Ийм байхад ажлын хэсэг дээр ирүүлсэн гэдгээр нь гишүүний саналыг шууд нөгөө хураахгүй хасаж болохгүй байгаа.

Б.Заяабал: 9 номерын ажлын хэсэг нэмэлт гишүүний санал дээр нэмэлт тайлбар өгье.

Н.Мөнхбилэг: Цэнгүүн гишүүний асуусан асуултад хариулъя. Үндэсний геологийн албаны дарга Мөнхбилэг. 2006 онд нэг гагийн 145 төгрөг гэж орж ирээд, өнөөдрийг хүртэл энэ дүн хөдлөхгүй явсаар байгаад одоо бид хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирж байгаа юм. Дараагийн удаад нэмэхээр болох юм бол бас л дахиад тодорхой хугацааны дараа хуульд дахиж л өөрчлөлт оруулж өсгөж явах болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг тухайн жилийн, өмнөх жилийн гэж байгаа шүү дээ. Нэг сард зарласан индексээр тогтмол хэрвээ индекс хэдээр өснө тэр хэмжээгээр нь төлбөрийг нь нэмэгдүүлээд явъя, 2006 оноос хойш 20 жил тийм.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүний гаргасан саналаар саналыг дэмжье гэдэг томьёоллоороо санал хураалтаа явуулъя. Санал хураалт. 39,1 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалтын 47.21 дэх хэсгийн “бүртгэж, хяналт тавина” гэснийг “бүртгэнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэнгүүн. Цэнгүүн гишүүнд микрофоныг өгье.

С.Цэнгүүн: Энэ заалт болохоороо 47.21 буюу ийм заалт байгаа юм. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын гэрээг гааль, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны байгууллагын нэгдсэн бүртгэлд бүртгэж, хяналт тавина гэсэн заалт байгаа. Өөрчлөн найруулах санал нь болохоороо ер нь энэ борлуулалтын гэрээнүүдийг бүртгэхэж байгаа юм байна. Тэр нь болохоороо татвараас нуугдах эрсдэлүүдийг багасгах зорилгоор байгаа гэж ойлгож байна. Хяналт тавина гэдэг нь өөрөө аливаа борлуулалтын гэрээ гэдэг чинь 2 компанийн хооронд хийгдэж байгаа бизнесийн арилжааны зарчмаар явж байгаа. Тэгтэл тэн дээр нь очоод татварынхан хяналт тавина гээд байгаа нь өөрөө чөлөөт эдийн засгийн юуг зөрчиж байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр хяналт тавина гэдэг нь ямар хэм хэмжээгээр, ямар хүрээнд хяналт тавих вэ гэдэг нь ойлгомжгүйгээр ийм нэг ахиад төрийн бүтэц гаргаад ирвэл энэ нь давхар ахиад нэг бүртгэл болоод явчих юм. Тэгэхээр бүртгэлээрээ бүртгээд яваг, хяналт тавих гэдэг хэсгийг нь хасъя гэж байгаа юм. Тэгэхээр тухайн ААН-үүд нь татвараа борлуулалтын гэрээнүүдийг нь бүртгэдэг болж байгаа юм байна. Тэр нь ажлын хэсэг тайлбарлах байх. Хамгийн гол нь ахиад хяналт тавина гэчихээр энэ чинь 2 компани хоорондоо хийсэн гэрээг нь төр яагаад хянана гэж, ямар үндэслэлээр юу юун дээр нь хяналт тавих гээд байгаа гэдэг нь ойлгомжгүй байна.

Б.Заяабал: Ажлын хэсэг Дамдинням сайд микрофон.

Г.Дамдинням: Гишүүдийн оройн мэнд хүргэе, тэгээд орой болтол сууж өгч байгаад баярлалаа. Яах вэ энэ нэг ийм юм болоод байгаа юм. Ашигт малтмалын салбар чинь их төвөгшөөлтэй нэг алдаа гарахаар том хэмжээний ингээд хулгай зэлгий алдагдал болчхоод байдаг юм. Одоо нэг ийм асуудал үүсчхээд байгаа юм. Бид АМНАТтай холбоотой их олон маргаан үүсдэг, АМНАТ-аа бүтэн авч чадахгүй болчхоод байгаа юм хянахгүй бол. Яадаг вэ гэхээр гэрээгээ Монгол дотор худалдааныхаа гэрээг хийхдээ хямд үнээр хийгээд, өөрийнхөө хамаарал бүхий компанид хямд үнээр хийгээд, хилийн цаана гаргаад өндөр үнээр дамжуулж зараад АМНАТ-аас зугтаагаад байгаа байхгүй юу. Тийм учраас гааль, татвартай нь хамтад нь бүртгээд хянахгүй бол болохгүй. Хяналт гэдэг нь тулгаж үзнэ, шалгаж үзнэ, АМНАТ-ыг шалгана л гэсэн үг. Ийм л утгаар хийхгүй энэ АМНАТ-аас зугтаагаад байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт нөгөө талд нь шууд эсрэг талд нь ямар асуудал гарчихсан бэ гэхээр гэрээний үнээр хийгээд АМНАТ аваад тооцоод яваад байсан чинь алдаа гараад, их хэмжээний АМНАТ алдаад байгаа байхгүй юу бид авах юм. Тэгэхээр нөгөөдүүлийг чинь болиулаад жишиг үнэ гэдэг рүү тавьчихсан, жишиг үнэ рүү аваачиж тавьчихсан. Тэгэнгүүт одоо энд ямар нөхцөл болох вэ гэхээр баяжуулах үйлдвэрүүд дээр дотоодын борлуулалтын АМНАТ буюу 2 дахин бага үнээр АМНАТ тавиад жишээ нь нүүрс дээр, тэрийгээ цаашаа экспортлоход нь хилээр гарахад нь бүртгэл хийгээд, дутууг нь, АМНАТ-ыг нь нөхөж авах тухай асуудал энд яригдаад байгаа байхгүй юу. Гол нь л тэр юм. Шалгана гэдэг нь энэ 3 байгууллагын мэдээллийг нэгтгэж шалгаж явахгүй бол болдоггүй зугтчихаад байдаг юм. Ийм л асуудал байгаа юм. Тийм. Зөндөө маш их байгаа. Одоо бол тийм, хийсэн юм байхгүй юу. Одоо хийгээд явж байгаа юм. Тэгээд одоо бол бүр аргаа бараад нөгөө тийшээгээ савахаараа хаашаа очоод савчихсан бэ гэхээр 100 төгрөгийн үнэтэй юмыг ингээд АМНАТ-аас зугтаагаад байна гэнгүүтээ 100 төгрөгийн үнэтэй үйлдвэрлэж байгаа юмыг 120 төгрөгөөр үнэлж, АМНАТ авдаг болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр ААН-дээ хохиролтой болчхоод байгаа юм.

Тэгэхээр энийг яг бодит үнээр нь авъя. Тэрийг нь бодит байна уу, үгүй юу гэдгийг нь хянаж байя л гэж байгаа юм. Энэ ер нь ААН-үүддээ ээлтэй заалт юм байгаа юм. Яг үнэндээ бол. Бүртгэлээ хянах ёстой байхгүй юу өөрөө. Тийм хянана, тэгэхээр бүртгэгчхээд хянахгүй бол хянана гэхээр хуулийн байгууллага орчих болчихоод байгаа байхгүй юу, бүүр хүндэрнэ, бүүр хүндэрчхээд байгаа юм хуулиараа. Тэгэхээр энэ чинь татварын байгаа л татвар чинь өөрөө хянах ёстой шүү дээ. Тэр эрх нь байхгүй бол болохгүй л байгаад байгаа юм л даа. Ийм л тайлбар байна даа. Тэгээд яах вэ энэ ашигт малтмал дээр ч яг энэ 3 хэлэлцээрийн дүнг нь аваад хилийн цаана гаргаад өндөр үнээр зараад байгаагаас хянах гээд байгаа юу, үйлдвэр дотоодын үйлдвэрлэлд авна гээд хийчхээд, үйлдвэрлээгүйгээр гаргачих гээд боловсруулалгүй гаргачих гээд байгаа юм энэ явдалтай шүү дээ. Тэгээд энийг нь сайн хянаж байх ёстой байхгүй юу, АМНАТ-аа бүтэн авах ёстой. Бүртгээд, хянаад явахаас өөр аргагүй л болчихоод байгаа юм л даа. Тэгээд яах вэ манай тайлбар ийм л байна. Тийм.

Б.Заяабал: Талуудын тайлбараа хийлээ. Ингээд 2 дугаар санал буюу УИХ-ын гишүүн гаргасан Цэнгүүн гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 34,8 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.35, 4.1.36 дахь заалтын, 10 дахь заалтын 28¹.3 дахь хэсгийн, 28³ дугаар зүйлийн, 16 дахь заалтын 64¹.2 дахь заалтын, төслийн 2 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн, төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7.1 дэх хэсгийн, 2 дахь заалтын 11.1.19 дэх заалтын, 6 дахь заалтын 35.4 дэх хэсгийн, төслийн 4 дүгээр зүйлийн 53.1 дэх хэсгийн “баяжуулалтын” гэснийг “боловсруулалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэнгүүн. Цэнгүүн гишүүн микрофон өгье.

С.Цэнгүүн: Энэ дээр болохоор нэр томъёоны өөрчлөлт оруулах саналтай байгаа юм. Баяжуулалт гэдэг нь болохоор өөрөө яг анхан шатны процесс байгаа технологийн процесс. Тэгэхээр боловсруулалтын болгоод ирэхээр энэ чинь илүү өргөн хүрээндээ ороод ирнэ. Тэгэхээр бид ганц баяжуулалтаар нь орхих биш, бүрэн боловсруулдаг болох ёстой гэдэг агуулгаар нь боловсруулалтын гэдгээр нь нэр томъёог нь томъёолж явсан нь зөв юм болов уу гэж харсан.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Г.Намчинсүрэн: Цэнгүүн гишүүний санал дээр нэмэлт тайлбар өгье. Ашигт малтмалын тухай хууль маань өөрөө эрэл хайгуул, ашиглалт, баяжуулалтын процесс хүртэлх харилцааг л зохицуулж байгаа юм. Аж үйлдвэрийн яамнаас Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулаад явж байгаа. Тухайн хүнд үйлдвэрийн хууль дээр боловсруулалтын асуудлуудыг оруулж ирэх юм. Боловсруулалтын гээд явчихаар өөрөөр хэлбэл бид Зөвшөөрлийн хуульд заасны дагуу тухайн үед 2023 онд энэ асуудлыг танилцуулахдаа зөвшөөрлийн зөвлөл дээр баяжуулалтын зөвшөөрөл гэдгээрээ зөвшөөрлөө аваад Их Хуралд дагалдуулан оруулж ирсэн. Боловсруулалтын гэхээр цар хүрээний хувьд ч болохгүй болчихоод байна. Зөвшөөрлийн зөвлөл дээр ороод танилцуулснаасаа чинь эсрэг болчихоод байгаа юм. Ийм л асуудал болоод байгаа юм. Хүнд үйлдвэрийн асуудал тусдаа өөрөө концепцын хувьд бие даасан хуулиар орж ирэх юм. Тэр үед боловсруулах үйлдвэрлэлийн зөвшөөрлийн асуудлууд дахиад хөндөгдөөд явчих юм.

Б.Заяабал: Талуудын тайлбар өглөө. Ингээд санал гаргасан УИХ-ын гишүүн Цэнгүүний саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 39,1 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалтын 47.5 дахь хэсгийн хүснэгтийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Батнайрамдал. Санал хураалт, санал хураалт явуулъя. Санал хураалт. 17,4 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй.

Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтаа явуулж эхэлье. Ажлын хэсгийн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйлийг хасах:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө олгосон хайгуулын тусгай зөвшөөрөлд Ашигт малтмалын тухай хуулийн 21.1.5 дахь заалт, 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйл хамаарахгүй болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“Оюу толгойн бүлэг ордын хувьд нэмэлт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, батлах хүртэлх хугацаанд зэсэд ноогдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ноогдуулах хувийг доор дурдсанаар ноогдуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн гишүүн Уянга гишүүний микрофон өгье.

Б.Уянга: Энэ саналыг болохоор гаргасан шалтгаан нь ОТ-н бүлэг ордтой холбоотой маш их хэмжээний улс төржилт яваад, тэгээд яг энэнээс болоод бусад төслүүд нь гацах уул уурхайн салбарт хөрөнгө оруулах саарах вий гэдгээс болгоомжлоод Эрдэнэтийн овоо төслийн тийм хэт өндөр татвар төлж байгаа байдал нь олон жил үргэлжилж болохгүй гэдэг үүднээс энэ саналыг томъёолж ажлын хэсэгт оруулсан байсан. Гэхдээ өмнөх саналууд дэмжигдсэн учраас санал хураалгахгүйгээр татаад авчхаж байгаа юм. Тийм.

Б.Заяабал: Санал гаргасан гишүүн саналаа татсан учраас дараагийнхаа санал хураалт руу оръё. УИХ-ын гишүүнээс гаргасан санал.

Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдүүлж тооцох хувийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан УИХ-ын гишүүн Жавхлан. Санал гаргасан Жавхлан гишүүний микрофон өгье.

Б.Жавхлан: Үгүй ээ энэ ингэсэн юм байгаа юм шүү, гишүүдээ анхааралтай байгаарай. Энэ ер нь ёстой нөгөө юуг нь ч тураахгүй, юуг нь ч эцээхгүй, тугалыг нь тураахгүй, нөгөө юу нь цатгалан юу нь бүтэн гэдэг билээ тийм л заалт юм байгаа юм шүү. Батнайрамдал гишүүний санал түрүүн ингээд унасан. Тэгэхээр одоо тэр Батнайрамдал гишүүний яг ярьж танилцуулаад байгаа нөгөө эрсдэлийг бид авч хүндэтгэлтэй хандаж, энэ нэг зохицуулалтыг оруулах ёстой заавал. Тэр үүднээс Уянга гишүүн оруулаад, ОТ-н бүлэг ордын гээд ингээд сугалаад зохицуулалт оруулчихсан байсан. Энэ хууль өөрөө бүгдэд нь эрх тэгш үйлчлэх ёстой гэдэг тэр зарчим алдагдах гээд байгаа учраас Уянга гишүүн тэрийгээ татаад, харин хэрэгжих хугацааг хойшлуулах ийм хугацаа тавьж оруулж ирсэн юм байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө заалт маань 29 оны 1 сарын 1-нээс буюу сонгуулиас хойшоогоо, дараагийн УИХ-ын, дараагийн ЗГ, намрын тэр шинэ чуулган гээд энэ хуулиа зөв буруугаа харж байгаад үргэлжлүүлж ч болно, эсвэл ингээд зогсоож ч болно. Тэр хугацааг нь олгоод бүүр 29 оны 1 сарын 1-нээс гэж байгаа юм.

Тэр хооронд тэр Онтрэ эд нар гээд тэр гэрээ хэлэлцээр юунууд нь бүх зүйл нэг тийшээ болоод ингээд дуусчихна гэж ингэж харж байгаа. Тийм учраас түрүүн хоолны завсарлагын үеэр гишүүдэд хэлж байсан асуудал маань өөрөө энэ юм байгаа юм. 29 оны 1 сарын 1-нээс гээд нөгөө зэстэй холбоотой АМНАТ-тай холбоотой зохицуулалт маань. Тэгээд энэ асуудлаар мөн өнөөдөр хэдийгээр Батнайрамдал гишүүн гадаадад томилолтоор явж байгаа ч гэсэн Дамдинням сайд салбарын сайд гишүүнтэй утсаар ярилцаад, энэ дээрээ ойлголцсон тийм ингэж үзсэн юм байгаа юм. Ингээд ажлын хэсгийн гишүүддээ ингээд нөгөө өглөө ажлын хэсэг хуралдсанаас хойш энэ асуудлуудыг зохих түвшинд ярилцаад ингэж орж ирж байгаа юм шүү. Тэгээд буцаад ямар ажлын хэсгээ хуралдуулаад танилцуулалттай нь биш, зүгээр яах вэ урьдчилсан байдлаар хэсгийн гишүүддээ танилцуулаад, ингээд Байнгын хороон дээрээ санал хураалгаад шийдье гэж оруулж ирж байгаа юм. Томьёоллоо сая уншихсан тийм ээ сая, уншихсан байгаа. Тэгээд энэ дээр санал хураагаад дэмжиж өгнө үү. Батнайрамдал гишүүн ойлголцоод.

Б.Заяабал: Санал гаргасан УИХ-ын гишүүн Жавхлан гишүүний саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Гурав.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Ажлын хэсгийн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд нь биржээр дамжуулан баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж экспортлох зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт олон улсын худалдааны нөхцөлөөр арилжиж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73,9 хувиар уг санал дэмжигдлээ.

Дөрөв.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Зэрэгцүүлж хураалгах санал байгаа юм байна. МУИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 төслийн зүйл, хэсэг, заалт бүр бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээрийн саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэж заасныг үндэслээд ажлын хэсгийн дэмжсэн 1 дэх саналыг Мөнхбаясгалан гишүүний гаргасан саналтай хамт танилцуулж, хураалгая.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Төслийн 2 дугаар зүйлийн “, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэснийг “байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж” гэснийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Мөнхбаясгалан. Дэгийн тухай хуулийн дагуу ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор эхлээд санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Тав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Ажлын хэсгийн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8.32 дахь заалтын “үйл ажиллагаа эрхлэх” гэсний дараах “зөвшөөрөл” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Зургаа.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Ажлын хэсгийн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 59.1.2 дахь заалтын “15” гэснийг “20” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “30 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэснийг “40 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Долоо.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Ажлын хэсгийн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Энэ хуулийн” гэснийг “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт

малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн, горимын санал. УИХ-ын гишүүн Жавхлан уншиж танилцуулна.

22.52 цаг

Арав.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслүүдийг нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Нэгтгэсэн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн танилцуулна. Гишүүний микрофоныг нээе. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 6 сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 6 сарын 11-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Мөн УИХ-ын гишүүн Цогтгэрэл, Жаргалан, Очирбат нарын гишүүд 2026 оны 6 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 6 сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

УИХ-ын даргын 2026 оны 278 дугаар захирамжаар байгуулагдсан Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Энхтүвшин ахалж, гишүүдэд УИХ-ын гишүүн Батбаатар, Зулпхар, Мөнхсоёл, Одбаяр, Пунсалмаа, Пүрэвдаваа, Сайнзориг, Уянгахишиг, Үүрийнтуяа, Цэнгүүн нар болон холбогдох байгууллагын албан тушаалтнууд ажиллалаа. Ажлын хэсэг 3 удаа хуралдсан бөгөөд 6 сарын 24-ний өдрийн хуралдаанаар дараах зарчмын саналуудыг ажлын хэсгийн гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9-д заасны дагуу та бүхэнд танилцуулж байна.

Үүнд 1 дүгээрт, Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн нэгдсэн төслийн нэрийг Эдийн засгийн эрх

чөлөөний тухай гэж өөрчлөх. 2.Нэгдсэн төсөлд хуулийн зорилт эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчмыг тодорхойлох. 3.Нэгтгэсэн төсөлд эдийн засгийн эрх чөлөөг хангах, төрийн бодлого, зохицуулалт, ил тод байдлыг хангах, хянах. 4.төрийн байгууллага, албан тушаалтан, бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчдэд үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог хангах. 5.төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйгээс бизнес эрхлэгчид учирсан хохирлыг төр хуульд заасны дагуу нөхөн төлөх хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх зэрэг саналыг гаргасан болно.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэсэн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Ерөнхий сайдын зөвлөх, Сүхээгийн Тэнгис Ерөнхий сайдын зөвлөх, Ганбаатарын Жавхлантөгс Шадар сайдын зөвлөх, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Жамбалдоржийн Мягмарсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх гэсэн ийм ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн иржээ.

Монгол УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэлэлцүүлгийн явцад 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой юм байна. Ингээд ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалтаа явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Батсүмбэрэл гишүүн. Саналын томъёоллоо уншиж эхэлье.

БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ болон ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН нэгтгэсэн төслийн нэрийг “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Батбаатар, Зулпхар, Мөнхсоёл, Одбаяр, Пүрэвдаваа, Пунсалмаа, Сайнзориг, Уянгахишиг, Үүрийнтуяа, Цэнгүүн, Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэх. Гишүүд санал хураалтдаа оръё. Санал хураалт.73.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

“1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан өмчлөгчийн эрхийг хамгаалах, бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрх, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга өрсөлдөөн, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя гишүүдээ. Санал. Хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 6 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим

3.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангахад дараах зарчмыг баримтална:

3.1.1.хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.бизнесийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх;

3.1.3.төрийн зохицуулалт нь тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байх;

3.1.4.шударгаар олж авсан өмчлөх эрхийг хамгаалах;

3.1.5.бизнесийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх;

3.1.6.хөдөлмөр, оюуны бүтээл, хөрөнгө оруулалтын үр шим, хууль ёсны дагуу олсон орлогоо чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг баталгаажуулах;

3.1.7.хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг бие даан тодорхойлох эрхийг хангах;

3.1.8.хөдөлмөрлөх эрхийг бүрэн хангах, зохистой хөдөлмөрийг дэмжих;

3.1.9.ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бодлого, зохицуулалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулах;

3.1.10.шударга өрсөлдөөнийг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх,

3.1.11.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр шударгаар өрсөлдөх боломжийг хангах;

3.1.12.хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийг байгуулахгүй байх;

3.1.13.төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй байх, бизнес эрхлэгчээс нэг мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.14.нийтийн мэдээллийг хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгож ашиглах боломжийг нэмэгдүүлэх;

3.1.15.бизнесийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээнд суурилсан, давхардалгүй, ил тод, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахад чиглэсэн хяналт шалгалтыг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх;

3.1.16.хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоох үйл ажиллагаанд төр аливаа хэлбэрээр оролцохгүй байх.

3.2.Эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсруулан батлахдаа энэ хуулийн 3.1-д заасан эдийн засгийн эрх чөлөөний зарчмыг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг. 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Эдийн засгийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим гээд 3.1.2 дээр энийг харин манай ажлын хэсгийн гишүүд маань яг юу гэж ойлгох гээд, юу гэж томъёолох гэж оролдсон бол? Энэ бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх гэдэг чинь яг яг юу хэлэх гээд. Түрүүний яаж байсан юун дээр ч нэг ийм юмнууд хураалгагдаж байгаагүй шүү дээ энэ хэн, дэд ажлын хэсэг. Энэ дээр нэг тайлбар хийгээд өгөөч? Бизнесийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх ийм зарчим гэж байх юм уу? Энийгээ нэг эсхүл гүйцээж найруулах ёстой юм уу, яах ёстой юм нэг маш тодорхойгүй юу орж ирж байна шүү дээ бүүр. Тайлбараа өгчхөөч.

Б.Заяабал: Ажлын хэсгээс хариулт өгөх үү? Ажлын хэсгийн 8 дугаар микрофоныг нээе.

Х.Сүрэнхорол: Ажлын хэсгийн хүрээнд энэ саналын томьёолол Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслөөс холбогдох зохицуулалт орж ирсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.3.3 дээр 3.3 дээр хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх гэдэг эрх зүйн зохицуулалт байгаа. Тэгэхлээр тэр зохицуулалтыг эш татаад энэ зохицуулалтыг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл дээрээ зарчим болгож оруулж ирж өгсөн.

Б.Заяабал: Нэмэлт тодруулга минут өгье, Энх-Амгалан гишүүний микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Одоо бид чинь нэг чөлөөлье гээд нэг хууль тогтоомж нь тодорхойгүй байгаа чөдөр тушаа болоод байгаа заалтуудаа л улам энэ бизнесийнхэнд хөрөнгө оруулалтынханд их ойлгомжтой болгоё л гэсэн зарчим барьж байгаа шүү дээ. Тэгээд зарчим дээрээ дахиад нэг ойлгомжгүй хуулийнхаа заалтуудыг дахиад ойлгомжгүй хэлбэрээр оруулж ирээд байх чинь дэвшил юм уу, ухралт юм уу гэдгийг би. Тэрнээс биш хуульд ийм байгаа юм адилхан энийгээ оруулчихъя гэдэг наадах чинь дэвшил биш шүү дээ. Бид нарын чинь зарчим чинь чөлөөлье гэж байгаа биз дээ. Одоо тэртээ тэргүй ойлгомжгүй байгаа хуулиудыг чинь бид 100 хэдэн хуулиудыг чинь дагуулаад энийг чинь ойлгомжтой болгож томьёолж оруулж ирж байгаа шүү дээ зарчим. Энийгээ жаахан гүйцээж боловсруулж яахгүй юм уу энэ чинь нэг тийм энэ чинь угаасаа ойлгомжгүй заалт байхгүй юу байсан байхгүй юу тэр хуульд оруулчихсан байсан байхгүй юу. Энийг санаж байгаа биз дээ бид ярьж байсан юу шүү дээ, тэгээд яг хуучнаар нь эш татаад оруулаад ирэхээр юуных нь дэвшил байх юм тэгээд? Тэгээд зарчим гэж оруулж ирэхээр, энийгээ жаахан гүйцээж, жаахан ойлгомжтой болгож гүйцээн боловсруул л даа ядахдаа.

Б.Заяабал: Та хариулт өгөх юм уу? Ажлын хэсгийн гишүүн Уянгахишиг гишүүн микрофоныг нээе.

Г.Уянгахишиг: Энийг ажлын хэсэг дээр нэлээн их яригдсан юм. Яагаад гэхээр ер нь бид бизнесийн үйл ажиллагаанд ямар ч хязгаарлалт тавихгүй байя гэдгээр жишээлбэл явж болно. Тэгэнгүүт бизнес ерөөсөө хуулийн зохицуулалт яах гэж орж ирдэг вэ гэхээр бусдын эрхээр хязгаарлагддаг гэдэг зүйл байдаг учраас яг ингээд бизнесийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалтууд байх нь байх юм байна. Гэхдээ Хууль тогтоомжийн хуулийн тухай хууль дээр ч гэсэн өмнө нь яг энэ томьёолол яагаад орж ирж байсан бэ гэхээр хамгийн бага байх гэдэг агуулгыг л оруулж ирээд байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл бизнесийн үйл ажиллагаанд хийх хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон боломжит хамгийн бага түвшинд байх буюу хязгаарлалт хийлээ гэхэд тэр юу гэдэг юм хамгийн байж болох бага түвшиндээ байх ёстой шүү гэдэг энэ зарчмыг зарчимд нийцсэн байж, бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийсэн аливаа хууль тогтоомжийн төсөл хэлэлцэгдэх ёстой шүү гэдэг ийм л санаа явж байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн гаргасан томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7.Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, зохицуулалт

4.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

4.2.Өмчлөх эрхийг хязгаарлах шийдвэр, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хууль, хуулиар эрх олгосон байх шаардлагыг хангасан байна.

4.3.Төрөөс үнэ тогтоох, нийлүүлэлтийг хязгаарлах шийдвэр гаргахдаа энэ хуулийн 3.1.2-т заасныг баримтлах бөгөөд аливаа хязгаарлалтыг зөвхөн хугацаатай тогтооно.

4.4.Тухайн жилийн төсвийн тухай хууль болон түүнийг дагаж боловсруулсан хууль тогтоомжоос бусад хууль тогтоомж нь бизнес эрхлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, зардлыг нэмэгдүүлэх бол хууль тогтоомжийн дагаж мөрдөж эхлэх хугацаа нь батлагдсанаас хойш 6-аас доошгүй сарын хугацаатай байна.

4.5.Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн үр дагаварт жил тутам шинжилгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг багасгана.

4.6.Бизнес эрхлэгчийн ашиг, орлого, хөрөнгөд ногдуулах татварыг хуулиар тогтооно.

4.7.Төр нь бизнесийн үйл ажиллагаанаас үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлал, арбитрын болон бусад шүүхийн бус журмаар шуурхай, шударга, хараат бусаар шийдвэрлэх боломжийг дэмжинэ.

4.8.Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломжийг хангасан байна.

4.9.Мэргэжил эзэмших, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн зохицуулна.

4.10.Төсвийн сахилга батыг сахиж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажиллана.

4.11.Төр бизнес эрхлэгчийн зөвшөөрөлтэй эрхэлж байгаа үйл ажиллагааг хэвийн, саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8.Нэгтгэсэн төслийн 7 дугаар зүйлийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл

8.1.Эдийн засгийн эрх чөлөөг хангах төрийн бодлого, үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

8.1.1.үндэсний аюулгүй байдал, хүний үндсэн эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, норм, стандартын баримт бичиг батлан гаргах;

8.1.2.бизнес эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндэд халдах, үндэслэлгүй, хуурамч мэдээлэл түгээх;

8.1.3.бизнес эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулах;

8.1.4.хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхүй гаргах;

8.1.5.энэ хуульд заасан зарчмыг зөрчиж эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлах, эс үйлдэхүй гаргах;

8.1.6.бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, оролцох, үндэслэлгүй хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлах;

8.1.7.бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актад зааснаас бусад баримт бичиг, түүний бүрдлийг шаардах;

8.1.8.бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тогтоосон хугацааг хэтрүүлэх.

8.2.Хувийн өмчийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хураах, дайчлан авах төрийн шийдвэр нь зөвхөн зах зээлийн бодит үнэлгээнд үндэслэсэн нөхөх олговор бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэгжинэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

9.Нэгтгэсэн төслийн 2 дугаар бүлгийн нэрийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ” “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА” гэж өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

10.Нэгтгэсэн төслийн 8 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

11.Нэгтгэсэн төслийн 3 дугаар бүлгийн нэрийг “ГУРАВДУГААР БҮЛЭГ” “ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ” гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.Нэгтгэсэн төслийн 9 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

13.Нэгтгэсэн төслийн 10 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

14.Нэгтгэсэн төслийн 11 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

15.Нэгтгэсэн төслийн 12 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

16.Нэгтгэсэн төслийн 13 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

17.Нэгтгэсэн төслийн 14 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

18.Нэгтгэсэн төслийн 15 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

19.Нэгтгэсэн төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

20.Нэгтгэсэн төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” “ХАРИУЦЛАГА, ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

21.Нэгтгэсэн төслийн 17 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хариуцлага

5.1.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйгээс бизнес эрхлэгчид учирсан хохирлыг төрөөс хуульд заасны дагуу нөхөн төлнө.

5.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

22.Нэгтгэсэн төслийн 18 дугаар зүйлийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Гомдол гаргах эрх

7.1.Аж ахуй эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, эрхийг сэргээх, нөхөн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

23.Нэгтгэсэн төслийн 19 дүгээр зүйлийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөө, шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

6.2.Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой өөрт байгаа мэдээллийг нийтэд тэгш, шударга, хүртээмжтэйгээр хүргэнэ.

6.3.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг хангах талаарх энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

6.4.Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

6.4.2.эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

6.4.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ;

6.4.4.энэ хуулийн 3.1.12-т заасны дагуу үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

6.4.5.энэ хуулийн 6.4.4-т зааснаас бусад төрөөс бизнесийн үйл ажиллагаанд олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ;

6.4.6.эдийн засгийн эрх чөлөөний төлөв байдлын талаарх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

24.Нэгтгэсэн төслийн 20 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

25.Нэгтгэсэн төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ” “БУСАД” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Жавхлан гишүүнийг дэмжсэнд бүртгэе.

26.Нэгтгэсэн төслийн 21 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. 25 дугаар санал дээр Сэддорж гишүүнийг бас дэмжсэнээр бүртгэлд авъя.

27.Нэгтгэсэн төслийн “ЗУРГАДУГААР БҮЛЭГ” “БУСАД ЗҮЙЛ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД” гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн өмнө шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

28.Нэгтгэсэн төслийн 22 дугаар зүйлийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

29.Нэгтгэсэн төслийн 23 дугаар зүйлийг 13 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

10.1.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Ажлын хэсгийн ахлагч Энхтүвшин гишүүний микрофон өгье.

Д.Энхтүвшин: Энэ зүйл заалт, зүйлийг 10 дугаар зүйлийг юу татаж авъя ажлын хэсэг, энгийн горимоор.

Б.Заяабал: Ажлын хэсэг энэ саналаа татаж авснаар ердийн горимоор хууль хүчин төгөлдөр болох нь.

Уг хуулийн төслийг дагаж орж ирсэн хуулийн төслүүдтэй холбоотой санал хураалтуудаа явуулъя. Бизнес эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хоёр.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 2 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэг, 15.9.6 дахь заалтын “Олон улс,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Уянгахишиг гишүүн горимын санал гаргая.

Г.Уянгахишиг: Төхөөрөмж ажилласангүй, санал дахиж хурааж өгнө үү. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин хурааж өгнө үү.

Б.Заяабал: Уянгахишиг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Уг 1 дүгээр саналыг дэмжье гэсэн ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтаа дахин явуулъя. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “хассугай” гэсний өмнө “, мөн зүйлийн 15.9.7 дахь заалтын “, татварын өргүй байх” гэснийг тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 6 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Гурав.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналуудаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “18 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын дугаарыг “7.1.11” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийн “эрх бүхий” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Дөрөв.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд” гэснийг “2024-2034 онд 90 хувиар, 2035-2040 онд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “дагаж мөрдөнө.” гэсний дараа “Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтын өөрчлөлтийг 2041 оны 01 дүгээр сарын 01-ний

өдрийг хүртэл дагаж мөрдөнө.” гэсэн өгүүлбэр нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Тав.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ажлын хэсгээс оруулж ирсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 32 дугаар зүйлийн “дэвшилтэт технологи” гэсний өмнө “газар тариалан,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Зургаа.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.18} дахь хэсгийн “зөвшөөрлийн гэрчилгээг” гэснийг “зөвшөөрлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “25.6 дахь” гэсний өмнө “25 дугаар зүйлийн” гэж нэмж, мөн зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “амьтныг сэргээн нутагшуулах” гэсний дараа “, өсгөн үржүүлэх” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 6 дугаар зүйлийн “хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийн “Бизнесийн” гэснийг “Эдийн засгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Долоо.Арбитрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Найм.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

